



ГАБРИЭЛЬ ГАРСИА

МАРКЕС

АЛДАГДСАН
ЦАГИЙН ТЭНГИС

Габриель Гарсиа Маркес

Алдагдсан цагийн тэнгис

Ирендира охины итгэмээргүй гунигт түүх

Тэр азгүй явдлын салхи сэвэлзэж эхэлж байхад Ирендира эмэг эхээ усанд оруулж байлаа.

Тэдний амьдардаг доошоогоо суун яйжийсан, зэвхий бетонон

байшин элсэн цөлийн эзгүйд сүүдийх бүлгээ. Хэдий Ирендира болон эмэг эх нь байгалийн эрхшээл доор байгаа ч элдвийн тогосын өд, өнгө өнгийн шигтгэмлээр эрээлсэн энэхүү Ром маягийн угаалгын өрөөнд гадаа догшрох салхийг бараг үл анзаарах авай. Гантиган ваннан дотор чармай шалдан бүдүүн эмэг эх цагаан халим мэт ажээ. Ач охин дөнгөж арван дөрөвтэй агаад ийм насных гэхэд дэндүү туниагүй турьхан харагдана. Тэрбээр эмэг эхээ анхилуун навчис, үндэс буцалгасан усаар ямар нэгэн шашны зан үйл гүйцэтгэх мэт нямбайлан угаах агаад бандгар тарган ууц, төмрийн өнгөт үс гэзэг, усан цэрэг ч зовмоор элдвийн ичгүүргүй шивээс бүхий хүчирхэг бүдүүн мөр сэлтийг нь арчиж байлаа. Би урд шөнө захидал хүлээж байна гэж зүүдэллээ хэмээн эмэг эх өгүүлэв. Ирендира зайлшгүй үед л дуугардаг бөгөөд зүүдэнд чинь ямар өдөр байсан бэ гэж асуулаа.

-Пүрэв гариг

-Тэгвэл муу мэдээтэй захидал байж. Гэхдээ хэзээ ч ирэхгүй.

Ирендира эмэг эхээ усанд оруулсны дараа унтлагынх нь өрөө рүү аваачлаа. Эмэг эх нь дэндүү тарган тул нэг бол ач охиныхоо мөрийг түшиж, эс бөгөөс сүмийн хамбын тэргэнцэр шиг зүйл тулж байж л биеэ зөөх чадвартай ажгуу. Хэдий тийм боловч энэхүү эрт галвын музейн үзмэр болмоор эмгэн маш их чадал тэнхээтэй хэвээрээ байлаа.

Ирендира дэндүү хэтэрхий, галзуу солиотой мэт эрээлж мяраалсан унтлагын өрөөнд дахиад хоёр цаг ажиллах ёстой.

Тэр эмгэний гэзгийг задлан, анхилуун сүрчиг цацаад дахин сүлжиж, бүсэлхийгээрээ цэцгэн хээтэй хувцсыг нь өмсүүлэн, тод улаан будаг уруулд нь түрхэж, хацрыг нь энгэсэгдээд зовхийг нь хүдрийн заараар будан хөлийнх нь хумсыг маажиндах бүлгээ.

Ийнхүү тэрбээр энэхүү асар том хүүхэлдэй мэт амьтныг тоноглож дуусгаад эгээ л хувцсыг нь чимсэнтэй адилхан дотор бачуурам хиймэл цэцэгс бүхий цэцэрлэг рүү аваачин, бүгдхэн шажигнах бягтруулын бичлэг сонсгохоор удмынх нь хүндэт суудал болох том буйданд суулгалаа. Эмэг эх улирсан баларсан дурсамжийнхаа мананд хөвж байх зуур Ирендира этгээд марзан тавилга, рыцарийн баримлууд болон нулимсан дусал хэлбэртэй гэрлийн бүрхүүл, өнгөлж будсан төгөлдөр хуур, гипсэн сахиусан тэнгэрүүд, ухаан гүйцэмгүй олон төрөл, хэмжээтэй цагнууд зэрэг хэрэгтэй хэрэггүй новш дүүрэн хөглөрсөн харанхуй байшинг шүүрдэж гарав.

Гадаа хашаанд тэртээ индианчуудын нутгийн булгаас ус зөөж хадгалах том торх байх агаад уг савны бөөрөнд үүрэлж авсан тахир доголон тэмээн хяруул болбол энэхүү хахир хатуу цөлийн цаг агаарыг давж амьд үлдсэн цорын ганц жигүүртэн ажгуу.

Байшин бүхнээс хол, цөлийн тэхий дунд байх бөгөөд зэргэлдээ нь орших уугин манарч байдаг нэвсгэр балгаснуудын дээрээс цөлд ганцаардан ганихарсан ямаанууд үсрэн амиа егүүтгэдэг болой.

Энэхүү нууцлаг оромжийг эмгэний нөхөр, хил давуулагч хулгайн домогт наймаачин Амадис байгуулсан ажээ.

Тэр хоёрын ганц хүү бас л Амадис нэртэй байсан бөгөөд энэхүү Ирендирагийн аав юмсанж.

Энэ гэр бүлийн гарал үүсэл, хүсэл зоригийг мэдэх гадарлах нэг ч амьтан байхгүй юм.

Индианчуудын яриагаар бол эцэг Амадис нь өөр нэгэн эрийг хутгалж алан байж, Антилла дахь янхны газраас үзэсгэлэнт эхнэрээ олж аваад энэхүү цөлийн гүнд нууж орхисон гэдэг билээ.

Эцэг хүү Аматисуудыг нас барсны хойно хүүхнийг булаацалдсан хоёр эр биенээ буудаж хөнөөсөн бөгөөд эмэг эх тэднийг цэцэрлэгтээ булж орхиод, хөл нүцгэн 14 үйлчлэгч охидыг хөөж явуулаад төрснөөс нь хойш үзэж чаддаггүй бутач ач охиноо зарцлан, энэхүү нууцлаг байшиндаа эзэн хатагтайн дүрд үнэмшин дэмийрч суудаг болсон авай.

Ирендира бүх цагийг тааруулж түлхэхэд зургаан цаг зарцуулдаг байв. Харин тэр азгүй өдөр охин бүх цагийг маргааш өглөө хүртэл явахаар түлхсэн байсан тул уг ажлыг хийгээгүй боловч эмэг эхээ усанд оруулах, хувцаслах, шал угаах, хоол бэлдэх, болор эдлэлүүдийг арчих гээд бөөн ажил амжуулжээ. Түүнийг арван хоёр цагийн үед цацагт хяруулын уух усыг сольж, Аматисуудын булшны шарилжийг услах үед хүчтэй шуурга дэгдсэн нь тэр азгүй явдлын эхлэл байсныг охин яахин мэдэх билээ.

Ирендира арван хоёр цаг гэхэд хар шөл чанахын хажуугаар болор тавагнуудыг өнгөлж байв.

Охин буцалж буй шөлний тагийг хэлтгий тавиад гал зуухны сандал дээр суун түр амсхийж авлаа.

Тэр нүдээ аньснаа буцаан нээгээд шөлөө таваглалаа. Охин яг л унтаж буй мэт харагдах аж. Эмэг эх лааны арван хоёр мөнгөн суурь зоосон баярын ширээний эхэнд залрах бүлгээ. Түүнийг бяцхан хонх цохингуут Ирендира шөл барьсаар даруй орж ирэв. Ирендира шөл аягалахдаа харц нь зүүдэлсэн хүн шиг үзэгдэхийг эмэг эх ажаад өмнөө байгаа шилийг арчих мэт гараа зангав. Гэвч охин түүнийг нь мэдсэнгүй. Эмэг эх охиныг дагуулан харж байснаа гал зуух руу эргээд явахад нь:

-Ирендира! хэмээн хашгирлаа.

Гэнэт сэрсэн охин шөлөө хивсэн дээр унагааж орхиход:

-Зүгээр зүгээр хүү минь! хэмээн эмэг эх дуугараад чи явж байхдаа л унтчих юм аа хэмээн үргэлжлүүлэв. Би ингээд сурчихжээ хэмээн Ирендира уучлал гуйсан өнгөөр хэлээд нойрмог хэвээр хивсний толбыг арилгаж эхэллээ.

Орхи, орхи! Чи наадахаа өглөө цэвэрлээрэй гэж эмэг эх өгүүллээ.

Ирендира дээр дурьдсан өглөө болгоны ажлуудаас гадна хоолны өрөөний хивсийг цэвэрлэнгээ нэгэнт угаалгын өрөөнд ирснийх даваа гаригийнхаа угаалгыг ч хийж авлаа.

Энэ үед гадаах шуурга байшинг тойрон эргэлдэж байлаа.

Охин тийнхүү өдөржин борви бохисхийлгүй хөдөлсөөр хоолны өрөөний хивсийг буцааж байрлуулах үедээ шөнө болж унтах цаг дөхсөнийг ч мэдсэнгүй. Эмэг эх үдээс хойшжин төгөлдөр хуур нүдэн залуу цагийнхаа дуунуудыг хоолойгоо шахан орилсон агаад заарь түрхсэн зовхи нь нулимсандаа халтартсан байлаа. Харин тэр унтлагын шаа торгон хувцсаа эгэлдэргэлсээр орондоо орохдоо энэ цаг үедээ эргэн ирэх мэт болоод, маргааш том өрөөний хивсийг нэгмөсөн угаачихаарай, нар салхи үзэлгүй хичнээн удав даа хэмээлээ.

-За тэгье! Эмэг ээжээ хэмээн ач охин хариуллаа.

Охин өдөн дэвүүр авч энэхүү хатуу харгис бэлэвсэн эмгэнийг сэрүүцүүлэх зуур цаадах нь нойрондоо авгах зуураа шөнө хийх ажлыг нь үүрэгдэн тоочих аж.

-Орондоо орохынхоо өмнө бүх хувцсыг индүүдчихээрэй!

-За эмэг ээжээ!

-Өлгөөтэй хувцсыг сайн шалгана шүү. Цагаан эрвээхэй ийм салхитай шөнө улам олон болдог юм.

-За эмэг ээжээ!

-Чамд цаг байгаа болохоор цэцэгнүүдийг салхинд гаргаж тавиарай.

-За эмэг ээжээ.

-Аа тийм. Тэмээн хяруулаа хооллоорой.

Эмгэн хэдий унтчихсан ч үүрэгдсээр байх агаад энэ нь ач охин унтаагаараа ажлаа амжуулдагтай төстэй ажгуу. Ирендира өрөөнөөс чимээгүйхэн гараад энэ шөнийн хувьд төгсгөлийн ажлуудаа оролдох зуураа эмгэний үгэнд ч хариулт өгч байв.

-Булшийг услаарай!

-За эмэг ээжээ!

-Хэрэв Амадисууд ирвэл битгий орж ир гэж хэлээрэй. Портфино Голаны бүлэг алах гээд отож байна.

Ирендира үүнд хариулсангүй. Яагаад гэвэл эмгэн одоо бол дэмийрч эхэлж байгааг тэр мэдэж байлаа. Тэрээр цонхнуудын түгжээг шалган, гэрлүүдийг унтрааж лаа барьсаар өрөө рүүгээ

зүглэхэд эмэг эхийнх нь амьсгаадан унтах л сонсогдож байв.

Охины өрөө эмэг эхийнхийг гүйцэхгүй ч бас ч гэж тохилог, даавуун хүүхэлдэй, чихмэл тоглоомоор дүүрэн аж.

Өдөржингөө хүнд хүчирт зүтгэсэн Ирендира лаагаа ширээн дээр тавиад хувцсаа ч тайлж чадалгүй нойрондоо цохиуллаа.

Төд удалгүй гай дагуулсан салхи бүлэг тайган ноход мэт өрөөнд улилдан орж ирээд лааг хөшигний дор унагалаа.

Үүрээр шуурга намдаж, байшингийн шатсан нурман дээр ганц нэг бороо дуслан хяравас ханхлуулж байлаа.

Индианчууд голдуу тосгоныхон түймрээс хоцорсон төгөлдөр хуурын хүрээ, цацагт хяруулын түлэнхий сэг, цээж баримлын толгой мэтийг аврахыг оролдож байлаа.

Харин эмэг эх цаашид яах тухайгаа дүнсийн бодлогоширч байлаа.

Хоёр Амадисийн булшны хооронд мэгшиж суусан Ирендира уйлахаа зогсоов. Эмэг эх нуранги дотор хэрэгтэй юм бараг үлдээгүйг үзээд ач охиноо харан өрөвдөнгүй дуугаар:

-Ээ дээ охин минь! Үүнийг надад төлөхөд чиний нас хүрэхгүй нь дээ гэлээ.

Нээрээ ч охин тэр өдрөө бороо ч намдаагүй байхад эхний төлбөрөө хийж эхлэв.

Түүнийг тосгоны мухлагийн эзэн болох өндөр туранхай эр рүү аваачив. Сайхь хүн бол охидын онгон хальсанд их үнэ төлдгөөрөө зартай эр юм санж. Эмэг эхийг шийдвэр төгс хүлээх зуур мань эр Ирендираг шинжлэх ухаанчаар шалгаж эхлэв. Тэр гуя хасыг нь барилан үзэж, хөхнийх нь хэмжээ, бүсэлхийнийх нь тойргийг хэмжин, охин ямар үнэ хүрэхийг тооцоолон бодтолоо нэг ч үг дуугарсангүй.

Тэгж тэгж энэ охин үнэхээр түүхийгээрээ юм байна. Яг л жингэр шиг мээмтэй юм хэмээсэн авай.

Дараа нь Ирендираг жигнэхэд 40 кило татаж байв. Нэг зуун песогоос илүү гарахгүй нь хэмээн бэлэвсэн эр хэллээ.

Эмэг эх хилэгнэж эхлэв. Цоо шинэ, бүрэн бүтэн охин зуухан песо байдаг гэнэ ээ хэмээн тэр бараг хашгираад, үгүй ээ ноёнтоон энэ бол таныг шударга ёсыг хүндлэхгүй байгааг харуулж байна хэмээлээ.

-За яахав. Зуун тавь болгоё.

-Энэ охин надад сая песогийн хохирол үзүүлсэн. Ийм үнээр бол өрөө хоёр зуун жил төлөх юм байна л даа.

-Харин ч та ийм сайхан охинтой байгаа нь азтай хэрэг.

Гадаа дэгдэх шуурганд байшин чичигнэх агаад дээвэр нь шүүр шанага болсон тул дусаал гоожин эгээ л гадаа байгаа юм шиг ажээ. Эмэг эх гамшиг зовлонгийн дунд ганцаардаж байлаа. Ядаж гурван зуу болгож өсгө л дөө хэмээн тэр хэллээ.

-Хоёр зуун тавь

Эцэст нь тэд хоёр зуун хорин песо бэлнээр, үлдсэнийг нь хоол хүнсээр өгч авалцахаар тохиролцов.

Дараа нь эмэг эх Ирендирад дохио өгч, бэлэвсэн эр түүнийг сургуульд хүргэж яваа юм шиг гараас нь хөтлөн хойд өрөөндөө авч оров.

-Би чамайг энд хүлээж байя хэмээн эмэг эх хэлэв.

-За эмэг ээжээ.

Арын өрөө нь дөрвөн тоосгон багана, далдуу модны ялзарсан навчаар хучсан дээвэр бүхий оромж байв.

Тоосгон багануудын хооронд завины сул залуур мэт дайвалзах хуучин муу дүүжин ор байх аж. Гадаа ус цалгих, салхи исгэрэхээс гадна тэртээ хол амьтан улилдах, усан онгоцны хэмхэрхий харжигнах нь сонсогдох авай.

Ирендира, бэлэвсэн эр хоёр арын өрөөнд ороод дээврийн дусаалд өртөхгүйн тулд хэсэг зогссон ч сүүлд тэртэй тэргүй норцгоосон билээ.

Ирендира эхлээд дуу гаргалгүй шүд зуун эсэргүүцэж, бэлэвсэн эрээс зугтахыг оролдсон ч цаадах нь мөн л дуу шуугүйгээр хоёр гарыг нь ард нь зөрүүлэн бариад дүүжин орруугаа чирч аваачлаа.

Охин мөн л дуугүй тэмцэлдэн нүүрийг нь самардсан ч бэлэвсэн эр түүнийг сурмагаар өргөж хөлийг нь сарвалзуулан газраас хөндийрүүлэхэд урт гээг нь агаарт хийсч байлаа. Тэр охины хөлийг газарт хүрч ядах үед бүсэлхийгээр нь тэврэн дүүжин орон дээр цээжээрээ даран унаж, өвдгөөрөө хөлийг нь хумилаа.

Ингэсний хойно Ирендира эзэрхийлэлд бууж өгөн ухаан нь бүүдийж, агаарт хөвөх загас сарны туяанд орох мэт мэдрэмж төрөөд цаашаагаа мэдэхээ болив.

Харин бэлэвсэн эр түүний хувцсыг сурмагаар тайчин, хадсан өвсийг салхинд цацах мэт шидэлж байлаа.

Ирендираг өвөртлөн мөнгө тоолох тосгоны эрчүүдийн тоо дууссан тул эмгэн охиныг ачааны тэргэнд суулган хил давуулан хулгайгаар наймаа хийгчид рүү авч явлаа.

Тэр хоёр будаатай хүүдий, хувинтай өөх болон түймрээс үлдэж хоцорсон эд хогшил болох

орны хавгас, цэргийн жанжин-сахиусан тэнгэр, хааны түлэнхий титэм мэтийн хэнд ч хэрэггүй хог новшин дунд ил суун зорчиж явлаа. Мөн хэрээс дүрсэлсэн чиргүүлэнд хоёр Амадисийн араг ясыг хийсэн байв. Эмэг эх салбархай шүхрээр нар халхалсан боловч тоос шороонд хөлстэйгээ хутгалдан амьсгалахад бэрх байдалтай байв. Ийм боловч мань эмгэн ихэмсэг байдлаа хадгалсаар явах авай. Харин Ирендира будаатай лааз, хүүдийнүүдийн ард энэхүү аялал, тээврийн үнийг төлөхийн тулд ачааны машины ачигчтай нэг удаа 20 песо авах болзолтойгоор загас наадуулж байв.

Охин эхлээд бэлэвсэн эртэй үзэлцдэг маягаараа өөрийгөө хамгаалах гэсэн боловч ачигч арга эвээр оролдон оролдсоор охиныг зөөлрүүлэн номхруулж авчээ.

Тэд тийнхүү явсаар анхны тосгонд хүрч очихын үед Ирендира ачигч хоёр ачааны ард ээлжит жаргалаа шавайгаа ханатал эдэлж аваад тарайн хэвтэцгээж байсан амой.

Ачааны тэрэгний жолооч эмэг эхэд хандан, за одоо л нэг амьд амьтны бараа харлаа даа хэмээн хашгирлаа.

Эмэг эх сая орхин гарсан тосгоноос нь арай том мэт боловч эгээ л ижилхэн өнгө зүсгүй, ноорхой гудамжнуудыг үл итгэсэн байдалтай ажиглав. Сайхан харагдахгүй л байх чинь хэмээн түүнийг хэлэхэд, энэ бол шашин номын нутаг даа гэж жолооч хариуллаа.

Би өглөг үйлдэх гээгүй, надад дамын наймаачид л сонин байна хэмээн эмэг эх өгүүллээ. Ирендира арын тэвшнээс ийн ярилцахыг сонсох зуураа будаатай хүүдий рүү гараа шургуулбал ямар нэгэн хатуу зүйл тэмтрэгдлээ. Гаргаад иртэл үнэт сувдан шигтгээ бүхий хүзүүний зүүлт байх нь тэр.

Охин өнөөх зүүлтийг үхсэн могой мэт хуруундаа хавчуулан мэлэрлээ. Энэ зуур жолооч, эмэг эх хоёр ярилцсаар байв.

-Хатагтай! Сэрүүн зүүдээ боливол яасан юм. Энд дамчид байхгүй дээ.

-Тийм шиг байна. Таны үгийг хүлээж авья.

-Хүн болгон л тэдний тухай ярьдаг юм. Гээд үзсэн хүн л байдаггүй юм даг. Ирендира хүзүүний зүүлтийг авч зүрхлэлгүй будаатай хүүдий рүү буцаан шургуулахыг ачигч харчихав.

Эмэг эх тосгон хоосон ядуу ч үлдэхээр шийдэн тэрэгнээс буух болж ач охиноо туслуулахаар дуудлаа. Ирендира ачигчид хандан яаруу боловч үнэн сэтгэлээсээ баяртай хэмээн дотночлон үнссэн болой.

Эмэг эх гудамжны голд ямбалан сууж ачаа буулгаж дуусахыг хүлээлээ. Сүүлийн ачаа нь Амадисуудын үлдэгдэл бүхий чемодан боллоо. Хүнд гэж үхсэн хүний жинтэй байх чинь хэмээн жолооч инээн өгүүлэхэд наана чинь хоёрын хоёр хүн байгаа юм, хүндэтгэлтэй хандах хэрэгтэй хэмээн эмэг эх намжирдав.

Энэ хоёр өмнө нь гантиг хөшөөнүүд байсан байх аа хэмээн жолооч дахин инээд алдлаа.

Жолооч араг яс бүхий чемоданыг тавилга хогшлын дунд эвгэйхэн тавиад гараа тослоо.

-Тавин песо

-Чиний дагуул чинь авчихсаан хө!

Жолооч ачигч руугаа тээнэгэлзэнгүй харвал цаадах нь тийм гэсэн янзтай толгой дохив. Жолооч халууцан чарлах хөхүүл хүүхэд тэвэрсэн эмэгтэй явахаар суусан тэрэг рүүгээ буцаж очлоо.

Ачигч эмэг эхэд хандан тун итгэлтэйгээр, таныг зөвшөөрвөл Ирендира надтай хамт яваг. Би сайхан сэтгэлээр л хандана хэмээн өгүүлэв. Охин уулга алдан, би тэгж хэлээгүй шүү хэмээхүй, тийм ээ энэ бол миний санаа гэж ачигч дуугарав.

Эмгэн болгоомжилсондоо бус харин үнэн хүслийг нь тэнсэхийн тулд ачигчийн хөлнөөс толгой хүртэл харлаа.

Тэгснээ, наадахын чинь хайхрамжгүйгээс болж надад учирсан хохирлыг төлбөл зөвшөөрч болох л юм хэмээгээд нийтдээ бол найман зуун далан хоёр мянга гурван зуун арван таван песо байгаа юм. Гэхдээ наадах чинь дөрвөн зуун хорийг нь төлчихсөн тул эцсийн дүн нь найман зуун далан нэгэн мянга найман зуун ерэн таван песо болно доо гэлээ.

Ачааны тэрэгний хөдөлгүүр дуугарлаа.

Хэрвээ би ийм их мөнгөтэй байсан бол өгөх л байсан. Ийм охины төлөө юм чинь хэмээн ачигч үнэн сэтгэлээсээ өгүүлэв.

Эмэг эх хүүтэй санал нэг байлаа. Тэрээр, хүү минь мөнгөтэй болоод эргээд ирээрэй хэмээн уриалгахан дуугараад, гэхдээ одоо яв. Дахиад тооцоо хийвэл чи арван песоны өрөнд орно шүү хэмээв.

Ачигч тэргэндээ үсрэн суугаад явж одов. Тэр хөдлөхдөө Ирендирад хандан гараа дохисон ч цаадахь нь мэл гайхсан хэвээр хоцорлоо.

Эмэг эх, ач охин хоёр ачааны тэрэг зогсож байсан газарт дорнын хивсний үлдэгдэл, ор хөнжлийн даавуу ашиглан оромж барьж авав. Тэгээд газраар хоёр гудас хаяад оромжны цоорхойгоор нар тустал унтацгаалаа.

Маргааш нь урьдынхаас шал өмнөө юм болсон нь эмэг эх Ирендираг додомдсон явдал болов. Тэрээр охины нүүрийг өөрийнх нь залууд моод болж байсанчлан сүнсний маягаар будан хиймэл хумс углуулж, үсэнд нь цацаг бүхий шаа торгон бүч зүүсэн нь эрвээхэй мэт үзэгдэх ажээ.

Чи ч нүдний булай шиг харагдаж байна хэмээн эмэг эх дүгнэснээ гэхдээ ингэсэн нь дээр. Тэртэй тэргүй эрчүүд эмэгтэйчүүдийн тал дээр шал тэнэг улс даа хэмээсэн бүлгээ.

Тэр хоёр цөлийн хярхагт торолзох хоёр луусыг үзэхээсээ өмнө дууг нь сонслоо. Ирендира

Эмэг эхийн заавраар хөшиг нээгдэхийн өмнөх тачаангуйн дүрийн жүжигчний маяг харуулан хэвглээ.

Эмэг эх тэргэнцрээ тулан аахилсаар гадаахь сандалд хүрч аваад лууснуудыг дөтлөхийг хүлээв.

Шууданч ирж явсан хэрэг аж. Энэхүү шууданч болбоос дөнгөж хорьхон настай ч ажилдаа нухлуулсанаас оворжуу харагдах агаад хамгаалалтын өнгөт комбинзон, урт оймс өмсөн, дуулга духдуулж, дайзтай бүсэндээ гар буу зүүжээ.

Мань хүн эмгэний хажуугаар өнгөрөхдөө гараа дохин мэндэлбэл цаадах нь оромж руу шагайн харахыг санал болгон гараараа зангалаа.

Шууданч зогсоод гудсан дээр богино ягаан банзал өмсөн хэвтээ Ирендираг олж үзлээ.

-Чамд таалагдаж байна уу? хэмээн эмэг эх асуулаа.

Цаадах нь өмнөө янхан хэвтэж буйг удаж удаж нэг юм ойлгоод турах гээд хоолоо сойсон хүнээс дээр л харагдаж байна хэмээн хошигнохоо аядав.

Тавин песо хэмээн эмэг эх хэлэв.

Пөөх! Та чинь эрдэнэсийн сан шаардах нь уу. Энэ чинь миний бүтэн сарын хоолны мөнгө байна хэмээн шууданч өгүүллээ.

-Битгий нарийл л даа. Буухиа шуудангийнхан лам нараас ч илүү мөнгө авдаг биз дээ.

-Би буухиа биш дотоод шуудангийнх. Буухиагийнхан машинаар явдаг юм.

-Ямар ч байсан секс хоол шиг л чухал зүйл дээ хө.

-Гэсэн ч энэ чинь хоол болохгүй биз дээ.

Эмэг эх шууданч тийм ч амар мөнгөө өгчих эр биш гэдгийг ойлгоод, чи ер нь хэдэн песотой хүн бэ гэлээ.

Шууданч лууснаасаа бугаад халааснаасаа хэдэн үнгэгдсэн халтар мөнгөн дэвсгэрт гаргаж ирснийг нь эмгэн элээ мэт шүүрэн авлаа. Тэгснээ, за яахав чамд гэж үнээ буулгалаа. Гэхдээ энэ талаар хаа сайгүй зар тараах нэг болзолтойгоор шүү хэмээлээ.

Хорвоогийн хязгаарт ч хэл хүргэж чадна. Миний ганц чаддаг ажил хэмээн шууданч эр өгүүлвэй.

Ирендира нүд цавчихад нь тороод байсан хиймэл сормуусаа авч хаяад хархүүд зай гарган цааш хэвглээ.

Энэ бол тун ч ашигтай хэлцэл боллоо.

Шууданчаас сураг сонссон алс холын эрчүүд Ирендирагийн залуу бие цогцсонд шунан цувж эхлэв. Бас эрчүүдийн араас тоглоомын ширээ, хоолны лангуу бий болж, эцэст нь алс холын отрын нутгаас нэгэн гэрэл зурагчин ирж, гурван хөлт зургийн аппарат, тоо томшгүй хун бүхий нуурын зурагтай арын самбараа зоож авсан бүлгээ.

Эмэг эх сандал дээрээ залран энэхүү зээлийн газраа хачирхсан мэт харан суух ажгуу.

Эрчүүд дарааллаа баримтлан, Ирендира руу орохын өмнө ягштал тааруулсан мөнгөө төлж байх нь л түүнд сонин байв. Эхэндээ тэр тун хатуу загнан таван песо дутаасан үйлчлүүлэгчдийг ч халгаахгүй байсан билээ.

Гэвч өдөр сар өнгөрөхөд эмгэн бодит байдалтай эвлэрч, шашин мөргөлийн тэмдэг, гэр бүлийн шүтээн, хуримын бөгж зэргийг төлбөрт авдаг болсон ажгуу.

Эмгэн ийнхүү анхны тосгонд нилээд удаж илжиг худалдаад авчих мөнгөтэй болж аваад өрөө хурдан төлүүлэх өөр газрын эрэлд мордон хөдөллөө. Тэр илжигний нуруунд дэвссэн сүрэл дээр суун явах агаад Ирендирагийн барьсан шүхэр түүнийг цөлийн халуун нарнаас халхлах ажгуу. Араас нь унтлагын гудас засч тордсон сандал, сахиусан тэнгэрийн гипсэн баримал мэт болон Амадисуудын араг ястай чемоданыг үүрч дүүрсэн хөл нүцгэн дөрвөн индиан дагалдах бүлгээ.

Тэд нь отроос хаягдаж хоцрогсод ажээ. Харин гэрэл зурагчин мөн бараадан дагалдах боловч хэзээ ч нийлэхгүй тусдаа яваа мэт царайлах ажээ.

Гал түймрээс хойш зургаан сарын дараа эмэг эх ажил хэргээ дүгнэж цэгнэлээ. Тэрээр Ирендирад хандан, хэрэв энэ янзаараа бол чи найман жил, долоон сар, арван нэгэн өдөр зүтгэж байж л өрөө төлөх юм байна даа хэмээн мэдэгдлээ.

Эмэг эх мөнгө хадгалдаг цүнхнээсээ ургамлын үр гарган цааш нааш нь тавин дахин тооцоо хийж сууснаа, энэ индианчуудын болон бусад жижиг зардлуудыг тооцохгүйгээр ийм байна хэмээн залрууллаа.

Илжиг даган нар, тоосонд шаналан гэлдрэх Ирендира дээрх тооцоотой маргасангүй, нулимсаа л дэмий цааш залгилаа.

-Миний яс янгинаад байна, эмэг ээжээ!

-Тэгвэл унтахыг бодохгүй юу

-За эмэг ээжээ

Охин нүдээ анин лүгхийм халуун агаараар гүнзгий амьсгалаад алхаа чигээрээ унтаж эхэллээ.

Дээрээ сараалжин тор ачсан ачааны жижиг тэрэг Сан Мигель Дисерто хэмээх энэ газрын нам гүмийг эвдлээ. Уг тэрэгнээс зээр, гөрөөс дайжин, шувууд цочин орилолдох ажээ.

Жолооных нь ард өвөг дээдсээсээ уламжилсан алаг сахал бүхий дани фермер эр суух бөгөөд

энэхүү мяраалаг эрийн нүүр нар, салхинд холцруутжээ.

Түүнтэй нуур тэнгис мэт ганцаардангуй гүн нүдтэй,сахиусан тэнгэрийн битүүлэг төрхтэй хүү Уллис нь хамт зорчин явах аж.

Дани эр майхны өмнө орон нутгийн гранизоны цэргүүд дугаарлан зогсоог үзээд энд ямар элэнцгээ наймаалцдаг байна аа гэлээ.

Хүүхэн хэмээн хүү Уллис нь хариулаад нэрийг нь Ирендира гэдэг юм гэлээ.

-Чи яаж мэдээв?

-Энэ цөлд хүн болгон л мэдэж байгаа шүү дээ.

Дани эр тосгоны нэгэн жижиг буудлын дэргэд зогсон тэрэгнээсээ буухад Уллис суусаар хоцорлоо. Тэр аавынхаа суудал дээр орхисон цүнхийг сурмаг уудлан багц мөнгөн дэвсгэрт халааслаад цүнхийг урьдын янзаар болголоо.

Уллис мөн тэр шөнөө аавыгаа унтсан хойно буудлын цонхоор гарч одоод Ирендирагийн майхны өмнө очин дугаарлалаа.

Зугаа цэнгэл ид үедээ орж байв. Халамцуу цэргүүд бүжиглэлдэж, гэрэл зурагчин тусгай цаас ашиглан шөнийн зураг татах аж. Эмэг эх бизнесээ бөөцийлөх зуур гар дахь мөнгөн тэмдэгтүүдээ толгойлон сагсанд хийж байв.

Уг нь тэнд ердөө 12 цэрэг үлдсэн байсан ч орой нь энгийн иргэд-үйлчлүүлэгчид ч нэмэгдсэн ажээ. Уллис дарааллын хамгийн сүүлд нь зогсч байлаа.

Тэнд байгсдын дотор байсан аймаар зэвүүн царайтай цэргийн орох ээлж болов. Гэтэл эмэг эх түүний замыг нь хаан хөндөлссөнөөр үл барам мөнгөнд нь ч хүрэхээс цэрвэлээ. Тэр түүнд хандан,үгүй хүү минь дэлхийн бүх алтыг төлсөн ч чамайг оруулшгүй нь. Чи аз хариулах хүн байна хэмээв.

Цэрэг, та юу гээд байна аа гэж гайхлаа. Чи буг чөтгөрийн бузар авчрах хүн байна. Царайг чинь харваас андашгүй хэмээн эмэг эх хэллээ.Тэгээд мань цэргийг гараараа занган хөөгөөд дараагийн хүн рүү дохилоо.

Царайлаг хархүү минь ор ор. Гэхдээ удаж болохгүй шүү.

Ардаа ажилтай улс хэмээн эмгэн хэлсэн авай.

Цэрэг майханд ороод төдөлгүй буцан гарч ирлээ. Учир нь Ирендира эмэг эхтэйгээ ярилцахыг хүссэн аж.

Эмгэн багц мөнгөө атгасаар том биш боловч цэвэр цэмцгэр майханд явж ороход эрчүүдийн хөлс, хирэнд нэвчсэн охин уучлал эрсэн янзтай дагжин сууж байлаа.

Эмэг ээж ээ хэмээн тэр эхэр татаад:

-Би үхэх нь ээ гэлээ.

Эмэг эх толгойг нь дарж үзээд халуураагүй байсан тул охиныг ятгахыг оролдон одоо аравхан цэрэг үлдэж байна гэв. Ирендира айсан араатан чарлах мэт эхэр татаж гарав. Эмэг эх түүнийг хараад арай дэндсэнийг ойлгон толгойг нь илэн тайвшруулахыг оролдлоо.

Чи туниа муутай болохоороо ингэж байгаа юм. Усанд ор, жаахан тэнхэрч ав хэмээн тэр хэлсэн авай.

Эмгэн Ирендираг жаал тайвширсан хойно майхнаас гарч гадаа хүлээж буй цэрэгт мөнгийг нь буцаав.

Өнөөдөртөө боллоо. Маргааш ирээрэй. Чамайг хамгийн эхэнд оруулна хэмээн эмэг эх амлалаа. Тэгээд бусдад нь хандан, хүүхдүүд ээ. Ингээд болоо. Маргааш есөн цагт цугларцгаа хэмээн хашгирлаа.

Цэрэг, ард эсэргүүцэн хашгиралдаж эхлэхэд эмгэн тулдаг тэргэнцрээрээ савчин үзэлцэж гарлаа.

Юм ойлгодоггүй новшнууд! Та нар энэ охиныг төмөр гэж бодоо юу? Өөрсдийгөө оронд нь тавиад үзээч. Борвины баас нь хатаагүй муусайн үймээнчид! хэмээн тэр дүрэмдэн хашгирсан бүлгээ.

Эрчүүд түүнд бүр ч хүнд хараал зүхлээр хариу барьсан ч эмгэн гар буугаараа сүр далайлган байж тэсч үлдэв.

Харин нөгөөдүүл нь хоолны ширээ, тоглоомын саравчийг сүйтгэн тонож орхиод арилцгаав.

Эмгэн майханд буцаж орохынхоо толгой дээр Уллыг олж үзэв. Сүүдэрт зогсох хөвгүүн асар том, сүр бараатай үзэгдэх агаад гоо үзэсгэлэн нь харанхуйд ч гэрэлтэн харагдах аж.

Эмгэн:

-Хөөе сахиусан тэнгэр гуай! Жигүүрээ яачихаав? хэмээн асуухуй өвөө маань л жигүүртэй байсан юм гэнэлээ. Гэхдээ хэн ч итгэдэггүй юм хэмээн цаадахь нь ажиггүй хариулав.

Эмэг эх хөвгүүнийг биширсэн янзтай дахин хэсэг харснаа:

-За сайн байна, маргааш өглөө ирээрэй гэхихээд майхандаа буцаж орлоо. Уллыг ч байрандаа сүүдийн зогссоор үлдлээ.

Ирендира усанд ороод арай дээрдэв. Тэр бүчтэй богинохон дотуур өмд өмссөн байх агаад унтахын өмнө үсээ хатаах зуураа өөрийн эрхгүй урсах нулимсаа тогтоохыг оролдож байв. Эмэг эх

унтаж байлаа.

Ирендирагийн орны араас Уллисын толгой алгуурхан цухуйлаа.Охин уйтгартай боловч болор мэт тунгалаг нүдийг нь олж хараад хий үзэгдэл эсэхийг нь шалган алчуураар толгойг нь ороотол нэг ч үг дуугарсангүй.

Уллисыг нүдээ цавчлахад Ирендира маш аяархнаар:

-Та хэн бэ гэж асуулаа.

Хөвгүүн өндийн цээжээ ил гарган миний нэр Уллис гээд эцгээсээ хулуусан мөнгөө харуулаад надад мөнгө байгаа хэмээв.

Ирендира гараараа ор тулан Уллис руу тонгойж, цэцэрлэгийн хүүхдүүд тоглож буй мэт ярьж эхэллээ.

-Чи дараалалд зогсож байсан уу?

-Би шөнөжингөө хүлээсэн.

-Тэгвэл одоо маргааш өглөө болтол хүлээ дээ. Би бөөр рүүгээ өшиглүүлж өшиглүүлчихсэн юм шиг болчихоод байна.

Энэ үеэр эмэг эх зүүдлэн ярьж эхлэв.

-Хамгийн сүүлд бороо орсноос хойш хорин жил болох нь хэмээн тэр хэлээд, ёстой нэг аймаар шуурга болж, бороо, тэнгисийн ус хоёр холилдоод маргааш өглөө нь байшин үхсэн загас,эмгэн хумсаар пиг дүүрсэн байсан юм даг. Тэгэхэд чиний өвөг аав Амадис, тайван нойрсог хөөрхий, агаарт хөвж яваа шулам загасны туяа цацрахыг харсан даа хэмээн ярив.

Уллис орны ар руу дахин нуугдахад Ирендира шоолонгуй инээмсэглэж, битгий тоо! Эмээ маань унтахаараа ингэж солиордог юм. Гэхдээ газар хөдөлсөн ч сэрэхгүй гэлээ.

Уллисыг өндийхөд Ирендира түүнийг аальгүй бүр эрхлэнгүй ч янзаар ширтсэнээ толботон заварсан цагаан даавуугаа хууллаа.

Хөвгүүн цагаан даавууны нөгөө талд очлоо. Даавуу гудаснаас хавьгүй том агаад тэр хоёр хэд нугалан эвхлээ. Ийнхүү эвхэх бүрд Уллис Ирендирад ойртсоор байв.

Тэгснээ, би чамайг харах гэж хүлээсээр байгаад галзуурах шахсан хэмээн тэр гэнэтхэн дуугараад чамайг хүн болгон л хөөрхөн гээд байсан, үнэн юм аа гэлээ.

Гэхдээ би үхэх гэж байна шүү дээ хэмээн Ирендираг хариулахад цаадах нь ээж маань цөлд үхсэн хүн диваажинд биш тэнгист төрдөг гэж ярьсан хэмээв.

Ирендира бохир даавууг цааш тавиад индүүдсэн цэврийг авч ороо бүтээлээ.

Би тэнгисийг амьдралдаа ер үзээгүй хэмээн охиныг хэлэхэд:

-Яг цөл шиг л дээ, гэхдээ устай гээд бодчих хэмээн Уллис тайлбарлав.

-Гэхдээ түүн дотор чинь алхаж болохгүй биз дээ?

-Усан дотор алхаж чаддаг байсан нэг хүнийг аав мэддэг гэсэн. Гэхдээ их дээр үед юм гэнэлээ.

-Чи өглөө эрт ирээд хамгийн түрүүнд ороод ирж болно шүү дээ.

-Би өглөө үүрээр аавтайгаа хамт эндээс явах ёстой.

-Эргэж ирж чадахгүй гэж үү?

-Мэдэхгүй. Бид нар хил рүү явж байгаад төөрөөд энд ирчихсэн юм.

Ирендира унтаж буй эмэг эхээ бодлогоширонгуй харснаа:

-За яахав мөнгөө өгчих хэмээн шийдэмгий өгүүллээ.

Уллис ч мөнгөө сарвайлаа.

Ирендира орон дээрээ гаран хэвтэхэд, хөвгүүн байсан газраа зүрх алдан зогссоор байх авай.

Ирендира түүний гараас татан яаруулснаа юу болоод байгааг ойлголоо. Энэ явдлын учрыг охин дэндүү сайн мэдэх билээ.

-Чи анх удаа ингэж байгаа юм уу? хэмээн тэр асуулаа. Уллис хариу хэлсэнгүй мушийхчаа аядав.

-Зөөлхөн амьсгал! Анх удаагаа дандаа ингэдэг юм. Сүүлдээ тоохоо больчихдог юм хэмээн Ирендира зааварлалаа.

Охин түүнийг хажуудаа хэвтүүлж, хувцсыг нь тайчих зуураа эх хүн шиг тайвшруулах ажээ.

-Нэрийг чинь хэн гэдэг гэлээ?

-Уллис

-Америк нэр байна.

-Үгүй, усан цэргийн нэр.

Ирендира түүний цээжийг нүцгэлэн энд тэнд нь хэд үнсээд үнэртлээ.

-Чи ч алт шиг хүн юм аа. Гэхдээ чамаас цэцэг үнэртэж байна.

-Жүрж л байх ёстой.

Уллис ингэж хэлэхдээ аль хэдийн дасан зохицож, тайвширсан байлаа.

-Бид нар хүнээс гадна бас шувуу зөөдөг юм. Гэхдээ сая бас жүрж хил давуулсан л даа хэмээн тэр ярив.

-Жүрж чинь хулгайн наймаа биш биз дээ хэмээн Ирендираг асуухад:

-Үгүй дээ. Жинхэнэ хулгайн наймаа чинь тэр. Тэвш нь тавин мянган песо хүрдэг юм хэмээн Уллис хариуллаа.

Ирендира ойрд инээгүйгээрээ инээд алдаж:

-Чи хэрэггүй юмыг ч сүртэй болгож ярих юм. Энэ чинь дажгүй санагдлаа гэлээ.

Тэр ийнхүү эелдэг яриа болсонд Уллисын юм үзээгүй, ариухнаараа байсан явдал нөлөөлөв үү гэлтэй.

Харин эмэг эх хэзээ мөдгүй аз нь харих болчихоод байгааг үл анзааран зүүдэндээ ярих аж.

“Тэр үед гуравдугаар сарын эхээр тэд нар чамайг гэртээ авчирсан юм даг. Чи хөвөнд боодолтой гүрвэл шиг юм байж билээ. Чиний эцэг Амадис тэр үед сайхан ч залуу байж, их ч баярлаж байсан. Мань хүн тэр өглөө хорин тэрэг дүүрэн цэцэг авчирч, тосгон цэцгэнд умбан яг л тэнгис шиг болж билээ” хэмээн эмгэн ярьлаа.

Эмгэн эх иймэрхүү байдлаар хэдэн цагийн турш чанга хашгиран ярьж зүүдэлсэн авай.

Гэвч энэ бүхнийг анзаарах сөгөө Уллист байсангүй. Учир нь Ирендира түүнтэй үнэн сэтгэлээсээ загас наадуулан цэнгэсэн агаад эхлээд хагас төлбөр авсан ч сүүлдээ мөнгө ч авалгүй янагласаар үүр цайлгасан авай.

Есүсын цовдлогдсон загалмай барьсан хэдэн санваартнууд цөлийн дунд зогсож байлаа. Тэдний ёрог даавуун хувцас, сахал үс нь салхинд хийсэн, арай ядан хөл дээрээ тогтоцгоох аж. Ард нь сахиус шүтээнээ залсан бунхан байх болой.

Бүлгийн ахлагч болох хамгийн дүүмэд санваартан ангамал цөлийн хатмал хөрсний хагархайг гараараа зааж, та үүнээс цааш явах ёсгүй хэмээн хашгирлаа.

Хавтангууд холбон бэхлээд дээр нь эмэг эхийг суулган дамнаж явсан дөрвөн индиан ийн хашгирахыг сонсоод цочин зогтуслаа.

Эмэг эх хатуу банзанд дороосоо нухлуулан, цөлийн халуунд зүдэрч байсан ч ихэмсэг төрхөө хадгалж явсан билээ. Харин Ирендира явган таваргаж явлаа.

Тэдний араас ачаа барааг нь үүрч дүүрсэн найман индиан, адагт нь гэрэл зурагчин унадаг дугуйтайгаа дагалдах бүлгээ.

-Цөл хэнд ч харьяалагдахгүй биз дээ хэмээн эмэг эх хэллээ.

-Энэ бол бурханы өмч. Та энэ бузар үйлдлээрээ ариун дагшин хуулийг нь зөрчиж байна хэмээн санваартан өгүүллээ.

Эмэг эх санваартны эрс занг анзааран аргаар үзэхээр шийдэж:

-Хүү минь би юу ч ойлгосонгүй хэмээн учирлав.

Санваартан Ирендира руу заалаа.

-Энэ хүүхэд насанд хүрээгүй байна.

-Уучлаарай, гэхдээ миний ач охин л доо.

-Тэр тусмаа. Энэ охиныг бидний халамжинд өг! Эс бөгөөс бид өөр арга зам сонгох болно.

Эмэг эх тэднийг ингэнэ чинээ санаагүй бөгөөд айн сүрдсэн байлаа. За яахав таны зөв. Би тэгж байгаад охиныг явуулчихъя хэмээн тэр өгүүлвэй.

Энэ явдлаас гурав хоногийн хойно Ирендира, эмэг эх хоёрыг унтаж байхад явган цэргийн харуул мэт чимээгүй гэтсэн хэдэн хүн майханд орж явчихлаа. Тэд бол зургаан залуу индиан санваартан байх агаад ёрог даавуун хувцас нь сарны гэрэлд гялалзан байх авай.

Индианчууд өчүүхэн ч чимээ гаргалгүйгээр Ирендираг шумуулын торонд хулдаад, том загас мэт гулдайлган дамжилсаар авч одов.

Охиныг санваартнуудын гараас салгах гэж эмгэн ёстой л үстэй толгойгоо зулгаах шахав. Тэр аль байдгаараа оролдсон ч барсангүй. Эцэст нь засаг захиргаанд хандлаа.

Хотын даргын алба хашигч цэргийн офицер гэрийнхээ гадаа хашаанд зогсон тэнгэрт бүртийх ганц бараан үүл рүү буудаж байх аж. Тэр ийнхүү бороо оруулахыг үр ашиггүй оролдох зуураа эмгэнд анхаарал хандууллаа.

Эцэст нь яриаг нь сонсож дуусаад:

-Би яаж ч чадахгүй нь дээ. Тохиролцоо ёсоор бол тэр санваартнууд охиныг чинь насанд хүртэл нь эсвэл хүнтэй суутал нь өөр дээрээ байлгаж болно гэж дуугарлаа.

-Ийм юм шийдэж чадахгүй байж та хотын дарга гэж байгаад ямар хэрэг байна хэмээн эмгэн асуухад:

-Бороо оруулахын тулд хэмээн цаадах нь хариу барив.

Дараа нь мөнөөх ганц үүл нүүж одсоныг үзээд сая л нэг юм эмгэнд бүрэн анхаарлаа хандуулав.

Та хэн нэгэн даргаар баталгаа гаргуулбал зүгээр дээ. Таныг ёс суртахуунтай, тохитой хүн гэсэн гарын үсэг гэсэн үг гэж хотын дарга яриад, сенатын гишүүн Онесимо Санчесийг таних

уу? хэмээн лавлалаа.

Халуун наранд шарагдахын дээр бандгар бөгс нь нарийн сандалд хавчигдан зүдэрч суусан эмэг эх:

-Би энэ эзгүй хоосон цөлд мухардсан орь ганц эмэгтэй байна хэмээн учирлалаа.

Хотын дарга наранд гялбаахгүй гэж өрөөсөн нүдээ аниад, эмгэнийг өрөвдөнгүй харж:

-Тийм бол цаг үрээд юүхэв, хатагтай, та тамд л ялзарч дээ гэлээ.

Мэдээж эмгэн тамд ялзарсангүй, харин майхнаа санваартнуудын буудлын эсрэг талд зоож аваад бүслэгдсэн хотыг ажиглах цэргийн жанжин мэт бодлогошрон харж суух болов.

Энэ хооронд юу болохыг хүлээж цөхсөн гэрэл зурагчин жаал жуул юмаа дугуйндаа ачлаа. Эмгэн нар төөнөхийг ч үл хайхран санваартнуудын буудлыг ширтэх ажээ. За яахав, хэн нь бууж өгөхийг харья. Тэд үү, би юу хэмээн тэр өгүүллээ.

-Цаадуул чинь энд гурван зуун жил болсон улс, танд бууж өгнө гэвэл хол хэвтэнэ хэмээн гэрэл зурагчин яриад:

-За би явлаа хэмээн мэдэгдлээ. Эмэг эх цаадах нь дугуйндаа хамаг юмаа ачсаныг сая л анзаарав.

-Чи хаачих нь вэ?

-Салхи хаашаа, би тийшээ, хорвоо дэлхий уудам шүү дээ.

Гэрэл зурагчин явж одоход эмэг эх хорвоо гэдэг чинь тийм ч уудам эд биш дээ, хүний тус мэддэггүй хог минь гээд санаа алдлаа.

Эмэг эх ийнхүү уурласан ч санваартнуудын буудлаас хараа үл салгах ажээ. Тэрбээр яг энэ янзаараа олон олон лүгхийм халуун өдөр, олон олон шуургатай өдрийг элдвийн арга сийлэн бодлогоширсоор суусан бөгөөд буудлаас хэн ч түүн рүү ирсэнгүй.

Нэгэн шөнө асаасан ганц нэг гэрэл нь чөтгөрийн гал мэт сүүмэлзэх ачааны тэрэгний нууцлагдмал цуваа эмгэний хажуугаар өнгөрөв. Эмгэн эх нэгэн цагт Амадисуудын цуваа яг ийм байсныг эргэн саналаа. Цувааны сүүлчийн тэрэг зогсон дугуй хээтэй бүрх, түрийтэй гутал өмсөн, цээжиндээ дайз зөрүүлж, автомат болон хоёр гар буу агссан нэгэн эр бууж ачаа, татлагаа янзлах нь яг л Амадисуудын сүнс гэлтэй үзэгдэв. Эмгэний сониуч зан хөдлөн нөгөө эрийг дуудлаа.

- Чи намайг таних уу? хэмээн эмэг эх асуулаа.

Нөгөө хүн гар чийдэнгээ тусган, өөрийгөө ертөнцийн хамгийн сайхан хүүхэн байсан хэмээн ажиггүй хэлж чадах тэрхүү эмгэний үрчинхий нүүр, гуниг зовлонд сүүмийсэн нүд, сэрлэгэр үс гэзгийг олж үзэв. Тэгээд өмнө нь харж байгаагүй гэдэгтээ итгэтлээ жаахан харж байгаад

гэрлээ унтраагаад:

-Та лав л мөнхийн сүнсний онгон охин биш байна гэв.

-Зөрүүдлэхээ больж үз хэмээн эмгэн маш эелдгээр дуугараад, би хатагтай байна гэлээ.

Нөгөө эр хар зөнгөөрөө гар буунуудаа атгалаа.

-Юун хатагтай билээ?

-Агуу их Амадисын хатагтай.

-Ёстой мэдэхгүй юм байна. Та юу хүсээ вэ?

-Их Амадисын ач охин, хүү Амадисын охин, миний ачийг энэ санваартнуудаас авч өгөөч гэж гуйх гэсэн юм.

Цаад хүн сая л тайвширлаа.

-Та буруу хаалга тогшиж дээ хэмээн тэр өгүүлээд, та биднийг бурхан тэнгэрийн хэрэгт оролцоно гэж бодож байгаа бол хатагтай биш л байна. Та хил давуулан нууц наймаа хийх тухайд адгийн янхны ч ойлголтгүй хүн байна гэлээ.

Өглөө нь эмэг эх унтаж чадсангүй. Тэрбээр цэмбэн хучлаган дотроо элдвийг тунгаан хэвтэхэд хамаг бодол санаа нь үймрэн солиорох шахаж, тэнгисийн эрэг дэх улаан цэцгэн чимэгт байшиндаа аз жаргалтай амьдарч асан тэр цагаа бодохоос зүрх нь дэлбэрэх шахаж, дэмий л гараараа зүрхээ дарах ажгуу.

Санваартнуудын босохын хонх дуугарч, гэрэл гэгээ гарч, агаарт талхны үнэр сэнгэнэх хүртэл тэр ийнхүү тарчиллаа. Дараа нь Ирендира босоод зугтаж ирэх гэж байна хэмээн хоосон горьдож гуниг зовлонгоосоо түр салав.

Харин Ирендира буудалд ирснээсээ хойш шөнө бүхэн бөх сайхан нойрсож байлаа. Нөгөөдүүл нь охины үсийг цэцэрлэгчийн хайчаар тайран сойзны үс мэт арзайлгаад, даяанчийн дугуй малгай өмсүүлэн устай хувин бариулаад хүн өгсөх, уруудах болгонд шат цэвэрлэх үүрэг өгсөн болой,

Тэрхүү шатаар нь шавар шавхай чирсэн санваартнууд, залуу сахилтнууд байнга холхих тул энэ ажилд шар шиг зүтгэх хэрэг гарав. Түүнээс гадна уг буудлынхан шөнө нь шуламтай төдийгүй элсэн цөлтэй тулалдах тул бүгд л туйлдан эцэцгээх аж.

Ирендира үнээ саах, аль эсвэл өдөржин банзан дээр дэвхэрч бяслаг шахах түүнчлэн ямаа ишиглүүлэх залуу санваартнуудыг харлаа. Мөн тэд нар цөлийн элчилгүй хөрсийг цахиур чулуугаар бусад нь хагалан байж бэлдсэн ногооны талбайд ус зөөн ачааны онгоцны ачигч мэт хөлрөхийг, талх жигнэх зуух, индүүдлэгийн өрөөний халуун тамыг ч үзэв.

Ийнхүү Ирендира унтдаг орноос нь цааш өөр олон олон сайн ба саар юм амьдралд байдгийг

Тэрүүхэндээ нээн гайхах агаад харин залуу санваартнуудын бүрэг нь ч, нүүрэмгий нь ч түүнтэй ганц үг солихгүй нь хачирхам байлаа.

Охин нэгэн өглөө шат угаах ус, саваа бэлдэж байхдаа цөлийн нарнаас ч тод яруу чавхдаст хөгжмийн аялгуу сонсов.

Шидэт аялгуунд хөтлөгдсөн Ирендира зургаан сарын нар гэрэлтсэн том цонх, нүцгэн ханатай өрөө рүү сэмхэн шагайвал голд нь нэгэн гэлэнмаа суун хөгжим тоглох нь урд хожид үзэгдээгүй ер бусын үзэсгэлэнтэй эмэгтэй байх амой.

Ирендира үдийн цай хүртэл уг хөгжмийг нүдээ ч үл цавчлан, зүрхээ уяраан чагналаа.

Тэр хоолны дараа залуу санваартнуудыг холхин өнгөрсний хойно харганаар хийсэн сойзоор шат угаахдаа хэн ч байхгүйд ганцаараа үлдлээ.

Тэгэхэд тэрбээр “Би аз жаргалтай байна” хэмээн энд ирснээсээ хойш анх удаа дуугарсан бүлгээ.

Энэ зуур Ирендираг зугтаад гараад ирнэ гэсэн эмэг эхийн найдвар бөхсөн ч Трой гэгээний өдөр буюу Долоо дахь ням гаригийн баяр хүртэл ямар нэгэн шийдвэр гаргалгүй тэвчээртэйгээ суусаар байв.

Долоо дахь ням гаригийн энэхүү шашны ёслолын үед санваартнууд цөлийг самнан жирэмсэн татвар эмсийг олж нөхөрт гаргадаг аж.

Тэд сайтар зэвсэглэсэн дөрвөн цэргээр хамгаалуулан ямбий ачааны тэрэг хөлөглөн ойр холгүй бэдрэх ажгуу.

Гэхдээ эрчүүд татвар эмсээс илүү эхнэрээ дарамталдаг хэмээх баримтыг иш үндэс болгох мөнөөх эмс бурхан тэнгэрийн хүслийг даган хүнтэй сууж өгөхгүй зовоох ажээ. Тиймээс тэдэнд үгийн урныг ашиглан байж бурханы хүсэл зоригийг ойлгуулахад хүрдэг боловч хамгийн зөрүүд нь ч ганц гялгар ээмэг үзээд зөөлөрдгийг хэлэх хэрэгтэй.

Нөгөөтэйгүүр эрчүүд нь ч гэсэн иймдээ тулахаар дүүжин орноосоо сая өндийж, буугаа агсаж аваад ямар нэгэн ачааны тэрэгний тэвшин дээр суун хүсээгүй гэрлэлтээс зугтан одох ажээ.

Эмэг эх жирэмсэн индиан хүүхнүүд ачсан ачааны тэрэг цааш нааш давхилдахыг хэдэн өдөр харсан ч толгойд нь ямар нэгэн арга орж ирээгүй л байлаа.

Цаасан пуужин пижигнэж, хонх дамар тачигнасан тэр өдөр толгойгоо боосон жирэмсэн хүүхнүүд тохиолдлын эр нөхрийнхөө гараас барьсаар бүлэг хүн дагуулан нийт дундын хуриманд цуварч байлаа.

Цувааны эцэст үсээ индиан маягаар тожийлгосон нэгэн хүү гартаа торгон бөс ороон лаа барин явах аж.

Эмэг эх түүнд хандан, хүү минь чи энд юу хийж яваа юм бэ? хэмээн туйлын эелдгээр асуув.

Хүү сармагчных мэт том том шүдтэй тул амаа хамхих аргагүй аж.

-Лам нар надад анх удаа сахил хүртээж байна хэмээн тэр хэллээ.

-Тэд чамд хэдийг төлж байгаа юм?

-Тавин песо

Эмгэн цүнхээ уудлан мөнгө харуулбал хүү мэлрэн гайхах аж.

-Би чамд хорийг нэмж өгье. Харин чи сахил хүртэхгүй, гэрлэх болно.

-Хэнтэй?

-Миний ач охинтой.

Ийнхүү Ирендира буудлын хашаан дотор санваартны бүрх өмсөн, торгон ороолт зүүгээд нэрийг нь ч мэдэхгүй хүнтэй хуримлах болох нь тэр. Охин юунд найдахаа ч мэдэхээ болин, цөлийн халуун наран дор давсархаг хөрсөн дээр өвдөглөн суугаад хоёр зуун жирэмсэн хүүхний үс гээгний үнэрт элийрэн байлаа. Санваартнууд урьд төлөвлөгдөөгүй энэ гэрлэлтийг болиулах арга олоогүй ба охиныг үлдэхийг ч ятгаж үзсэн бүлгээ.

Гэвч Ирендира нөгөөх үүл буудагч захирагч, нөхөр болох хүн, эмэг эх гурвынхаа дэргэд очоод төрснөөс нь хойш баглаж байсан хүлээснээс гарч чадсангүй.

Санваартнууд түүнээс чин сэтгэлээ илэрхийлэхийг хүсэхэд тэрбээр, би эндээс явахгүй хэмээгээд, нөхөр болох хүнээ зааж гэхдээ түүнтэй биш, эмэг эхтэйгээ үлдмээр байна гэсэн авай.

Уллис аавынхаа төглөөс жүрж хулгайлах гэж үдээс хойшжин аргаа барав. Учир нь аав нь муудсан мод огтлох зуураа түүнээс нүд үл салгах агаад ээж нь ч байшингаас хараад байв. Иймээс мань хүн төлөвлөгөөгөө хойшлуулахаас аргагүй болоод дуртай дургүй хөдлөхчөө аядаж байв.

Өргөн том төгөл нууцлагдмал нам гүмд байх бөгөөд нимгэн дээвэртэй модон байшингуудын цонхыг зэс тороор хамгаалж, тулгууртай довжоон дээр нь хайш яайш тарьсан цэцэгтэй савнууд бүхий тавцан байх ажээ. Уллисийн ээж довжоон дээрх Венецийн дүүжин сандал дээр тухалж, толгойны өвчнөө эмнэх гэж эмийн ургамал чамархай дээрээ наажээ.

Харваас энэтхэг төрхтэй тэр эмэгтэй Уллисыг жүржийн төглийн хаана байсан ч үл үзэгддэг цацраг туяа мэт харцаа салгахгүй амой.

Тэрбээр тун чиг царайлаг, нөхрөөсөө нилээд дүүмэд бөгөөд омог отгийнхоо хувцсыг өмссөөр ирсэн, удам судрынхаа урьд эртийн түүхийг мэддэг нэгэн ажгуу.

Уллисыг мод огтлогч барьсаар гэртээ орж ирэхэд ээж нь ширээн дээрээс эмээ авчруулахыг хүслээ. Гэтэл хүү шил, лонхонд хүрмэгц өнгө нь хувираад байх нь тэр.

Ээж нь эмээ уух зуур уг үзэгдлийг сайтар ажиглаад, өвчиндөө дэмийрээгүүйдээ итгэлтэй болсон хойноо хэзээнээс ингэх болов хэмээн төрөлх гуажира хэлээрээ асуулаа.

Цөлөөс ирсэнээс хойш л хэмээн Уллис мөн л гуажирагаар хариулаад, гэхдээ шилэн юманд хүрэхээр л ингээд байгаа юм гэж үргэлжлүүлээ.

Тэгээд үүнийгээ нотлон ширээн дээрх шилэн савнуудад хүрэн өнгийг нь хувирган үзүүлээ.

Ийм юм хайр дурлалаас л болдог юм хэмээн эх нь хэлээд,цаадах чинь тэгээд хэн бэ гэж асуулаа. Уллис хариулсангүй.

Энэ үед тэр хоёрын дэргэдүүр багц жүрж барин өнгөрч явсан аав нь гуажира хэл мэддэггүй тул та хоёр юу ярьж байна? хэмээн Уллисаас даниар асуув. Онц юм биш ээ хэмээн Уллис хариулав.

Харин Уллисын ээж дани хэл мэддэггүй ажээ. Тиймээс нөхрийгөө байшинд орсон хойно, аав чинь юу гэв? хэмээн хүүгээсээ лавлавал цаадах нь онц юм биш ээ гэлээ.

Аав нь байшинд ороод түр үзэгдэхгүй байснаа албан өрөөндөө очсон нь харагдлаа.

Ээж нь хоёулханаа үлдээд хэсэг байзнаснаа, хэн юм бэ? Хэлчих л дээ хэмээн шалгаав.

Хэн ч биш хэмээн Уллис дуугарлаа. Тэр чингэж хариулахдаа хайхрамжгүй байсан нь албан өрөөндөө байгаа эцгийгээ ажин харж байснаас болсон хэрэг.

Аав нь жүржнүүдийг төмөр шүүгээн дээр тавиад уг шүүгээнийхээ нууц кодыг эргүүлж байхыг үзэв.

Түүнийг ийнхүү эцгийгээ ажиглаж байх зуур ээж нь ч холдсонгүй, чи ойрд талх ч идсэнгүй гэлээ.

-Би талханд дургүй.

Ээжийнх нь царайд ер бусын сониуч зан тодорч, битгий худлаа ярь, чи дурласан байна. Дурласан хүн талх идэхээ больчихдог юм гэлээ.

Эмэгтэйн дуу хоолой, харц нь аргадаж энхрийлэхээсээ илүү айлгаж загнах маягтай болж ирлээ.

-Тэр хүн чинь хэн гэдгийг хэлсэн чинь дээр байлгүй.Эс бөгөөс чамайг ариутгагч усанд оруулахаас аргагүй болох нь ээ.

Албан өрөөндөө байгаа дани эр төмөр шүүгээг онгойлгон жүржнүүдийг дотор нь хийгээд хүнд хаалгыг нь хаалаа. Уллис тийшээ ширтэхээ сая нэг юм болин эхийнхээ үгэнд дуртай дургүй хариулж байв.

Хэн ч биш гэж би танд хэлээ биз дээ хэмээн тэр өгүүлээд худлаа гэвэл ааваас асуу л даа

гэлээ.

Элэгдэж хуучирсан Библи сугавчилсан дани эр амандаа зуусан усан цэргийн гаансаа асаасаар гарч ирлээ. Эхнэр нь түүнээс та хоёр цөлд хэнтэй уулзсан бэ? хэмээн испаниар асуулаа.

Хэнтэй ч уулзаагүй. Нөхөр нь ийнхүү үл ялиг уцаардуу дуугарснаа худлаа гэвэл Уллисаас асуу гэлээ. Тэрбээр сууж, тамхиа татаж дуусгаад библиэ нээн уянгалаг жигдхэн дани хэлээр хоёр цагийн турш Бурханы сургаалаас иш татан уншсан бүлгээ.

Уллис элдвийг бодон хөрвөөсөөр шөнө дунд хүртэл огт унтаж чадсангүй. Өнгөрсөн явдлын дурсамжиндаа сэтгэл дэнсэлсэн тэр хөвгүүн дахин бүтэн цаг тийчилснийхээ дараа зориг шулуудлаа.

Тэрбээр шурхийн босч ковбой өмд, шотланд цамц, түрийтэй гутлаа өмсөөд цонхоор дэвхрэн бууж, шувуу ачсан ачааны тэрэг унан дайжиж одов. Тэгэхдээ өглөө эцгээсээ хулуулан авч нуусан гурван жүржээ цэцэрлэгээс авахаа мартсангүй.

Тэр шөнөжингөө цөл гаглан давхиад өглөөгүүр дайралдсан тосгон суурингуудаас Ирендираг сурагласан боловч мэдэх хүн байсангүй.

Эцэст нь охиныг сенатын гишүүн Онесимо Санчесийн сонгуулийн сурталчилгааны багийнхантай хамт Нуева Кастилла хавьд явж байгаа байх гэсэн чимээ сонсов. Тэр Кастиллалд ч дараагийн тосгонд ч Ирендираг олсонгүй. Харин эмэг эх сенатын гишүүнээс бичгээр баталгаа гаргуулж авч чадсан тул ёстой дураараа дургиж буй сураг дуулдав.

Уллис гурав дахь өдрөө шууданчтай дайралдан явах чигээ заалгаж авав.

Тэд нар тэнгисийн зүг явж байгаа юм гэнэ лээ. Чи шалавлах хэрэгтэй. Тэр шулам эмгэн Аруба арал руу очих санаатай байгаа гэнэ лээ шүү хэмээн шууданч ярьсан бүлгээ.

Уллис түүнээс хойш бүтэн хагас өдөр яваад дампуурч тарсан явуулын циркээс эмэг эхийн худалдаж авсан гандмал майхны барааг олж харав. Нөгөөх салхин хамхуул мэт гэрэл зурагчин хорвоо үнэхээр давчуухан юм гэсээр эргэж ирсэн байх агаад зургийн хэрэглэлээ майхны ойр байрлуулж авчээ. Бас нэг үлээвэр хөгжмийн хамтлагархуу юм Ирендирагийн үйлчлүүлэгчдэд вальс тоглох ажилтай болжээ.

Уллис дугаарлан зогсоор майханд орж очоод бохир заваан, ундуй сундуйг юуны өмнө анзаарав. Эмэг эхийн хатан хааны маягийн ор өнгөө хувилган муудаж, сахиусан тэнгэрийн цээж баримал Амадисуудын араг ястай зэрэгцэн газарт хэвтэхийн сацуу арслангийн хөл бүхий хөнгөн цагаан бие угаалгын сав харагдаж байлаа.

Ирендира дөнгөж бүтээсэн орон дээрээ нүцгэн чигээрээ хэвтэх бөгөөд майхан нэвт тусах гэрэлд бие нь нялх хүүхдийнх мэт туяарах ажээ. Тэр нүдээ харсан чигтээ унтаж байлаа.

Уллис жүржнүүдээ барьсаар дөхөж очин зогсоод охин түүнийг ширтэж байгаа ч харахгүй байгааг ойлголоо. Тэр гараа Ирендирагийн нүдний өмнүүр дохиод охины тухай санаашрахдаа

Зохион олсон нэрээр дуудлаа.

-Иреднира!

Ирендира сэрлээ. Тэр Уллисын өмнө нүцгэн байгаагаа санаад уулга алдаад хучлагаа эрүүндээ тулгал татлаа.

Битгий хараад бай л даа! Би аймаар муухай байгаа биз дээ хэмээн тэр өгүүллээ.

-Чи яг л жүржийн өнгөтэй болчихож. Хар л даа!

Уллис ийн өгүүлээд мөнөөх жимсийг нүдэнд нь тулган үзүүллээ. Ирендира нүдээ цавчлан байж харсан ч жүржнүүд өөрийнх нь биетэй адилхан өнгөтэй гэдгийг олж үзсэнгүй. Би чамайг энд бүү үлдээсэй гэж хүснэ хэмээн охин хэллээ.

-Би чамд үүнийг л үзүүлэх гэж ирсэн юм. Уллис ийн хэлээд жүржийг хумсаараа зүсэн хуваагаад Ирендирад харууллаа.

Жүржний яг голд жинхэнэ очир алмас байх нь тэр!

Бид нар ийм жүржнүүдийг л хил давуулдаг юм даа хэмээн Уллисын ярихад, гэхдээ энэ чинь зүв зүгээр амьд бүтэн жүрж байна шүү дээ гэж Ирендира уулга алдлаа.

Тэгэлгүй яахав, аав ургуулдаг юм чинь хэмээн хүү инээмсэглэлээ. Ирендира итгэхгүй байлаа. Тэр нүдээ цавчлан байж очир алмасыг гартаа барин ширтлээ.

Ийм гуравтай байхад л бид дэлхийг тойрно хэмээн Уллис хэллээ. Ирендира түүн рүү үл итгэсэн байдалтай харангаа очир алмасыг буцаан өглөө.

Түүнээс гадна би машинтай яваа. Чи хар л даа. Уллис ийн дээр дээрээс нь давхцуулан яриад цамцныхаа хормой дороос дээр үеийн хийцийн гар буу гаргаж ирэв.

Би арван жил хаашаа ч явах эрхгүй гэж Ирендира хэллээ.

Чи явна. Шөнө цагаан халимыг унтсан хойно би гадаа ирээд шар шувуу шиг дуугарч дохио өгнө шүү.

Уллис ийн яриад яг л шар шувуутай тун адилхан дуугарсанд Ирендира анх удаа инээмсэглэлээ. Эмээ маань л байна хэмээн Ирендира хэллээ.

-Шар шувуу юу?

-Үгүй ээ, Халим!

Тэр хоёр инээд алдацгаалаа. Гэвч Ирендира дахин гуниглаж, эмэг ээж зөвшөөрөхгүй бол хэн ч хаашаа ч явж болохгүй гэж ярьлаа.

-Ямар хэлэх алба уу?

-Гэхдээ тэр заавал мэднэ. Зүүдээрээ мэдчихдэг юм.

-Зүүдэлж байхад нь л бид хоёр хил давчихсан байна шүү дээ. Хоёулаа дамын наймаачид шиг л хил давчихна.

Уллис бугаа хэзээ язааны мэт дохин үзүүлж, амаараа буудах дуу гарган Ирендирад эр зоригоо нотлохыг оролдлоо. Охин за үгүйн алиныг ч хэлээгүй боловч нүдээрээ зөвшөөрсөн дохио өгөөд Уллисыг гаргаж өгөхдөө үнслээ.

Сэтгэл догдолсон хөвгүүн хоёулаа маргааш усан онгоц хөвөхийг хараад зогсож байна аа хэмээн шивгэнэлээ.

Үдэш долоон цагаас арай хойхно Ирендирад эмэг эхийнхээ үсийг самнаж байх зуур азгүйдлийн салхи дахин сэвэлзлээ.

Майханд индиан дамнуурчид болон хөгжмийн хамтлагийн ахлагч нар хөлсөө авахаар цугларсан байв. Эмэг эх хүзүүнээсээ салгадаггүй уутнаасаа мөнгө гарган тоолж дуусаад дансаа дэлгэн үзэж, хамгийн ахмад индианд төлбөрөө өгөв.

Долоо хоногт хорин песо байгаа. Үүнээс хоолонд найм, усанд гурав, шинэ цамцанд чинь тавин цент суутгаад найм тавь болж байна. Май тоол хэмээн тэр хэлэв.

Ахмад индиан мөнгөө тоолж аваад бүгдээрээ майхнаас мэхийн ёсолсоор гарч одоходоо “Цагаан авхай танд баярлалаа” гэгцгээв.

Дараа нь хамтлагийн ахлагчийн ээлж ирэв. Эмэг эх дансаа үзсэнээ аппаратаа оролдон суугаа гэрэл зурагчин руу хандан чи хөгжимд мөнгө төлнө биз дээ гэж асуулаа.

Гэрэл зурагчин толгойгоо ч үл өндийлгөн, хөгжим зурган дээр гардаггүй шүү дээ хэмээв.

-Гэхдээ хүмүүс хөгжим сонсоод зургаа авахуулахаар шийддэг биз дээ.

-Тэгж ярих юм бол тэр чинь оршуулгын хөгжим шиг нас барсан хүмүүсийг санагдуулдаг болохоор нүдээ аниад байдаг юм.

Энэ үед тэдний ярианд хамтлагийн ахлагч оролцон, хүмүүс хөгжимнөөс биш харин таны тэр шөнийн гэрлээс болж нүдээ аньдаг байх шүү гэж дуугарлаа.

Үгүй ээ! Хөгжимнөөс л болж байгаа юм хэмээн гэрэл зурагчин зүтгэлээ.

Эмэг эх маргааныг тасаллаа. Тэрбээр гэрэл зурагчинд хандан, чи битгий бэртэгчин зан гарга! Сенатын гишүүн Онесимо Санчесийг хар. Хөгжимчид дагуулж яваа болоод л хэрэг нь сайхан бүтэж байна даг гэлээ.

Тэгснээ дуугаа өндөрсгөн, чи нэг бол төлөх ёстой юмаа төл, үгүй бол ганцаараа ёдор

толгойлж явахгүй юу хэмээн ширүүллээ.

Би өөрөө өөрийгөө тэжээж дөнгөнө. Би ямар ч гэсэн уран бүтээлч хүн гэж гэрэл зурагчин адарлаа.

Эмэг эх мөрөө хавчаад хөгжимчинтэй тооцоо хийн данс нийлсэн мөнгөө гардууллаа.

Хоёр зуун тавин дөрвөн номер тоглогджээ. Нэг нь тавин цент гэсэн үг. Гучин хоёр тоглолт бүтэн сайн болон амралтын өдрүүдэд болж. Нэг нь жаран цент гэхээр нэг зуун тавин зургаа хорь болсон байна хэмээн эмэг эх ярилаа.

Хөгжимчин мөнгийг авахаас татгалзлаа. Нэг зуун наян хоёр дөч байх ёстой хэмээн тэр хэлэв.

-Яагаад тэр билээ хө?

-Вальс илүү үнэтэй. Тоглоход хэцүү.

Гэсэн ч эмэг эх санасан мөнгөө өгч л саллаа. Тэгэхдээ, за яахав, миний өрөнд энэ баярын үеэр хоёр сайхан вальс тоглоод өгчих. Тэгээд өр ширгүй больё гэсэн бүлгээ.

Хөгжимчин юу ч ойлгохоо болиод дээрх тооцоог эргэцүүлэн будилсаар мөнгийг авлаа.

Яг энэ үед зэвүүн исгэрэх салхи майхныг огцом үлээгээд намжихад эргэн тойрон нам гүм болонгуут шар шувууны дуу тодоос тод сонсогдох нь тэр! Ирендира сандарч мэгдсэнээ хэрхэн нуух учраа олсонгүй, дэмий эмэг эхийн мөнгөний савыг дэрэн доогуураа шургууллаа. Гэвч эмгэн охинд түлхүүр өгөхдөө айсныг нь анзаарч, Битгий ай! Шар шувуу салхитай шөнө дандаа дуугардаг юм гэлээ.

Тэгснээ хамаг юмаа үүрээд явахаар зэхэж буй гэрэл зурагчинд хандан, чи маргааш болтол байвал байхгүй юу. Эрлэгийн элч энүүгээр яваад байх шиг байна хэмээн хааш яаш хэлэв.

Гэрэл зурагчин шар шувуу дуугарахыг мөн сонссон ч бодлоо өөрчилсөнгүй. Үлд үлд хүү минь. Миний чамд юу хэлсэн хамаагүй хэмээн эмгэнийг ярихад гэхдээ би хөгжимд мөнгө төлөхгүй хэмээн цаадах нь дуугарлаа.

Үгүй, үгүй! Би тэр тухай ярихгүй хэмээн эмэг эхийн хэлэхэд, энэ янзаараа байвал таныг хэн ч хайрлахгүй дээ гэж гэрэл зурагчин өгүүллээ.

Эмэг эхийн царай барайж, тэгвэл зайл шаар минь хэмээн уурслаа.

Түүний энэ уур удтал гарсангүй, Ирендирагийн тусламжтайгаар орондоо орж байхдаа ч бухимдсаар байв.

Шулмасын зулбасага! Хүний сэтгэлийг ойлгодоггүй муу новш хэмээн тэр үглэсээр байсан амой.

Харин Ирендирад үүнийг анхаарах сөгөө байсангүй. Учир нь шар шувууны дуу шуурганы

дундуур сонсогдсоор, охин тодорхойгүй түгшүүр дунд шаналж орхив.

Эмэг эх тэгж тэгж нэг юм хэвлээ. Мөнөөх байшинд амьдарч байх үеийн ёсоор ач охин нь дэвүүрээр сэрүүцүүлж, эмгэний уурыг гаргахын тулд бүр ч их хөдлөх хэрэг гарав. Ингээд эмгэн унтахын өмнөх тушаалаа буулгалаа.

-Эртхэн босоод хүн амьтан босохоос өмнө миний угаалгын усыг бэлдээд орхиорой!

-За эмэг ээжээ.

-Маргааш дөрөв дэх өдөр. Хүн их ирнэ. Сайн унтаарай. Дараа нь битгий өлбийгээд байгаарай. За юу?

-За эмэг ээжээ.

-Аа тийм цацагт хяруулаа хоолло!

-За эмэг ээжээ.

Ирендира дэвүүрээ орны толгой дээр тавиад тавиуртай лаануудыг талийгаачдын ястай хайрцагны өмнө асаав.

Эмэг эх аль хэдийн унтаж эхэлсэн ч мөн л заавар өгөн ярьсаар байв.

-Амадисуудад зориулан лаа асаахаа мартав!

-За эмэг ээж ээ.

Одоо бол эмэг эх зүүдэндээ дэмийрч эхэлсэн тул сэрэхгүй гэдгийг Ирендира мэдэж байлаа. Охин салхи улихыг сонссон ч энэ бол азгүйдлийн салхи ч үлээж эхэлснийг хэрхэн мэдэх билээ. Тэр дахин шар шувуу дуугартал харанхуйг ширтэн зогссон бөгөөд эрх чөлөөнд тэмүүлэх зөн бэлгэ нь эмэг эхээсээ айх айдсыг давж гарсан байлаа.

Охин майхнаас тав ч алхалгүй юм хүмээ унадаг дугуйндаа ачсан гэрэл зурагчинтай халз тулгарч орхилоо. Түүний хуйвалдсан маягийн харц Ирендираг болгоомжлуулахад хүргэлээ.

Гэвч тэр гэрэл зурагчин, би юу ч мэдэхгүй, юу ч хараагүй. Харин хөгжимд мөнгө төлөхгүй гэж хэлээд сайн сайхныг ерөөж орхиод явж одсон бүлгээ.

Нэгэнт зориг шулуудсан Ирендира цөлийн гүн рүү шар шувууны дууны чигт салхи исгэрэх харанхуйд уусан гүйж одлоо.

Тэгэхэд л эмэг эх иргэний засаг захиргааныхантай ганц уулзсан хэрэг.

Эмгэн өглөөний зургаан цагт очиж, сенатын гишүүний захидлыг харуулахад орон нутгийн засаг дарга дүүжин орноосоо ухасхийн босч ирэв.

Энэ үед Уллисын аав үүдэнд нь хүлээж суулаа.

“Энд чинь юу бичсэнийг яаж ойлгоно гэж бодоов? Би уншиж чаддаггүй хэмээн засаг дарга омогдлоо. Энэ бол сенатын гишүүн Онесимо Санчес гуайн батлан даасан захидал хэмээн эмэг эх хэлэв. Засаг дарга цааш юм ярихаа болиод дүүжин орныхоо дэргэдээс автомат буугаа авч, чанга чанга хашгиран албатуутдаа тушаал буулгаж гарав.

Тэд нар таван минутын дараа гэхэд л цэргийн машин хөлөглөн оргодлуудын ул мөрийг баллан үлээх шуургыг сөрөн хилийн зүг довтолгож явав.

Засаг дарга жолоочийн дэргэд сууж, дани эр, эмэг эх хоёр арын суудалд хоёр талын гишгүүр дээр зогсох зэвсэгт цагдаа нарын хамт явлаа.

Тэд тосгоны өмнөхөн ус үл нэвтрэгч хөлөг онгоцны далбаагаар тэвшнүүд нь хучаастай ачааны тэргэнүүдийг зогсоолоо. Тэрэгнүүдийн тэвшний ард нуугдан сууж явсан эрчүүд бүтээлгээ сөхөхөд барьсан автомат, пулемётных нь ам мөнөөх хэд рүү онилоотой байх аж.

Засаг дарга эхний тэрэгний жолоочоос шувуу ачсан тэрэг хэдийд зөрснийг лавлав. Жолооч хариу хэлсэнгүй машинаа асааснаа, бид нар матаач тагтаа нар биш хил давуулагч панзчид байна хэмээн зэвүүцэнгүй өгүүллээ.

Засаг дарга буунуудын ам өөрийг нь чиглэхийг нүдний булангаар зэрвэсхэн хараад гараа өргөн инээмэр аядлаа. Тэгснээ та нар ингэж гэгээн цагаан өдөр явах ёсгүй л юм даа хэмээн дэмий л хашгирсан авай. Цувааны хамгийн сүүлчийн тэрэг арынхаа хөндлөвч дээр “БИ ЧАМАЙГ ХҮСЭН ТАЧААДНАМ, ИРЕНДИРА!

гэсэн бичигтэй байлаа.

Тэднийг умар зүг рүү явах тусам салхи улам хуурайшихаас гадна нар ч гэж ёстой цоонож байлаа. Цонх нь хаалттай ачааны тэргэн доторхи халуун, шороо хоёр бүтэж үхэм аж.

Эмэг эх хамгийн түрүүнд гэрэл зурагчинг олж харлаа. Толгойдоо боосон алчуураас өөр нар халхлах юмгүй мань зурагчин тэдний яваа зүгт жийж явах нь тэр.

За тэр харав уу? Нөгөө хуйвалдагч явж байна. Адгийн шаар хэмээн эмэг эх зангалаа.

Засаг дарга гишгүүр дээр яваа нэг цагдаадаа гэрэл зурагчинг хариуцах тушаал буулгав. Түүнийг барьж аваад эндээ хүлээж бай. Бид удахгүй ирнэ хэмээн тэр хэллээ.

Цагдаа гишгүүрээс үсрэн буугаад гэрэл зурагчинг зогсоохоор хоёр ч удаа хашгирлаа. Гэвч салхины эсрэг яваа гэрэл зурагчин үүнийг сонссонгүй. Тэрэг түүний хажуугаар өнгөрөхөд эмэг эх хачирхалтайяа зангавал, гэрэл зурагчин үүнийг нь мэндчилж байна хэмээн эндүүрч гараа даллан инээмсэглэлээ.

Тэр буун дууг ч сонссонгүй. Бие нь агаарт хөөрч ирээд унадаг дугуйн дээрээ буцаж унахдаа аль хэдийн амь тавьсан байлаа.

Тархи нь зад буудуулан цацагдсан ба тэрхүү сум хаанаас ирснийг мэдэхээсээ өнгөрсөн байв. Тэд ийнхүү явсаар үдийн өмнө шувуудын өд сөд салхинд хийсэлдэхийг олж үзлээ. Дани эр тэрхүү өд сөдийг өөрийн шувууных гэж танилаа.

Жолооч чиглэлээ өөрчлөн хаазаа тултал гишгэн давхисаар хагас цагийн дараа тэртээд бүртэлзэх ачааны тэрэгний барааг олж харсан бүлгээ.

Уллис уг тэргийг толиндоо үзээд хурдаа нэмэн зугтаахыг оролдсон ч моторынх нь чадал нэгэнт чинээндээ тулсан байлаа.

Ирендира тэр хоёр огт унтаагүй яваа ба айдас,цангаа хоёрт талхиулж гүйцээд байв. Уллисын мөрийг түшин зүүрмэглэж явсан Ирендира цочин сэрлээ. Охин тэднийг хариугүй гүйцэж яваа тэргийг харан хаалганы хажуу хайрцаг дотор байсан гар бууг өөрийн эрхгүй авлаа.

“Сайн буу шүү. Наадахыг чинь цагтаа ноён Франсис Драк хэрэглэж явсан юм гэнэлээ хэмээн Уллис өгүүлэв.

Охин бууг хэд савчсанаа цонхоор шидчихэв. Арын тэрэг салхинд өд сөд нь зулмарсан шувуун ачаатай тэрхүү ямбий тэргийг гүйцэж түрүүлээд огцом эргэн замыг нь хаалаа.

Энэхүү түүхийг өгүүлэгч зохиолч миний бие яг энэ үйл явдал болох үед л Ирендира, Уллис хоёрыг биечлэн мэдэх болсон юм.

Тэр үедээ бод энэхүү түүхийн нарийн ширийнийг огт сонирхоогүй хэрэг. Харин тэртээ олон жилийн хойно Рафаэль Эскалано энэхүү явдлын эмгэнэлт төгсгөлийг дуугаар илэрхийлснийг сонсоод та бүхний уншиж буй энэ түүхийг бичихээр шийдсэн билээ. Ингээд гол сэдвээсээ ялимгүй хазайсандаа уучлал эрээд яриагаа үргэлжлүүлье.

Хүү,охин хоёрыг чингэж баригдсаны дараахан мөн л миний адил энэ хязгаараар тэнүүчлэн шар айраг хөргөх төхөөрөмж худалдаалдаг Авара Середо Сумудо намайг тэргэндээ суулгаж авч явсан юм даг.Бид хоёр хэрэгтэй хэрэггүй яриагаа шар айргаар даруулсаар их цөлийг ядах юмгүй туулаад хилийн бүсэд тулж очив.

Тэнд мөнөөх ужид самууны үүр болсон майхан байх ба “ХАМГИЙН АМТТАЙ НЬ ИРЕНДИРА”, “ДАХИН ДАХИН ИРЭЭРЭЙ-ИРЕНДИРА ЧАМАЙГ ХҮЛЭЭНЭ ШҮҮ”, “ИРЕНДИРАГҮЙ БОЛ АМЬДРАЛ УТГАГҮЙ”

гэсэн бичээсүүдтэй даавуу хадаастай байгаа харагдлаа.

Ёстой таван хэл, найман зүсний арьс үндэс, зэрэг зиндааны эрчүүдийн эцэс төгсгөлгүй урт цуваа, бадар худалдаачдын чимээ шуугианд дөжирсөн энэ хотын гудамж бүрээс салбарлаж өгс багтах зай бүхэнд чихэлдэн эвхэрэлдэх нь могой мэт санагдах бүлгээ.

Энд гудамж бүхэн мөрийтэй тоглоомын үүр, байшин бүхэн зугаа наргианы танхим, айл бүхэн оргодол алдуулын оромж болсон газар ажээ.

Дуучдын учир нь үл ойлгогдох дуу хөгжим, наймаачдын бараагаа зарахаар орилолдохтой

нийлээд эндхийн солиормоор халуунд ердөө бөөн нүргээн болон сонсогдох ажээ.

Энд холхих эх орон ч үгүй золбингуудын дунд жинхэнэ хорт могойгоор хатгуулаад өөрийнхөө хийсэн ерөндгөөр анагааж үзүүлнэ гэх сайн эр Блакман гэгч чиг байна, эцэг эхийнхээ үгийг дагаагүйгээс шоргоолж болж хувирсан гэж ярих хүүхэн чиг байна. Бас мөнх амьдралын элч хэмээх нэгэн бээр од мичдийн аймшигт тохиол болж хүүхэр буцлан тэнгис урваж ёроол нь ил гарна гэж ярьж яваа ч үзэгдэнэ.

Харин уг хотын улаан дэнлүүний гудамж энэхүү чимээ шуугианаас холхон оршдог юмсанж. Тэнд тэнгисийн сарнай үнэртүүлсэн хүүхнүүд бүжгийн эзгүй танхим сахин эвшээлдэх ажээ. Тэд өглөөнөөс эхлэн суугаагаараа унтацгаах агаад өөрсдийг нь хүсэх эрчүүд огт үзэгдэхгүй тул дэмий л ямар нэг гайхамшигийг хүлээн тайзнаас дүүжлээстэй сэнсийг гиюүрэн ширтэцгээж байв. Гэнэт тэдний нэг нь босон нэрстэй ваар өрөөстэй тагт руу гарлаа. Доогуур нь Ирендирагийн шүтэн бишрэгчид явж байв.

Цаадах чинь бид нараас юугаараа илүү байна хэмээн хүүхэн хашгиран асуухад дороос хэн нэг нь тэр чинь сенатын гишүүний батлан даалттай шүү дээ хэмээн хариу барив.

Энэ үед гудамжны чимээнд татагдсан хоёр дахь хүүхэн тагтан дээр гарснаа, пөөх ямар урт дараалал байсан гэж бодно таминь. Тэгээд бас ганц удаа л 50 песо гээд төсөөлөөд үз дээ гэлээ.

За яахав. Тэр муу нялх хүүхэд ямар алт болсон алцаатайг нь очиж үзнэ дээ хэмээн эхний хүүхэн шийдэв. Би ч бас явъя. Энд сандлаа үнэгүй бүлээцүүлж сууснаас дээр хэмээн нөгөө хүүхэн хэлэв.

Тэр хоёр дээр бусад хүүхнүүд нь нэмэгдээд Ирендирагийн майханд очин бөөн үймээн дэгдээв. Тэд майханд шууд дайран орж, төлсөн мөнгөнийхөө төлөө байдгаараа жаргаж хэвтсэн эрийг дэрээр цохин хөөгөөд Ирендирагийн орыг гудамж руу чирч гаргав.

Энэ бол доромжлол! Сүрэг дээрэмчид! Сүнсгүй новшнууд! хэмээн эмэг эх хашгирлаа. Дараа нь бас дугаарлан зогсоо эрчүүд рүү хандан, муу нусгай нар, та нар нэг муу харж хамгаалах хүнгүй ядарсан хүүхэд рүү дайрч байхад байж байгааг нь. Эрчүүдээ алд! Ижил хүйстнүүд! хэмээн цамналаа.

Хэдий эмгэн түрдэг тэргээ савчин байдгаараа орилох авч олны шуугианд эрхгүй дарагдаж байлаа.

Эмэг эх нь охиныг зугтаахыг оролдсоноос хойш нохойн гинжээр орны хөндлөөс гинжилдэг болсон тул Ирендира олны инээдэм тохуурхалаас зайлж чадсангүй. Харин хүүхнүүд охинд гар хүрсэнгүй, гудамж дагуух тагтнууд дээр нүглийг нь наманчлуулах байдлаар жаал суулгаад эцэст нь хотын төв талбай руу чирч аваачлаа. Ирендира нүүрээ нуун байдгаараа атийгаад таг дуугүй суусан ба нохойн гинжтэйгээ ичгүүр, гутралдаа цөхрөн цог шиг халуун наранд шарагдан суусаар байсан бөгөөд харин сүүлд хэн нэгэн сайн санаатан цамц нөмрүүлсэн бүлгээ.

Яг тэр үед миний бие эмгэн, охин хоёрыг ганцхан удаа харсан юм даг. Тэр хоёр сүүлдээ нутгийн захиргааны хамгаалалтанд хэсэг байж байгаад эмгэний хэтэвч хоосрох тийшээ хандахад цөлийг орхин тэнгисийн зүг одсон бүлгээ.

Тэгэхдээ энэ ядуу хоосон хязгаарт урьд үзэгдээгүй бийлэгжүү цуваа хөдөлсөн юм даг. Зургаан шар тэргэнд хаадын цээж баримлууд, ховор хуучин цагнууд, жинхэнэ эх биш ч гэлээ байшин шатахад үрэгдсэн зургуудын хямдхан хуулбарууд, хуучин төгөлдөр хуур, чемодантай бягтруул, пянзнууд ачсан байсан. Бүлэг индианчууд ачаа хөсгийг хариуцан байх ба хөгжмийн хамтлаг замын тосгодод ирэх буцахыг зарлан байв.

Эмэг эх тэргэн дээр байрлуулсан сүүдрэвч дор сүрлэн гудсан дээр тухлан, халаасан дахь арвайнаасааажилсан шиг аялж явлаа. Түүний цээжин бие нь ихэд томорсон харагдаж байв. Учир нь эмэг эх цамцан дотуураа усан цэргийн хантааз өмсөн түүндээ дайзанд сум хадгалах лугаа адил алтан гулдмайнуудаа байрлуулсан байлаа.

Ирендира элдвийн цацаг санжигнасан тод өнгийн даавуун хувцас өмсөн зэрэгцэн сууж явах бөгөөд нохойн гинжээр аргамжуулсан хэвээр байх ажээ.

Чамд гомдоод байх юм байхгүй хэмээн эмэг эх нь хилийн тосгоноос хөдлөн замд гарч явахдаа хэлжээ. Мөн тэрбээр чи хатан хаан шиг хувцаслан, тансаг зөөлөн орон дээр унтаж, хувийн эзэмшлийн хөгжмийн хамтлагтай, 14 индиан шивэгчинтэй болно гэж яриад энэ үнэхээр сайхан байгаа биз хэмээн асуулаа.

-Тийм ээ эмэг ээжээ!

“Намайг байхгүй болохоор чи эрчүүдийн гарт хоцрохгүй. Яагаад гэвэл чи том хотод өөрийн байшинтай болно. Чи аз жаргалтай, эрх чөлөөтэй байх болно хэмээн эмэг эх үргэлжлүүлэн ярих ажээ.

Энэ бол үзэгдэж дуулдаагүй ирээдүйн тухай яриа байлаа. Түүнээс гадна охины биеэ үнэлсний хөлс нэг л ахихгүй, эмэг эх будилуулах тусам Ирендира тэрхүү гэрэлт ирээдүйд итгэх итгэлээ алдсаар байсан ч энэ тухайгаа хэнд ч хэлж зүрхлээгүй ажгуу. Тэгээд ч Ирендира бодлоо хав дардаг зантай болжээ. Тэрбээр хужир шүүний ухмал нүх, уурхайн хонгил, тосгодын эл хуль гудамжинд эрчүүдийн зугаа гаргаж байхдаа энэхүү тамлалыг дуугүйхэн тэвчиж байлаа. Эмэг эх нь ирээдүйн тухай хөзрөөр мэргэлж буй мэт бурж гардаг байв.

Нэгэн үдээс хойш тэд бартаат хавцлыг туулан аман дээр нь гарч ирвээс эртний домогт лаврын модны үнэр салхи хөлөглөн сэнгэнэж, ямайк хэлээр ярилцах нь сонсогдох нь тэр. Тэд тэнгист тулж очсоноо зүрхээ даран байж ойлголоо.

За энэ дээ хэмээн насныхаа ихэнхийг цагаачлан өнгөрөөсөн эмэг эх хэлээд Карибын тэнгисийн болор мэт тунгалаг агаараар амьсгаллаа.

-Ирендира! Чамд сайхан байна уу?

-Тийм ээ. Эмэг ээжээ.

Тэд нар тэндээ буудаллаа. Эмэг эх шөнө нь зүүдэлсэнгүй, харин өнгөрсөн ба ирээдүйг хольж хутган баахан яриа дэлгээд урь дынхаасаа хожуу унтаж, өглөө нь тэнгисийн чимээнд сайхан амарчихсан босч ирэв. Тэгсэн хирнээ Ирендигаар биеэ угаалгах зуураа ирээдүйн тухай ам мэдэн бурж алдах нь нойрмоглоон дэмийрч байна уу гэлтэй.

Чи эрхэмсэг хатагтай болно. Дагалдагсаддаа хүндлэгдэн ихэс дээдэст таашаагдах болно. Далайн онгоцны ахмадууд дэлхийн өнцөг булан бүрээс чамд ил захидал илгээх болно хэмээн тэр Ирендирад ярьсан авай.

Харин Ирендира энэ яриаг анхаарч сонссонгүй. Гадаахь саван дахь ургамлын хандаар анхилуун болгосон бүлээн ус хоолойгоор дамжин ирж байв. Ирендира нэг гараараа эмгэнийг савандангаа нөгөө гараараа ус хутган биеийг нь зайлж байлаа.

Харин эмгэн “Чиний гэр орны алдар суу Антиллийн нуруунаас Голландын вант улс хүртэл түгэн тархах болно. Гэр орон чинь ерөнхийлөгчийн ордноос ч чухал байна. Яагаад гэвэл тэнд засгийн газрын харилцааны асуудал яригдаж, улс орнуудын хувь заяа шийдэгдэж байх болно” хэмээн энэ зуур бурлаа.

Гэтэл гэнэт ус тасрав. Ирендира юу болсныг үзэхээр гарахад хоолой руу ус хийх үүрэгтэй индиан эр түлээ хагалж байв.

Ус дуусчихлаа. Дахиад жаахан ус хөргөмөөр байна хэмээн индиан эр өгүүллээ. Ирендира анхилуун навчистай ус даргилах нөгөө зуухан дээр очин гараа жийрэглэн тогоог өргөж үзээд индианы тусламжгүйгээр даахаа мэдлээ. Та яв яв. Би усыг юүлчихье хэмээн охин хэллээ. Тэр индиан хүнийг явахыг хүлээж байгаад буцламгай устай тогоог өргөн хоолойны түвшинд аваачаад хүн шалзалж алам уг усыг юүлэхийг завдлаа.

Яг энэ мөчид эмэг эх майхан дотроос Ирендира! хэмээн хашгирлаа. Хашгирах хашгирахдаа охины юу хийх гэж буйг харсан мэт хашгирлаа. Эмэг эхийнхээ дуунд цочсон ач охин сүүлчийн мөчид уг үйлээсээ түдгэлзлээ. Одоо очлоо эмэг ээж ээ! Би ус хөргөж байна хэмээн тэр хэлсэн авай.

Шөнө нь алттай хантаазтай эмэг эх нь зүүд нойрондоо дуу дуулж байхад Ирендира элдвийг эргэцүүлэн удтал сэрүүн хэвглээ. Ирендира эмэг эх рүүгээ хараагаа хурцлан ширтэхүй нүд нь муурынх мэт гэрэлтэх аж. Дараа нь тэр ор руугаа чиглэн живсэн хүн мэт гараа цээжиндээ аван, нүдээ хараатай чигээрээ алхахдаа хамаг дотоод сэтгэлээ хөвчлөн байж хөвгүүнээ дуудлаа.

-Уллис!

Уллис жүржийн цэцэрлэгтэй байшиндаа цочин сэрлээ. Тэрбээр Ирендирагийн дуу хоолойг дэндүү тод сонссон тул охиныг хайн харанхуйг нэгжин харлаа. Тэгээд түргэн зуур зогтуссанаа хувцсаа бөөгнүүлэн тэврээд өрөөнөөс гарав. Түүнийг үүдний довжоо өнгөрч явтал гэнэтхэн аавынх нь дуу гарав.

-Чи хаачих нь вэ? Уллист аав нь цэв цэнхэр үзэгдэх ажээ. Юм үзэж нүд тайлъя даа хэмээн тэр хариуллаа. За яахав, энэ удаа чамайг хорьшгүй нь. Гэхдээ эцгийн хараал хаа ч явсан дагах болно гэдгийг л чамд анхааруулья хэмээн дани эр өгүүллээ. Болтугай болтугай гэж Уллис хэллээ.

Хүүгийнхээ шийдвэр төгс байдалд гайхаж, басхүү бахархсан дани эр түүнийг жүржийн төгөл өнгөртөл дагахдаа нүүрэнд нь инээмсэглэл тодорч эхэллээ. Эхнэр нь гагцхүү энэтхэг бүсгүйчүүдэд л байдаг тэрхүү гоо үзэсгэлэнгээ цацруулан араас нь дагаж явав. Уллисыг хашааны хаалга хаахад эцэг нь түүнтэй хэдэн үг солив.

Тэр амьдралын хатууг үзээд чиний бодсоноос чинь өмнө эргээд ирнэ хэмээн дани эр эхнэртээ өгүүллээ.

Тэнэг хүн ээ чи! хэмээн энэтхэг бүсгүй санаа алдаад, тэр хэзээ ч эргэж ирэхгүй хэмээсэн ажгуу.

Уллис энэ удаа Ирендира хаана явааг хэнээс ч асуусангүй. Тэрбээр замын тэрэгнүүдэд нуугдан сууж, хоол хүнс хулуул идэж, нойроо сэм аван зорчсоор Аруба арлыг зорин зангуугаа татаж, аян замын ерөөл дагуулах хөлөг онгоцны зогсоол бүхий, гял цял шилэн байшингуудтай тэнгисийн эргийн тосгонд байх танил майхныг олж очив.

Ирендира орны хөндлөөс гинжлээстэйгээ түүнийг дуудсан үе шигээ усанд живсэн хүн мэт хэвгэн унтах амой.

Уллис охиныг ширтэн удтал чимээгүй суусан ба түүний өрөмдөх мэт харцанд цаадах нь өөрийн эрхгүй сэрсэн бүлгээ. Тэгээд тэр хоёр харанхуйд үнсэлдэн хувцсаа алгуурхан тайчсан бөгөөд тэдний элгэмсэг дотночлол, нууцхан аз жаргал нь дурлалаас ч хүчтэй байлаа.

Майхны нөгөө буланд унтаж буй эмэг эх шөнийнхөө зүүдэнд авган чангаар ярьж эхлэв.

-Грекийн усан онгоц ирсэн үе юм даг хэмээн тэрбээр хэлээд онгоцны багийнхан гэж ёстой галзуу эрчүүд хүүхнүүдэд аз жаргал бэлэглээд мөнгөөр биш далайн сүмсээр төлбөр хийдэг сэн. Тэр сүмсүүд нь амьтай, айлуудаар явж хүүхэд айлгаж уйлуулдаг, хүүхдүүдийн нулимсыг тэд нар уудаг байсан даа хэмээн хөврүүлэв.

Тэгснээ эмгэн орон дээрээ хөрвөөснөө босч суулаа.

-Тэгэхэд л миний бурхан ирсэн юм даа. Өндөр, сүрлэг, Амадисыг бодвол ёстой эр хүн байсан даа хэмээн тэр хашгирлаа.

Уллис өдий хүртэл эмэг эхийн дэмийрэхийг тоохгүй байснаа ийнхүү босон суухыг нь үзээд нуугдахыг оролдоход Ирендира болиуллаа.

-Битгий тоо! Наадахь чинь яг ийм яриан дээр ирэхээрээ босч суудаг юм. Гэхдээ сэрдэггүй юм хэмээн охин хэллээ. Уллис түүний мөрийг наллаа.

-Би тэр шөнө усан цэргүүдтэй наргин газар хөдлөх шиг л юм болж байлаа хэмээн эмэг эх

үргэлжлүүлээ. Усан цэргүүд инээж хөхрөөд, орилж хашгираад бужигнаж байсныг бодоход бас л над шиг юм бодсон байж таарна. Харин тэр л ганцаараа тайзан дээр үлдсэн. Би тэр үед хүн болгоны амнаас салдаггүй байсан тэр нэг дуулсан минь өчигдөрхөн мэт санагдаж байна. Тэр дууг гадаа хашаанд байсан туулайнууд хүртэл даган дуулж билээ тэгэхэд.

Эмэг эх зүрх сэтгэлийнхээ уй гашууг илэрхийлсэн дуугаа зүүдэлж буй хүний ёсоор гуншиганаан аялав.

Онгон ариун хальсыг минь

Одоо эргүүлж хайрлаач Бурхан минь

Энхрий залуугийнхаа хайрыг

Эхнээс нь дахиад амталмаар байна

Уллис энэ үеэс эхлэн эмгэний аягалахыг сонирхож эхлэв.

-Тэр яг Гуатрал Гвинейд ирдэг шиг мөрөн дээрээ тоть суулган бас махчингуудыг алдаг буугаа мөрөвчилчихсэн байж билээ. Түүнийг өмнө минь зогсоход амьсгалаас нь үхэл үнэртэж байж билээ. Тэгэхэд тэр маань “Би хорвоог мянган удаа тойрч, газар газрын хүүхнүүд харсан хүний хувьд чамайг хамгийн эрхэмсэг, дур булаам гэдгийг баттай хэлэх байна” гэж билээ.

Эмэг эх ийнхүү яриад дахин хэвтэж, дэрэндээ нүүрээ наан хэсэг эхэр татууллаа. Уллис, Ирендира хоёр хөгшин авгайн уухичин унтах чимээг чагнан удтал дуугүй байцгаалаа. Тэгтэл:

-Чи түүнийг алж чадах уу? хэмээн Ирендира гэнэтхэн боловч тайвнаар асуух нь тэр. Балмагдсан Уллис юу гэхээ мэдсэнгүй.

-Хэн мэдэхэв дээ. Чи алья гэж бодоод байгаа юм уу?

-Би чадахгүй нь. Тэр чинь миний эмэг ээж шүү дээ.

Уллис унтаж буй том биеийг хэр амь бөхтэйг нь шалгах мэт харснаа:

-Чиний төлөө би яасан ч чадна гэлээ.

Уллис хагас килограмм хулганы хор худалдан авч амтат хөөсөнцөр, мойлны чанамалтай холиод энэхүү үхлийн зуурмагаа бялууны гол руу хийлээ. Тэгээд нүгэлт үйлээ нуун дээр нь өөр хөөсөнцөр нэмэн сайтар хутгаад бялуун дээрээ далан хоёр ягаан лаа зоон ажлаа өндөрлөв.

Түүнийг энэхүү төрсөн өдрийн бялууг тэврэн орж ирэхэд эмэг эх таягаа савчин эзний суудалдаа заларч байсан авай.

-Аа муу ичгүүргүй шулам! Энд хөл тавьж яаж зүрхлээв чи? хэмээн тэр ориллоо.

Уллис сахиусан тэнгэрийн сайхан төрх гарган, таны төрсөн өдрөөр уучлал гуйхаар ирлээ хэмээн өгүүлэв.

Хөвгүүний башир залинд хууртсан эмэг эх төрсөн өдрийн ширээгээ хуримын ширээ мэт заслаа. Тэр Уллисыг баруун гартаа суулгалаа.

Ирендира тэр хоёрт үйлчилж байв. Эмэг эх бялуунд хатгаастай далан хоёр асаастай лааг ганцхан амьсгаагаар унтрааж орхиод бялууг хоёр тэнцүү хуваалаа. Энэ удаа тэр Уллист үйлчлэх ажээ.

-Өөрийгөө уучлуулж чаддаг эр хүн хорвоогийн хагасыг эзэмшдэг юм. Би чамд энэ аз жаргалын хэрчим бялууг өгье хэмээн эмэг эх өгүүлэв.

-Би чихэрлэг юм идэж чаддаггүй юм. Та ид хэмээн Уллис хэлэв. Мөн эмэг эх Ирендирад ч гэсэн нэг хэрчим бялуу өгснийг нь охин гал зуух руу авч ороод хогийн саванд хаясан бүлгээ.

Эмэг эх үлдсэн бялууг өөрөө цохиж гарав. Тэр бялууг бүхэл бүхлээр нь ам руугаа чихэн зажлалгүй залгих зуураа тамшаалан дуу алдаж, Уллисыг талархан харах ажээ. Түүгээр ч зогсохгүй өөрийнх нь бялуу дуусахад Уллисынхыг ч цааш хийж орхиод тавган дээрх үлдэгдлийг ч гараараа хаман идэж орхив.

Ийнхүү тэр бүхэл бүтэн сүрэг хулгана хиаруулам хүнцэл идсэн авай. Тэгснийхээ дараа төгөлдөр хуур тоглож, шөнө дунд хүртэл дуулж аваад баяр баясгалантай амьтан орондоо орж хэвийн байдалтай унтаж эхлэв. Ганц өөрчлөгдсөн юм гэвэл амьсгаа нь чихран тасалдах ажээ. Ирендира, Уллис хоёр нөгөө орон дээрээс түүний амь тэмцэхийг нь хүлээсээр байв. Гэвч эмгэн зүүдэндээ дэмийрч эхлэхүй дуу хоолой нь урьд урьдынхаас илүү цоглог байх нь тэр.

-Би бүр галзуурч орхиж билээ, бурхан минь. Ёстой галзуурсан даа хэмээн тэр хашгиран ярьж эхэллээ. Би түүнийг оруулахгүйн тулд хаалгандаа хоёрын хоёр түгжээ хийн, хувцасны ширээ тулгаж тавиад дээр нь сандал ширээ овоолсон ч тэр бөгжөөрөө хаалга ганцхан тогшиход л сандал ширээ аяндаа хойш болж, хувцасны ширээ хөндийрөн түгжээнүүд өөрснөө мултрад уначихаж билээ.

Эмэг эхийн яриа улам бодитой, төстэй болохыг Ирендира, Уллис хоёр гайхан чагнаж байлаа.

-Би сэтгэл баясгалантай, үхлээ түгшин, хаалга битгий онгойгоосой, орж ирэхгүй байгаасай, ороод ирээсэй гэж сэтгэл хоёрдон байлаа. Ирвэл буцаад битгий яваасай. Би түүнийг хөнөөхгүй гэж бодож байсан сан.

Эмэг эх энэхүү түүхээ хэдэн цагийн турш давган ярьж, тэр цаг үедээ амьдрах мэт болов. Тэрбээр үүр цайхын өмнөхөн газар хөдлөх мэт ороо нужигнуулан хөрвөөж уйлан дуугарч эхэллээ.

Би түүнд анхааруулахад өмнөөс инээдэм болгож билээ хэмээн тэр хашгирлаа.

-Намайг дахиад анхааруулахад дахиад л инээдэм болгож байснаа дараа нь амаараа биш харин

надад хэрчүүлсэн хоолойныхоо завсраар ай даа хатан хаан минь, хатан хаан минь гэж байж билээ.

Эмэг эх ийнхүү алин цагт үйлдсэн аймшигт хэргээ ярихад Уллис айн Ирендирагийн гарыг атгалаа. Настай эмэгтэй хүнийг алах ч гэж дээ хэмээн тэр уулга алдлаа. Ирендира үүр цайхыг ажиглан ийн хэлэхийг нь анзаарсангүй. Цаг өглөөний тав болж байлаа.

-Энэ хүн заанаас ч бөх амьтай юм уу даа. Итгэмээргүй юм гэж Уллис дуу алдлаа.

Ирендира түүнийг харцаараа тас шилбүүрдэн:

-Чи ерөөсөө хэнийг ч алж чадахгүй амьтан болохоор тэр гэлээ. Уллис энэхүү зэмлэлд тун ч их гутран майхнаас гарч одов. Харин Ирендира нар мандан, шувуу жиргэн жиргэтэл далд үзэн ядалт, урам хугаралт хослуулан эмэг эхээ харж хэвтсэн бүлгээ. Эцэст нь эмэг эх нүдээ нээн эелдгээр инээмсэглэн байж:

-Бурхан чамайг өршөөг хэмээв.

Эмэг эхийн хувьд ганц өөрчлөгдсөн юм гэвэл өдөр өдрийн дэглэмийг хооронд нь андуурах болсон явдал байлаа. Энэ өдөр лхагва гариг байсан боловч эмгэн ням гаригийн хувцсаа өмсөнө гэж зүтгээд, Ирендираг жин үдээс өмнө үйлчлүүлэгч хүлээн авч болохгүй гэлээ. Бас хувцсаа анарын өнгөөр будуулахыг охиноос хүсээд үсээ санваартны маягаар засууллаа.

-Би зургаа авахуулахыг өнөөдөр шиг хэзээ ч хүсч байгаагүй хэмээн тэр шүүрс алдаж байв.

Ирендира эмэг эхийнхээ үсийг самнаж эхлэхэд саманд нь үс зулгаран хоцорлоо. Тэгээд үүнийг эмэг эхдээ даруй харуулбал цаадахь нь самыг үзсэнээ толгойтой үсээ гараараа татвал туг үс гарт нь зулгарч ирэв. Дахин үзэхэд дахиад л зулгарлаа. Тэгснээ эмгэн тачигнатал хөхрөн хоёр гараараа үсээ үгтээн туг туг үс газарт шидэлж гарлаа.

Эцэст нь үс нь барагдан наргил модны самар мэт гялаан толгой

гарч ирэв.

Ирендира энэ явдлаас хойш хоёр долоо хоногийн хойно шар шувууны дуу дохиог сонстлоо Уллисын сургийг алдсан байв. Энэ мөчид эмэг эх төгөлдөр хуур тоглож, урьд эртийн дурсамжиндаа авган бодит ертөнцийг умартсан байв. Тэрбээр толгойдоо гял цал өд бүхий хиймэл үс углажээ.

Ирендира дээрх дохионд хариу өгснийхөө дараа төгөлдөр хуураас нарийхан утаа суунаглан гарахыг хараад бутан дундуур сүлжин харанхуйд уусан одов. Тэрбээр Уллисын байгаа газарт хүрэн бутан дунд зэрэгцэн нуугдаад харанхуйд хөх дөл сүүмэлзэн гүйсээр майханд орохыг харлаа.

-Чихээ тагла хэмээн Уллис хэллээ. Тэр хоёр хоёул чихээ тагласан нь хэрэг болсонгүй. Учир нь ямар ч дэлбэрэлт болсонгүй. Майхан дотор гэрэл мэлсхийснээ чимээ алдарч, тэгснээ цагаан тоос босон юу ч үзэгдэхгүй болов.

Ирендира эмэг эхээ лав үхсэн байгаа гэж бодсоор майханд зүрхлэн орвол цаадах нь амьд, амьдаар ч барахгүй бүтээлэг барьчихсан гал унтраахыг оролдож байх нь тэр.

Хиймэл үс нь түлэгдэж унтлагын хувцас нь урагдсан байх ажээ. Уллис эмэг эхийн харилцан авцалдаагүй зааварт мунгиналдах индианчуудын орилоон хашгираан дунд зугтаж одов.

Гал унтран утаа намдсан хойно л энэхүү явдлын учрыг ухацгааж эхлэв.

-Энэ бол ямар нэгэн хорлогчин шулмас шиг амьтны л хийсэн хэрэг. Төгөлдөр хуур ингэж дэлбэрдэггүй л юм даа хэмээн эмэг эх ярив.

Тэрбээр энэхүү шинэ гамшгийн учрыг олох гэж янз янзаар оролдсон ч Ирендирагийн гэмгүй номхон байдалд гайхширч орхив. Эмэг эхийн зан огт өөрчлөгдсөнгүй бөгөөд Уллисыг ч сэжиглээгүй ажгуу. Тэрбээр элдвийн таамаг гарган хүлээсэн хохирлоо тооцоолсоор үүр цайтал сэрүүн хэвтсэн ба тун бага, муу унтлаа.

Өглөө нь Ирендира алтан гулдмай бүхий хантаазыг нь тайлбал эмгэний мөр цэврүүтэж хөхнийх нь арьс түлэгдэн хуурсан байлаа.

-Би ч орондоо эргэж хөрвөөх шалтгаантай болсон шиг байна хэмээн тэр Ирендирад хэлээд өндөгний цагаан түрхүүлэхийг хүслээ. Эмэг эх түүнчлэн хачирхалтай зүүд зүүдэлснээ мэдэгдээд нилээд хүч гарган байж чухам юу зүүдэлснээ эргэн санав.

-Дүүжин орон дотор азарган тахиа байна гэж зүүдэллээ хэмээн тэр өгүүллээ.

Ирендира хэдий гайхсан ч гэмгүй царай гарган:

-Энэ бол сайны дохио. Учир нь азарган тахиа бол урт наслахын бэлэг тэмдэг шүү дээ хэмээн худал залав.

-Бурхан чамайг сонсох болтугай. Бид хоёр дахиад л нөгөө анхныхаа байдалд эргээд орлоо. Бүхнийг дахиад эхлэх болох нь хэмээн эмэг эх хэлэв. Ирендира үүнийг үл тоолоо. Түүнийг бигнүүр барин майхнаас гарахад эмэг эх цээжин биедээ өндөг шавуулж, нүцгэн толгойдоо гич түрхсэн амьтан үлдэв. Охин гал зуух болгон ашигладаг далдуу модон саравчин дотор бигнүүртээ өндөг хийж зогсоод орных нь ард Уллисын нүд гялалзахыг олж үзэв. Ирендира үүнд үл цочсон ч тамирдангуй дуугаар би чиний хийсэнд итгэхээ ч болих нь хэмээлээ.

Уллисын харц гунигийн мананд бүрхэгдлээ. Тэрээр огт хөдөлгөөнгүй чимээгүйхэн зогсож, өндөг хагалсаар буй Ирендираг зориуд үл тоож буй царай гаргав. Тэгснээ эгшин зуурын дараа харцаа шилжүүлэн гал зууханд буй өлгөөтэй тогоо, хоол амтлагчийн сав, махир балиуусыг гүйлгэн ажиглалаа. Уллис босон дув дуугүй саравчин дотор орж ирээд балиуусыг авлаа.

Ирендира түүнийг дахин хараагүй боловч саравчнаас гарахад нь

-Болгоомжтой байгаарай. Цаадах чинь үхлийн дохио авчихсан шүү. Цагаан дүүжин орон дээр азарган тахиа байна гэж зүүдэлсэн хэмээн маш нам дуугаар шивэгнэлээ.

Уллисыг балиус барьсаар орж ирэхийг эмэг эх үзээд ер бусын хүч гарган таягны дэмжлэггүйгээр өндийн босч гараа өргөөд:

-Хүү минь чи чинь галзуураа юу? хэмээн хашгирлаа. Уллис түүн дээр үсрэн мордож балиусаа нүцгэн цээж рүү нь шаалаа. Эмгэн татавгасхийснээ бүхэл биеэрээ түүнийг даран унагаад баавгайнх мэт хүчирхэг гараараа багалзуурдахыг оролдов.

-Жингэрийн зулбасага! Сахиусан тэнгэрийн дүртэй араатан байсныг чинь дэндүү хожуу мэдлээ дээ хэмээн тэр хяхатнан уухиллаа.

Тэр үүнээс илүү юм хэлж чадсангүй. Учир нь Уллис балиусаа сугалан авснаа хажуу талд нь дахин дүрлээ. Эмэг эх нэг том ёолон хүржигнээд довтлогчоосоо улам чанга зуурлаа. Уллис өрөвдсөн ч үгүй гурав дахиа дүрэхэд амтат бал мэт ногоон өнгөтэй тослог цус олгойдон гарч ирэв.

Ирендира хаалган дээр бигнүүрээ барьсаар зогсож, энэ тулалдааныг жишим ч үгүй тайвнаар харсаар зогсов.

Асар том махан бөмбөлөг мэт харагдах эмэг эх өвчин, хорсол хоёртоо бахардан уухилсаар Уллисыг тэвэрлээ. Түүний гар хөл, тэр бүү хэл халзан толгой нь хүртэл цусанд будагдан ногоорчээ. Үхлийн эхний давалгаатай учирсан эмэг эх томоор амьсгаадан уухичлаа. Уллис хутгатай гараа сугалан авч гэдсийг нь хүүлэхэд цус годогдон хөлнөөс нь толгойг нь хүртэл ногооноор будав. Эмэг эх толгойгоо сүүлчийн удаа өндийн амьсгал авахыг оролдоод нүүрээрээ газар шааж уналаа.

Уллис одоо л нэг хүч тамиргүй болсон гараас мултраад нэг ч хором хүлээлгүй сүүлчийн дүрэлтээ хийлээ.

Ирендира бигнүүрээ ширээн дээр тавиад эмэг эхийнхээ дээрээс тонгойн ажиглав. Тэгээд түүнийг нэгэнт үхсэнийг мэдмэгцээ царай нь эгшин зуур өөрчлөгдөн хорин жилийн золгүй амьдрал нь ч өгөөгүй тийм их хөгшин төрхийг олох нь тэр.

Тулалдан ноцолдож ядарсан Уллис цогцосны дэргэд суун нүүрээ цэвэрлэхийг оролдох боловч нэмэргүй агаад чингэж оролдох бүрдээ ногоон цусыг улам нялгадсаар эцэстээ хуруунаас нь савиран харагдах ажээ. Тэрбээр Ирендира алттай уутыг барин майхнаас гарч явахад л ялимгүй сэхээ орлоо.

Тэр охин руу хашгирсан авч хариу сонссонгүй тул босон салганасаар үүдэнд очоод Ирендира буудлаас зугтан тэнгисийн эрэг даган гүйж одохыг үзлээ. Тэр түүнийг зогсоох сүүлчийн оролдлогоо хийн дурлалт хүний ёсоор бус харин эмэгтэй хүнийг хэний ч туслалцаагүйгээр алсан гэмтний шаналалт дуугаар дуудлаа. Эмэг эхийн албат индианчууд түүнийг тэнгисийн эрэгт нүүрээ газарт шаан ганцаардаж айсандаа цурхиран уйлж байхад нь барьж авсан ажгуу.

Ирендира түүнийг сонссонгүй. Тэр салхи сөрөн гөрөөснөөс ч хурдан дэгдэж байсан ба хэн ч дуудсан зогсохооргүй байлаа. Ийнхүү тэрбээр тэнгисийн бараа далд орон ортол, элчилгүй их хуурай салхит цөл эхлэн эхэлтэл, хэзээ ч жаргадаггүй нарнаас цааш гүйсээр л байсан бүлгээ.

Охин тэгээд сураг ажиг алдарсан билээ.

Хиймэл сарнай

Мина үүрийн туяанд нүдээ гялбуулсаар шөнө нь орныхоо дэргэд бэлдэж тавьсан ханцуйгүй даашинзаа өмсөөд залгадаг ханцуйг нь эрэн чемодан онгичиж гарав. Гэвч олсонгүй тул хана, хаалганы ард хайж байхдаа өрөөнд унтаж буй сохор эмэг эхийгээ сэрээхгүйг хичээж байв. Гэвч түүнийг ханын шүүгээнд толгойгоо шургуулан эрлээ үргэлжлүүлэх зуур эмэг эх нь босчихсон байв. Тиймээс бүсгүй гал зуухны өрөөнд түүн дээр очин ханцуйгаа сураглав.

-Угаалгын өрөөнд байгаа. Би өчигдөр орой угаасан юм гэж сохор эмэгтэй хэлэв. Залгадаг ханцуй угаалгын өрөөний хэцэн дээр модон хавчаартай тохоостой байх аж. Гэвч нойтон байлаа. Мина гал зуух руу буцан очиж ханцуйг чулуун зуухан дээр хатааж эхлэв.

Сохор эмэгтэй түүний эсрэг талд кофе хутган суух агаад цийлгэр нүд нь довжоон дээрх эмийн ургамал тариалсан ваарнууд тийш чиглэсэн байлаа.

-Миний юмыг битгий аваад бай л даа. Ойрд нар гарахгүй байгаа шүү дээ гэж Мина хэлэв. Сохор эмэгтэй дуу гарсан зүг рүү нүүрээ хандуулан нээрээ өнөөдөр чинь их мөргөлийн өдөр гэдгийг би мартчихаж гэв. Тэгээд кофе буцалсан эсэхийг гүн амьсгаа аван үнэртэж үзээд тогооныхоо тагийг авлаа.

-Дор нь цаас тавьчих. Зуух бохир байгаа шүү гэж тэр хэлэв. Мина зууханд гараа хүргэж үзвэл бохир байсан ч халуунд хатуурсан хөө хувцсыг нь тортоглохооргүй байсанд бохир байх юм бол тантай ярина шүү гэлээ. Сохор эмэгтэй кофе аягалж аваад сандлаа довжоо руу чирэх зуураа, чи чинь уурлачихаа юу даа охин минь. Их мөргөлийн өдөр уурлавал алдас болно шүү гэлээ. Тэгээд довжоон дээрх сарнайн дэргэд суун кофегоо ууж эхлэв.

Мөргөлийн хонх гурав дахь удаагаа жингэнэхэд Мина ханцуйг зуухан дээрээс авч үзвэл нойтон хэвээрээ байлаа. Гэвч Мина өмсөж орхив. Яагаад гэвэл эцэг ламтан Анжел түүнийг мөрөө ил гаргасан хувцастай очвол адислахгүй гэдгийг тэр мэдэж байв. Мина нүүрээ ч угаасангүй, уруулын будагны үлдэгдлээ алчуураар хам хум арилган, мөргөлийн номоо шүүрч аваад гарч гүйлээ. Гэвч хорин минутын дараа эргээд ирэв.

-Чи уншлага дууссан хойно очиж дээ гэж сохор эмэгтэй хэллээ.

Мина шуудхан жорлон руу зүглэнгээ би мөргөлд очиж чадашгүй нь. Ханцуй нойтон. Дээр нь хамаг хувцас үрчинхий байна гэж үг хаялаа. Ингэхдээ тэр өөрийг нь дагуулан харж буйг мэдэрч байв.

-Их мөргөлийн эхний өдөр сүмд очихгүй байх ч гэж дээ хэмээн сохор эмэгтэй халаглалаа.

Мина жорлонгоос гарч ирээд өөртөө кофе аягалж аваад сохор эмэгтэйтэй зэрэгцэн суулаа. Гэвч тэр кофегоо ууж чадсангүй, та л буруутай хэмээгээд нулимс мэлтэлзүүлэв.

-Чи уйлаад байгаа юм уу хэмээн сохор эмэгтэй уулга алдлаа. Тэр цэцэг усалдаг савыг газарт тавиад цааш явах зуураа чи уйлаад байна аа даа хэмээн давтлаа.

Мина аягаа шалан дээр тавиад, би уурлаад л ингэж байна гэснээ босож эмэг эхийнхээ хажуугаар өнгөрөх зуур танаас болж би их мөргөл тасаллаа, та тийм болохоор нүгэл наманчлах бүхээгт очих хэрэгтэй гэлээ.

Сохор эмэгтэй Минаг унтлагын өрөөний хаалга хаатал хүлээгээд буцан явж газар тэмтрэн аягаа олж авлаа. Тэгээд кофег асгах зуураа, намайг нүгэлгүй гэдгийг бурхан тэнгэр мэднэ дээ хэмээв.

Энэ үеэр Минагийн ээж унтлагын өрөөнөөс гарч ирээд, та хэнтэй яриад байна аа гэж асуулаа.

-Хэнтэй ч биш ээ. Би галзуурч эхлээд байгаагаа та нарт хэлээ биз дээ гэж сохор эмэгтэй хариулав.

Өрөөндөө орж сэтгэл нь тайвширсан Мина банзлынхаа товчийг мулталж дотор талд нь битүү зүүнд холбож бэхэлсэн гурван түлхүүр гаргаж ирлээ. Тэгээд ширээний доод шургуулгыг нэгээр нь онгойлгон бяцхан модон хайрцаг гаргаж авав. Дараа нь хоёр дахь түлхүүрээр уг хайрцгийг онгойлгон дотроос нь утсаар багласан боодол цаас аваад шургуулгыг эргүүлэн түгжлээ.

Охин цааснуудыг банзалдаа нууж очоод жорлонд хаялаа.

-Чамайг чинь сүмд л байгаа гэж бодлоо хэмээн ээж нь түүнийг гал зууханд очиход хэлэв. Тэр яваагүй хэмээн сохор эмэгтэй хажуугаас нь хэлээд би өнөөдөр их мөргөлийн өдөр гэдгийг мартаад ханцуйг нь угаачихсан юм гэж үргэлжлүүлээ.

-Одоо ч гэсэн нойтон л байна даг хэмээн Минаг бувтнахад би ийм мөргөлийн үед мөн ч их ажил амжуулдаг сан гэж сохор эмэгтэй хүүрнэв.

-Тэгвэл би өнгөрсөн зул сараар зөндөө л олон цэцэг аваачсан даг.

Тэр өдөр яагаа ч үгүй халуу шатлаа. Мина долоон цагаас өмнө хиймэл цэцгийн лангуугаа дэлгэж, хээтэй цаас, дамартай утас, хоёр хайч, цавуу тэргүүтэн бүхий хайрцгаа нээв. Удалгүй Тринадад гутлын хайрцаг сугавчилсаар ирээд яагаад мөргөлд очоогүйг нь сонирхов.

-Ханцуй байдаггүй гэж Мина хариулав.

-Нэг хүнээс гуйгаад авчихгүй дээ.

Мина сандал авчран Тринададтай зэрэгцэн суугаад харин хэтэрхий оройтчихсон байна лээ гэлээ. Тэрээр сарнайн дэлбээ хийж дуусгаад ишийг нь сүлжиж эхлэв. Тринадад ч гутлын хайрцгаа хойш тавин газар сууж хамтарлаа. Мина найзынхаа хайрцгийг харан, чи гутал худалдаж аваа юу гэлээ.

-Гутал ч гэж дээ үхсэн хулгана шиг юм байгаа даа.

Тринадад нэхэж сүлжихдээ гаргуун тул Мина түүгээр ногоон цаасан гинж хийлгэдэг билээ. Тэр хоёр юу ч ярилгүй ажилдаа мэрийн суусаар гэр бүлийн даруухан гэрэл зургуудаар ханыг

нь чимсэн том өрөөнд халуу шатаж эхлэхийг сая л анзаарав. Мина нэг юм хэлэх гэсэн янзтай Тринададыг ширтлээ. Тринадад ажлаа зогсоов.

-Юу болчихоов?

Мина урагш бөхийлөө.

-Нөгөөх чинь яваад өгсөн.

Тринадад гайхсандаа хайчаа доош алдаж:

-Үгүй байлгүй дээ гэлээ.

-Тийм ээ. Явчихсан.

Тринадад Минаг нүд үл цавчлан ширтэхэд өтгөн хөмсөгнийх нь завсар тод босоо зураас үзэгдэх аж

-Тэгээд одоо яах вэ? хэмээн тэр шалгаав.

-Одоо бүх юм өнгөрсөн.

Мина бүгтхэн хоолойгоор ийн хэлсэн ажгуу.

Тринадад арван цагт явж одлоо.

Мина хайрцагандаа үхсэн хулгана хийгээд жорлонд хаяхаар зүглэлээ. Энэ үеэр сохор эмэгтэй сарнайн бут арчилж суулаа. Мина хажуугаар нь өнгөрөхдөө, та энэ хайрцаганд юу байгааг таахгүй гэж мөрийцье л дээ хэмээгээд хайрцгийг сэгсэрлээ. Сохор эмэгтэй толгойгоо гилжийлгэн гараа чихэндээ аваачаад дахин гурван удаа чагнасан ч таасангүй.

-Өнгөрсөн шөнө сүмийн хавханд орсон хулганууд байгаа юм гэж Мина хэллээ.

Түүнийг өрөөндөө буцаж ороход сохор эмэгтэй араас нь дагалаа. Мина цонхныхоо дэргэд суун нэгэн сарнай урласаар бараг дуусах дөхөж байх аж.

-Мина! Чи аз жаргалтай амьдаръя гэвэл хөндлөнгийн танихгүй хүнд сэтгэл алдаад хэрэггүй дээ хэмээн сохор эмэгтэй өгүүлээд дөхөн сууж ажлаас нь хамжилцахыг хүслээ. Харин Мина түүнээс тусламж авахыг түвдсэнгүй.

-Охин минь сэтгэл санаа чинь нэг л тавгүй байна аа даа. Чи яагаад мөргөлд очоогүй юм бэ?

-Та мэдэж л байгаа шүү дээ.

-Хэрэв тэр ханцуйнаас болсон бол чи гэрээсээ ч гарахгүй байсан. Хэн нэг нь гадаа чамайг хүлээж уулзаад санааг чинь үймүүлчихэв ээ дээ янз нь. Мина эмэг эхийнхээ нүдний өмнүүр шил арчих мэт гараа савчаад та ч үзмэрч юм даа гэлээ.

-Чи өнөө өглөө хоёр ч удаа жорлонд орлоо. Уг нь нэгээс илүү явдаггүйсэн гэж сохор эмэгтэй хэллээ.

Мина чимээгүйхэн сууж сарнайгаа урлах аж.

-Чи шүүгээний доод шургуулганд нуусан юмаа үзүүлэхгүй юм уу?

Мина яаралгүйхэн хөдөлж хиймэл сарнайгаа цонхны хүрээнд өлгөөд банзлаа сөхөн мөнөөх гурван түлхүүрийг гарган эмэг эхийнхээ алган дээр тавьлаа.

-Та очиж өөрийнхөө нүдээр харахгүй юу гэж охин хэллээ.

Сохор эмэгтэй түлхүүрүүдийг хурууныхаа өндгөөр тэмтрэн үзэж байснаа миний нүд жорлонгийн ёроол дахийг харж чадахгүй л дээ гэжээ.

Мина толгойгоо өргөснөө сохор эмэгтэй түүний харцыг мэдрээд буйг гэнэт ойлгов.

-Миний хийсэн юм тийм сонин санагдаад байгаа юм бол жорлон руу үсрэхгүй юу.

-Чи шөнө орондоо үргэлж л юм бичиж байх юм.

-Гайгүй байлгүй. Та өөрийн гараар гэрэл унтраадаг биз дээ.

-Гэхдээ чи дороо л гар чийдэн асаачихдаг шүү дээ. Би юм бичиж байгааг чинь амьсгалаар чинь мэддэг юм.

Мина тайван байхыг хичээж байв.

-Яахав тийм байдаг байж хэмээн тэр толгойгоо өндийлгөлгүй хэлээд тэгсэн гээд сонирхмоор юм юу болоов гэж үргэлжлүүлэв.

-Юу ч болоогүй л дээ. Гэхдээ тэрнээс болоод их мөргөл тасалчихлаа даа.

Мина дамартай утас,хайч, цавуу, хараахан дуусаагүй иш болон навч, дэлбээг хоёр гараараа хаман авч сагсанд чихээд сохор эмэгтэйд хандлаа.

-Тэгвэл намайг яах гэж жорлонд очсон гэж бодоов? хэмээн Мина асуулаа.

Хэн ч дуугарсангүй. Өрөөнд хэсэг нам гүм байсны эцэст охин өөрөө өөрийнхөө асуултын хариу болгож би бие засах л гэж жорлонд очсон юм даа хэмээлээ.

Сохор эмэгтэй гурван түлхүүрийг сагс руу шидээд босч гал зуух руу явах зуураа, охин минь чиний ам өчгийг анх удаа сонсож байгаа биш дээ би гэж гэвтнөлөө.

Удсан ч үгүй Минагийн ээж гартаа урж, тасчсан баахан хиймэл цэцэг барьсаар гарч ирснээ хүүе таминь юу болоод байна аа гэлээ.

-Би галзуурчихаад байна аа. Өөрсөд рүү нь чулуу нүүлгэхээс нааш намайг галзуугийн эмнэлэгт аваачихгүй улс юм даа та нар хэмээн сохор эмэгтэй хэлсэн бүлгээ.

Нэгэн өдрийн явдал

Даваа гаригийн өглөө бороо орсонгүй халуухан өдөр болох шинжтэй байв. Шүдний эмч Аурелио Эсковар туйлын эртэч хүний хувьд эмнэлгээ зургаан цагт онгойлгов. Тэгээд шилэн саван дахь гипсэн хэвнээс хиймэл шүднүүд авч багажнуудаа ширээн дээр үзмэр мэт нямбайлан эгнүүлж тавьлаа. Эмч хоолойдоо алтан товчтой захгүй цамц өмсөн, өмдөө мөрөвчилжээ. Энэ хүн бол өндөр туранхай биетэй, шарангуй царайтай нэгэн агаад бусдад чих хатуутай хүн шиг санагдах нь бий.

Тэрбээр ширээн дээрхээ цэгцэлж дуусаад сандлаа өрөм рүү дөхүүлж хиймэл шүд өнгөлөх ажилдаа орлоо. Мань хүн хөлөөрөө өрөмний гишгүүрийг товшин нямбай, шургуу ажиллах аж.

Найман цагаас өмнөхөн ажлаа зогсоож цонхоор гадагш харвал байшингийн дээврийн шон дээр хоёр бялзуухай ноолойн сууж биеэ хатааж буй нь үзэгдэв. Тэгээд үдээс хойш борооших нь дээ гэсэн бодолтойгоор ажлаа үргэлжлүүлж байтал арван нэгтэй хүүгийнх нь цангинасан дуу анхаарлыг нь сарниуллаа.

-Аав аа!

-Аан.

-Тосгоны дарга шүдээ авахуулах гэнэ ээ.

-Намайг алга байна гэж хэл.

Тэр энэ удаа алтан шүд өнгөлж байв. Гараа сунган хийж буй зүйлээ нүд онийлгон шалгах аж. Хүү нь хүлээлгийн өрөөнөөс дахиад л хашгирлаа.

-Тэр таныг энд байгааг дуугаар чинь мэдэж байна гэнэ ээ.

Шүдний эмч алтан шүдээ яаралгүйхэн шалгаж дуусаад тэр тусмаа сайн даа хэмээн өгүүллээ.

Ингэснээ өрмөө дахин ажиллуулж, цаасан хайрцагнаас хиймэл шүдний нарийн ширийн зүйлсийг гарган аваад өмнөхөө үргэлжлүүлэв.

-Аав аа!

-Юу гэв?

-Тэр шүдийг нь авч өгөхгүй бол таныг буудна гэж байна.

Аурелио Эсковар тайван боловч сурмаг хөдөлгөөнөөр өрмөө товшихоо зогсоон сандлаасаа холдуулаад шүүгээнийхээ доод шургуулгыг татлаа. Тэнд нь гар буу байх ажээ.

-За тэгвэл орж ирээд бууд гэж түүнд хэлээтэх.

Тэр сандлаа хаалганы эсрэг байрлуулаад харцаа гар буун дээрээ тусган хүлээлээ.

Тосгоны дарга орж ирлээ. Дарга нэг хацрынхаа сахлыг хуссан боловч өвчиндөө хандаж пэмбийсэн нөгөө хацрынх нь сахал арзайтлаа ургасан харагдав.

Шүдний эмч түүний нүднээс олон шөнийн шаналгаа олж үзээд ширээнийхээ шургуулгыг хуруугаараа түлхэн хаагаад, суугтун хэмээн зөөлхөн хэлэв.

-Өглөөний мэнд хэмээн тосгоны дарга хэллээ.

-Өглөөний мэнд.

Багажнууд ариутгах зуур дарга сандлын ивүүрт толгойгоо налан хэвтлээ. Ингэхэд өвчин нь намдах шиг болов. Эмчийн өрөө модон сандал, гишгүүрт өрөм, хуруу шилнүүд дотор нь хийсэн шилэн хайрцаг төдийхөнтэй даржин газар аж. Сандлын эсрэг талд босоо хүний өндөртэй хөшиг бүхий цонх харагдав.

Тосгоны дарга эмчийг дөхөж ирэхэд хөлөө жийн чангалж, амаа ангайлгалаа. Аурелио Эсковар доош тонгойн өвчилсөн шүдийг шалгаж дуусаад эрүүг нь гараараа болгоомжтой түлхэн амыг нь хамхиуллаа.

-Уг нь ч хорхойтоогүй л юм байна.

-Яагаад тэгвэл...

-Яагаад гэвэл буйл чинь бугласан байна.

Тосгоны дарга дээш өлийн эмчийн нүд рүү харж, за за гэж хэлээд инээмсэглэхийг оролдлоо. Харин эмч хариу инээмсэглэсэнгүй аажуухан хөдөлж ажлын ширээ рүү ариутгасан багажаа авчран дотроос нь хоёр хямсаа авлаа. Тэгснээ шүлс хаядаг савыг өлмийгөөрөө түлхэн өвчтөнд дөхүүлээд угаагуурт гараа угааж эхлэв.

Тэрбээр энэ бүх хугацаанд тосгоны дарга руу нэг ч удаа харсангүй. Харин дарга түүнээс харц салгахгүй байв.

Өвчилсөн шүд нь доод эрүүний соёо байж таарав. Шүдний эмч хөлөө алцайлган зогсоод мөнөөх шүдийг бахиараа хавчиж авлаа. Тосгоны дарга сандлын түшлэгийг хоёр гараараа зууран биеэ хөвчилж, хөлөө газарт байдгаараа жийхэд бөөр рүү нь хүйт оргиж байв. Гэхдээ ямар нэгэн дуу гаргасангүй.

Шүдний эмч түүний нэг гарыг түлхэн жаахан зайлуулснаас өөр заавар өгсөнгүй. Тэгснээ занасан гэхээс илүү тохуурхсан өнгөөр, за хө чи одоо манай тосгоны хорин залуугийн амийг төлөх цаг ирлээ дээ гэлээ.

Тосгоны дарга яс шажигнахыг эрүүгээрээ мэдрэн нулимс нь цийлэгнэж ирлээ. Гэвч тэр шүдээ сугаран сугартал амьсгаа аваагүй бүлгээ. Дараа нь мөнөөх шүдээ нулимстай нүдээр харвал хөгийн юм харагдсан тул бүхэл бүтэн таван шөнө тарчилсан шалтгаанаа ойлгомооргүй

болж ирэв. Хөлс нь цутгаж, мэнчийж улайсан тэр хүн доош тонгойн шүлсээ хаяад дүрэмт хувцасныхаа доод товчийг мултлан нусны алчуураа бэдэрлээ.

Эмч түүнд цэвэр алчуур авч өглөө. Тэгэхдээ май нулимсаа арчиж үз гэж хэлсэн ажгуу. Тосгоны дарга хэлснээр нь болголоо. Зүрх нь цохилон бие нь чичирсэн байх аж. Тэрбээр шүдний эмчийг гараа угаах зуур тааз хэрхэн цуурсныг тэнд шороонд даруулсан үхсэн шавьж хорхой шаваастайг ажиглав.

Аурелио Эсковар гараа угааж дуусаад түүн рүү эргэн харж, унтаж амар, харин амаа давстай усаар сайн зайлаарай гэлээ.

Тосгоны дарга босон цэргийн хүний ёсоор баяртай хэмээн зангаад дүрэмт хувцасныхаа доод талыг товчлоогүй чигээр үүд рүү зүглэв.

-Нэхэмжлэхээ явуулчихаарай гэж тэр шүдний эмчид хандлаа.

-Өөр рүү чинь үү эсвэл захиргаа руу юу?

Тосгоны дарга эмч рүү харалгүй чигээр гарч хаалга хаасан хойноо салхивчны завсраар, за хааш нь ч байсан яалаа, адилхан нохойн баас юм чинь гэсэн авай.

Алдагдсан цагийн тэнгис

Нэгдүгээр сарын сүүлчээр тэнгис улам догшрон давалгаалж, хамаг хог новшоо гаргаж хаясан тул хэдхэн долоо хоногт л тосгон тэр чигээрээ бохиртон заваарч хэн хүний сэтгэл гансармаар болов.

Үүнээс хойш 12-р сар хүртэл энд хүн байхын аргагүй байдаг гэгцгээх бөгөөд тэр өглөөний найман цаг өнгөрчихөөд байхад орноосоо өндийсөн нэг ч амьтан алга байлаа.

Ноён Хербертийн ирдэг тэр жил тэнгисийн ааш аяг огтхон ч өөрчлөгдөлгүй хоёрдугаар сар дуусав. Харин түүнээс хойш арай жаахан зохирч гуравдугаар сарын эхний хэдэн өдөрт сарнай цэцгийн үнэр анхилсан амой. Тобиас анх энэ үнэрийг мэдэрсэн хэрэг. Тэр шөнийн хагаст цусанд нь амтархсан хилэнцэт хорхойнуудтай үзэлцсээр үүрийн сэрүүнээр л жаахан унтаж авчээ. Мань хүн шөнийн уртад сэрүүссэнийг нь мэдэх тул хэвгэж байхдаа агаар хэрхэн өөрчлөгдөхийг анзаарч сурчээ. Ийм ч учраас сарнайн үнэр анхилахад тэнгисээс үнэртсэн эсэхийг нь шалгаж хаалгаа ч нээсэнгүй өглөө нь оройхон өндийлээ.

Тэгэхэд Клотильда хашаан дотор гал түлж байв. Гадаа хүйтэн, од мичид огжоогүй, тэнгисийн гэрэлд төдийлөн сүүмийн харагдах ажээ.

Тобиас кофегоо уусны хойно тагнайд нь урьд шөнийн үнэр, амт үлдэж хоцорсныг мэдэрчээ.

Урьд шөнө ч сонин юм болох шиг боллоо гэж тэр өгүүлэв. Харин Клотильда мөнөөх үнэрийг мэдээгүй өнгөрсөн хэрэг. Тэрээр зүүдээ ч санахааргүй бөх унтсан юмсанж.

-Сарнай цэцгийн үнэр гарсан шүү. Тэнгисээс л ханхалсан даа хэмээн Тобиасын ярихад, би сарнай яаж үнэртдэгийг ч мэдэхгүй гэж Клотильда хариулав. Клотильдагийн зөв байхад гайхах ч юм алга байлаа. Учир нь тосгоны хавийн газар хүчилд идэгдэн цөлжсөн тул тэнгист талийгаачдаа оршуулагсад л хааяа нэг сарнай олж ирэн хөвүүлдэг бүлгээ.

Нөгөө Гуактаялаас авчирч тэнгист оршуулсан хүнээс ханхалж байсан шиг үнэр гарсан даа хэмээн Тобиас хэллээ.

За яахав, тийм л биз хэмээн Клотильда инээвхийлээд хэрвээ сайхан үнэр бол тэнгисээс л лав гарахгүй дээ гэлээ. Тэнгис ч үнэндээ хэцүүхэн нь үнэн юм. Зарим үед загасчдын торонд уснаа хөвж явдаг элдэв хогноос өөр юм торохгүй байхад давалгаанаар шидэгдсэн үхсэн загасны сэгэнд тосгон даруулах шахдаг аж. Усан дор тэсэлгээ хийгээд ч нэмэргүй, сүйрч сүйдсэн онгоц, завины хэмхэрхий л үзэгдэхээс өөрцгүй үе зөндөө тохиолддог авай.

Тосгонд үлдсэн хэдхэн эмэгтэйчүүд Клотильдагийн адилаар өглөөний цайгаа чанаж байв. Тэдний нэг Якоб өвгөний самган тэр өглөө ердийнхөөсөө эрт босч гэр орноо янзлаад цайгаа уухаар суухдаа сургагч, зөвлөгчийн дүртэй харагдаж байв. Тэрбээр нөхөртөө хандан,

-Миний сүүлчийн хүсэл бол амьдаараа оршуулуулмаар байна хэмээн мэдэгдлээ.

Эмгэн энэ үгийг хоногоо хүлээн хэвгэрт хадагдсан хүний янзаар нухацтайяа хэлсэн боловч

үнэндээ бол гуравдугаар сарын нар цонхоор нь гэрэлтсэн гал тогооныхоо өрөөнд хоолны ширээний ард сууж байсан хэрэг. Эсрэг талд нь өвгөн Якоб цайгаа ууж суух агаад эхнэрээ маш их хайрладаг тул сэтгэл санааг нь зовоох ямар ч зүйлийг үл түвдэх эр хүн юм.

Намайг хүн шиг хүний ёсоор газрын хөрсөнд оршуулбал би санаа амар нүд анимаар байна хэмээн эмгэн нь өгүүлээд үүнийг үзэхийн тулд намайг амьдаар минь оршуул гэж хүмүүсээс гуйх хэрэгтэй байна гэж үргэлжлүүлэв.

Чи хэнийг ч гуйх шаардлагагүй. Би өөрийнхөө гараар бүгдийг хийнэ хэмээн өвгөн Якоб аядуухан дуугарав. Тэгвэл бэлдэх л хэрэгтэй, би тун удахгүй үхнэ хэмээн эхнэр нь хэлэв.

Өвгөн Якоб түүнийгээ тун чиг анхааран харлаа. Эхнэрийнх нь нүд л залуугаараа үлдсэн юм. Түүнийх нь мах шуугдан, яс нь горзойсон, тариа тарихаар модыг нь огтолсон талбай шиг л болсон байлаа.

-Чи өмнөхөөсөө илүү тэнхлүүн байна шүү дээ хэмээн өвгөн хэлэхэд өнгөрсөн шөнө би сарнайн үнэр үнэртлээ гээд эмгэн санаа алдав.

-Битгий тоо хө. Бидэн шиг ядуу дорой улсад тийм юм байнга л тохиолддог шүү дээ хэмээн өвгөнийг ятгах аятай ярихад, тийм биш ээ гэж эмгэн эсэргүүцээд, энэ тэнгисээс холхон очиж үхэхийн тулд нөгөө ертөнцөд очих цагийг минь мэдүүлж өгөөсэй гэж би үргэлж залбирч ирсэн юм. Энэ тосгонд сарнай үнэртэнэ гэдэг бол зөвхөн Бурханы зар л байж таарна гэлээ.

Энэ явдлын учрыг олж, хужирыг тунгаахад хугацаа хэрэгтэй хэмээн хөгшин Якоб бодлоо. Хүмүүс хүссэн үедээ биш харин цаг нь болохоор үхдэг гэдгийг тэр зөндөө сонссон ч эмгэнийх нь зөгнөл санааг нь бүр зовоож орхив. Тэр ч бүү хэл тийм юм боллоо гэхэд эхнэрээ амьдаар нь оршуулах болох нь уу гэж гайхан бодсон хэрэг.

Якоб өвгөн есөн цагт урьд өмнө нь дэлгүүр байсан байрыг онгойлгон хоёр сандал, тавцан дээрээ даамны буудалтай ширээ оруулж тавиад тэр хавиар явсан хүмүүстэй наадаж эхлэв.

Тэрээр наранд гандан өнгөө алдан эвдэрч нурсан тосгон болоод гудамжны адагт цухалзах тэнгисийг ажиглаж суулаа.

Тэр үдийн цайны өмнө заншил ёсоор Дон Максимо Гомезтой тоглолоо. Өвгөн Якобын хувьд хоёрын хоёр иргэний дайныг эв эрүүл, сав саруул туулаад гурав дахид нь өрөөсөн нүд төдийгөө алдсан ийм баатар эртэй тоглох нь нэр төрийн хэрэг ажгуу.

Өвгөн нэг тавилд шүүгдэн нөгөөд нь хожсоныхоо дараа

-Дон Максимо! Та ер нь эхнэрээ амьдаар нь оршуулъя гэвэл чадах уу? гэж асуувал:

-Чадалгүй дээ. Ёстой гар минь ч чичрэхгүй дээ хэмээн цаадахь нь хариулав.

Якоб өвгөн бяцхан гайхширч чимээ алдсанаа:

-Петра минь нүд аних нь шиг байна гэж санааширлаа.

-Ийм юм болбол амьдаар нь оршуулах ямар ч шаардлагагүй хэмээн Дон Максимо Гомез аанай л мөнөөх янзаараа хэллээ. Тэр хоёр хүү идэн даам гаргасныхаа дараа ус гүйлгэнэсэн гунигт нүдээрээ түүнийг ширтэн:

-Цаадах чинь тэгээд яачихаав? гэлээ.

-Өнгөрсөн шөнө сарнайн үнэр үнэртсэн гэнээ хэмээн өвгөн Якоб тайлбарлалаа. Тэгвэл тосгоны хагас нь талийгаач болох нь дээ хэмээн Дон Максимо Гомез дуугараад өнөө өглөө хүн болгон л ийм юм яриад байгаа шүү дээ гэх нь тэр.

Түүнд мэдэгдэлгүй худлаа хожигдох нь өвгөнд хэцүү байсан тул мань хүн ширээ сандлаа хурааж, дэлгүүрээ цоожилж орхиод сарнай үнэртэгсдийг олж уулзлаа.

Гэтэл энэ тухайд хамгийн итгэлтэй байгаа хүн нь Тобиас болж таарав. Тиймээс өөрийнхөө эмгэнтэй санаандгүй тааралдсан хүн болж уулзаад сарнайн үнэрийн тухай сайтар ярьж өгөхийг Тобиасаас өвгөн гуйв.

Тобиас ч хүссэнээр нь хийлээ. Тэрээр дөрвөн цаг гэхэд амралтын өдрийнхөө хамаг гоёлыг өмсөж зүүгээд, өөрийнх нь авгай үдээс хойшжингоо хувцас хунар оёж шидсээр буй довжооны дэргэд зогсож байлаа.

Тэр чив чимээгүй ирсэн тул эмгэнийг цочоож орхив. Өө золиг гэж хэмээн эмгэн уулга алдаад чамайг ч сахиусан тэнгэр заларлаа л гэж бодлоо гэв.

Би л байна шүү дээ, танд нэг юм хэлэхээр ирлээ хэмээн Тобиасыг өгүүлэхэд, за яршиг би мэдэж л байна гэж эмгэн өмнөөс нь өгүүлэв.

-Та мэдэхгүй ээ. Мөрийцсөн ч яахав.

-Чи урьд шөнө сарнай цэцгийн үнэр үнэртээ биз дээ?

-Хүүе та яаж мэдээв хэмээн Тобиасыг гайхахад би өдий наслахдаа жирийн хүн ч мэргэн зөнч болж болно гэдгийг л ойлгосон юм даа хэмээн эмгэн намжирдав.

Энэ яриаг дэлгүүрийн арын хананы цаанаас сонссон өвгөн Якоб тэрүүхэндээ ичингүйрсхийн саатлаа.

-Хөөе эзэгтэй минь гэж тэр тэндээсээ хашгираад нөгөө чиний бодсон биш л байгаа биз дээ гэлээ.

Эмгэн толгойгоо ч өндийлгөсөнгүй:

-Энэ банди худлаа ярьж байна аа. Юу ч үнэртээгүй байж таарна хэмээв.

Үгүй ээ болсон доо. Арван хоёр цагийн үед. Би хилэнц хорхой хөөж байсан юм гэж хариуд нь Тобиас зүтгэлээ.

Худал үг, чамайг жүжигчин гэдгийг хүн бүхэн мэднэ хэмээн цамцны зах цардсаныгаа хойно эмгэн мэдэгдэв. Тэр эмэгтэй ингэж хэлээд Тобиасыг нүдний шилэн дээгүүрээ духайн харах ажээ. Тэгснээ:

-Чи хө намайг хуурах гэж л үсээ вазелиндаж, гутлаа тослоо юу хэмээлээ.

Энэ явдлаас хойш Тобиас тэнгис ширтэн суудаг зантай болов.

Тэр хашаандаа дүүжин ороо засч аваад хүмүүсийг унтаж байхад орчлон хорвоо дээр болж өнгөрдөг элдэв сонинг гайхан гайхан шөнийг хагаслах авай. Тэр олон шөнө хилэнцэт хорхойнууд хэрхэн мурчиганан гүйлдэж, байшингийн эзэд хумсаа дуугарган тэднийг хэрхэн ангуучлах, эцэстээ тэгж оролдохоо болин залхахыг хүртэл олж сонсчээ.

Мөн Клотильда хэрхэн унтдагийг ч тодорхой мэдэж авав. Клотильда бишгүүрдэх мэт хурхирах нь үдэш эртийн бүгчимд зовиуртай мэт байдаг ч яваандаа өөрчлөгдөн зургадугаар сарын нозоором нам гүмийн нэг хэсэг болон жигдэрдэгийг тэр анзаарлаа.

Тэр юм мэддэг хүний ёсоор тэнгисийн мандлын зөвхөн ганц цэгийг л удтал тогтоон харж, өнгөө хэрхэн өөрчлөхийг нь ажиглаж байв.

Тэнгисийн өнгө бүдгэрэн ус нь улам хөөсөрхөг болж, шуурга зөгнөн оволзохыг харж байлаа. Сүүлдээ ийн ажиглахдаа сүрхий гаршин унтаж байхдаа ч тэнгисийг мартахгүй болж ирэв.

Өвгөн Якобын эхнэр наймдугаар сард өөд болов. Тэр эмэгтэй нойрон дундаа бие барсан ба түүнийг бусдын л адил цэцэг навч бараа сураггүй тэнгисийн усанд оршууллаа.

Харин Тобиас өөрийн цагийг хүлээсээр л. Сүүлдээ чингэж хүлээх нь амьдралынх нь утга учир болж эхэлсэн ажгуу. Нэгэн шөнө тэр дүүжин орондоо дугжирч байхдаа агаарт ямар нэгэн өөрчлөлт гарахыг мэдэрлээ.

Энэ бол тэртээ дээр цагт боомтын эхэнд орж ирсэн Японы усан онгоцны ялзарсан сонгинотой чингэлгүүдийг живүүлэхэд замхраад л дахин бий болоод байсан шиг тийм үнэр аж. Сүүлдээ мөнөөх үнэр улам хурцадсаар тогтож орхив.

Зөвхөн үүний дараа л Тобиас орноосоо зүрхлэн өндийж Клотильдаг сэрээхээр мөрнөөс нь дугтарлаа.

-За нөгөөх чинь боллоо доо гэж тэр өгүүллээ. Клотильда аалзны тор шүүрдэж байгаа юм шиг мөнөөх үнэрийг гараа савчуулан арилгах дүр үзүүлээд бүлээн дэр рүүгээ шургангаа бурхан л мэдэг хэмээлээ.

Тобиас гудамжинд гаран хашгирч эхэллээ. Тэр бүр хамаг тэнхээгээрээ хашгирлаа. Эргэн тойрон ажин түжин. Дахин амьсгаа аваад дахин хашгирлаа. Агаарт мөнөөх үнэр анхилсан хэвээрээ л байлаа.

Харин тосгон мөн л дүлий дүмбэ байх тул Тобиас айл айлын хаалгыг балбаж гарав.

Тэрээр эзгүй байшингуудыг хүртэл очиж нүдсэн агаад сая л ноход хуцалдан хүмүүс сэрж эхлэв.

Гэхдээ олон хүн уг үнэрийг мэдэрсэнгүй. Харин бусад нь нэн ялангуяа хөгшид энэ үнэрийг улам сайн үнэртэхээр тэнгис рүү очицгоов. Энэ бол өмнөх үнэрүүдийг мартагдуулам ер бусын төгс үнэр байсан ажгуу.

Зарим хүмүүс үнэртэж ханаад гэртээ харьж,бусад нь тэнгисийн эрэгт унтахаар шийдэцгээв.

Үүрээр өнөө үнэр амьсгалахад ч харамсмаар онцгой сайхан боллоо.

Тобиас тэр өдөржингөө унтлаа. Клотильда тэр хоёр үдийн амралтаар нийлж аваад хашааныхаа хаалгыг ч хаасангүй, өдөржингөө орондоо үнгэлдэж өнгөрөөв. Тэр хоёр эхлээд чийгийн улаан хорхой мэт удаан янаглангуй, дараа нь туулай мэт хурдан түргэн, сүүлдээ яст мэлхий мэт залхуутай гэх мэт янз янзаар загас наадуулсан бүлгээ.

Тэднийг чингэж буй ахуйд хөгжмийн аялгуу үе үехэн сонсогдох агаад үүнийг Катаринагийн тэндээс дуулдаж байна хэмээн Клотильда өгүүлээд тосгонд хэн нэгэн нь ирж дээ гэж таамаглалаа.

Үнэхээр ч гурван эр, нэг эмэгтэй ирсэн аж. Катарина өөр хүмүүс ч нэмэгдэж ирнэ гэж тооцоолоод бягтруулаа засахыг оролдсон ч барсангүй Панчо Апаресито гуйхад хүрэв.

Панчо Апаресито бол хохь хоосон ядуу хүн тул бүх юманд оролцдог ч авах юм нь алтан гартай басхүү өөрийн гэсэн багажтай хүн билээ.

Катаринагийн гэр бол бусдаас онцгойдуухан тэнгис рүү харсан модон байшин бөгөөд дотроо вандан сандал, жижигхэн ширээ бүхий том өрөө болон хэд хэдэн унтлагын өрөөтэй юм.

Тэнд байсан гурван эр, нэг хүүхэн Пансо Апареситогийн бягтруултай ноцолдохыг харан чимээгүйхэн эвшээлгэх зуураа чимээгүйхэн ууцгааж суув.

Бягтруул ч нилээд оролдсоны дараа ажиллаж эхэллээ. Хүмүүс хөгжмийн бүгдхэн боловч содон аялгуу дуурсахад яриагаа зогсоов.

Тэд биенээ хоромхон зуур ээлжлэн харахдаа ямар нэг юм хэлээгүй ч хэзээ нэгэн цагт энэхүү хөгжмийг сонсож байснаасаа хойш хичнээн их өтөлж өвгөрснөө мэдэрцгээсэн авай.

Орой есөн цаг гэхэд хэн ч унтсангүй, Катаринагийн хуучин пянзнуудыг сонсон нар хиртэхийг үзэж буй хүүхэд адил түгшүүртэйхэн догдлонгуй сууцгаах ажээ. Пянз болгон нь хэн нэгэн талийгаачийг ч юмуу аль эсвэл удтал өвдсөний дараа идсэн амтат хоол, маргааш хийхээр хойш тавиад мартаж орхисон ажил үйл зэргийг санагдуулах авай.

Хөгжим 12 цагийн үед зогсож, тэнгис дээгүүр бүрхсэн үүлийг харсан хүмүүс бороо орох нь дээ гэцгээсээр унтахаар тарж одов.

Гэтэл мөнөөх үүл усны мандал дээгүүр хэсэг хөвснөө тэнгист шингэн алга боллоо. Гагцхүү

одод л гялтганах аж.

Хүйтэн агаар тосгоноос дэгдэн одсоноо төд удалгүй сарнайн үнэр хөлөглөн буцаж ирлээ.

-Якоб! Би чамд юу гэж хэллээ! Дон Максимо Гомез ийн дуу алдаад, одоо ч шөнө бүхэн сарнай үнэрлэх нь гарцаагүй боллоо гэв.

-Бурхан өршөөг! Гэхдээ энэ үнэр миний хувьд хэтэрхий оройтлоо хэмээн өвгөн Якоб хариулав.

Тэр хоёр хоосон дэлгүүрийг эзэгнэн, хөгжмийн чимээг огтхон ч үл анхааран даамдаж байв. Мөнөөх эрчүүдийн дурсамж тэрхүү пянзнуудыг үйлдвэрлэгдэхээс ч аль өмнийн юм болохоор сэргэх сэдрэх ч учир жанцангүй ажгуу.

-За даа. Энэ холион бантангийн юманд ч би нэг их итгэхгүй л байгаа гэж Дон Максимо Гомез өгүүлээд энэ олон жил тоосоор амьсгалж, цэцгийн талбайтай болохыг мөрөөдсөн үй олон хүүхнүүдийг үзсэн энэ хүмүүс сүүлдээ бүр цэцгийн үнэр үнэртэж байна гэж хүртэл үнэмшиж суугаа нь арга ч үгүй юм даа хөөрхийс хэмээн хүүрнэв.

Гэхдээ яах аргагүй үнэртээд байгаа юм биш үү? хэмээн өвгөн Якоб асуулаа. Тэр хамаагүй ээ гэж нөгөөх нь зөрүүдлээд дайны үед хувьсгал бүр ялагдчихсан байхад бид нар удирдагчтай болохсон гэж дэмийртлээ бодсоноос болж Марльборотын гүнг амьдаараа залрахыг үзэж л явсан юм даг. Би энэ хоёр онигороороо л харсан юм даа хэмээн хөөрлөө.

Энэ яриа шөнө дундаас хойш болсон хэрэг. Өвгөн Якоб ганцаараа хоцроод, дэлгүүрээ хааж дэнлүүгээ барин унтлагын өрөөгөө зүглэлээ. Талийгаачдыг тэнгис рүү буулгадаг хадан цохио усны мандлаас ялгаран сүүхийлхэх нь цонхоор үзэгдэж байв.

Өвгөн

-Петра! хэмээн эмгэнээ аяархан дуудсан боловч цаадах нь сэрсэнгүй. Тэр үед Петра эмгэн үд дундын хурц наран дор Бенгалийн цутгалангийн мандал дээгүүр хөвөн дүүлж явав. Эмгэн далайн онгоцон дээр байдаг гэрэлтүүлэгтэй үзмэрийн цонх мэт үзэгдэх тэнгисийн усыг нэвт ширтэн ертөнцийн нөгөө хязгаарт Катаринагийн бягтруулыг дахин сонсож суугаа эр нөхрөө хайх ажээ.

-Хүмүүс дөнгөж зургаан сарын өмнө л чамайг минь галзуу амьтан гэцгээж байсан. Тэгвэл одоо чиний минь үхэхийг зөгнөсөн энэ үнэр гарлаа гэж баяр хөөр болж ч байх шиг хэмээн өвгөн Якоб өөрөө өөртэйгээ ярьлаа.

Тэр гэрлээ унтраан орондоо ороод өвгөн хүний ёсоор тамиргүйхэн эхэр татан мэгшүүлээд төд удалгүй нойрондоо цохиулсан бүлгээ.

-Яаж ийгээд энэ тосгоноос л зайлах минь! Хорин песотой л болчихвол там руу ч хамаагүй явах минь хэмээн тэр үглэсээр өглөө нь орноосоо өндийв.

Тэр үдээс хойш мөнөөх үнэр хэдэн долоо хоног арилсангүй, байшингийн мод, хоол унд, ус

унданд шингэж хаа сайгүй ханхийн байдаг болов. Зарим хүмүүс бааснаасаа хүртэл цэцгийн үнэрийг мэдрээд шогширч байлаа.

Катаринагийн зочлогсод баасан гаригт явцгаасан ч маргааш нь бөөн хүн дагуулсаар эргэж ирэв. Тэд нар нь идэх хоол, унтах хэвтгэр эрэн шоргоолж шиг бужигналдан сүүлдээ гудамжинд хөл гишгэх зайгүй боллоо.

Дахиад ч хүмүүс нэмэгдлээ. Тосгон сүйрсний дараа явсан эмэгтэйчүүд ч ирцгээлээ. Тэд бүдүүрч, нүүрээ нялайтал шунхадсан байх агаад авчирсан шинэ пянзнууд нь хэнд ч ямар ч дурсамж санагдуулахгүй бүлгээ.

Тосгоны хуучин оршин суугчдаас ч мөн ирцгээв. Тэд урьд цагт баяжих аянд мордоцгоосон бөгөөд хэдийгээр өөрсдийн азтай хийморьтой явцгааснаа шагшралдах боловч мөнөөх явахдаа л өмсөж байсан тэр л хувцастайгаа тууж явах ажээ.

Хөгжим болон зугаа цэнгэлийн үзвэр, азын тоглоом, мэрэг төлөгчид, буу зэвсэг агсагсад, хүзүүндээ могой цагираглуулан мөнхийн ус санал болгогсод гээд есөн шидийн зүйлээр тосгон дүүрлээ.

Тэд бүр хэдэн долоо хоногийн турш, тэр ч бүү хэл анхны бороо орон, тэнгис давалгаалан хөөсөрч анхилам үнэр алга болчихоод байхад ч ирсээр байсан авай.

Шашны номлогч сүүлчийн хүмүүстэй хамт ирлээ. Тэрбээр кофенд талх дүрэн зажилж энэ тэрүүгээр алхангаа азын тоглоом, шинэ хөгжмийн бичлэг, уг хөгжмийг даган бүжиглэх аяг жаяг, тэр бүү хэл тэнгисийн эрэгт унтдаг шинэ ёсыг хүртэл аажим аажмаар хорьж орхив.

Нэгэн өглөө мөнөөх номлогч Мелгорын гэрт тэнгисийн үнэрийн тухайд сургааль айлдав.

-Тэнгэр бурхандаа талархацгаа, хүүхдүүд минь. Энэ бол Бурханы үнэр юм аа хэмээн тэр мэдэгдэв.

Хэн нэг нь түүний үгийг хажуугаас нь тасалж, эцэг минь! та тэр үнэрийг үнэртэж ч үзээгүй байж ингэж хэлж болж байгаа юм уу гэлээ.

-Ариун номд энэ тухай тодорхой заасан байна. Бид Бурханы таашаан сонгосон газарт амьдарч байна хэмээн ламтан айлдвай.

Тобиас олны дунд зүүдэлж буй хүн мэт баахан холхив. Тэр Клотильдаг мөнгө гэж юу байдгийг үзүүлэхээр авчирсан ажээ. Тэр хоёр азын тоглоомоос асар их мөнгө хожиж баян цаггалан болно хэмээн өөрсдийгөө итгүүлдэг бүлгээ.

Гэвч тун удалгүй нэгэн шөнө л тэр хоёр болоод бүх тосгоныхон хэзээ ч төсөөлшгүй их мөнгө нэг дор байхыг үзэх учиртай байжээ.

Тэр шөнө ноён Херберт ирсэн нь тэр юм. Мань хүн гэв гэнэтхэн гарч ирээд гудамжны тэхий дунд ширээ засан түүн дээрээ банкны тэмдэгт пэндийтэл чихсэн хоёр чемодан гаргаж тавьсан ажгуу.

Эхэндээ мөнгийг хэн ч анзаарсангүй. Учир нь хүмүүс ийм их мөнгө байж болдогт нэг л итгэхгүй байлаа. Харин ноён Херберт бяцхан хонх дэлдэхэд л ялигүй итгэцгээн яриаг нь сонсохоор дөхөцгөөв.

- За би болбоос дэлхийн хамгийн баян хүн байна. Би асар их мөнгөтэй болохоор хадгалах, агуулах сав ч олдохоо болилоо. Түүнээс гадна миний агуу их зүрх ч цээжиндээ багтахгүй байна. Тийм болохоор би дэлхийгээр жуулчилж, хүн төрөлхтний өмнө тулгарсан асуудлуудыг шийдэхээр яваа юм хэмээн ноён Херберт илтгэлээ.

Тэрээр өндөр нуруутай, улаавтар царайтай эр байлаа. Мань хүн дөнгөж саяхан мөлчийтөл угааж, хуссан болов уу гэмээр болцгор гараа занган өндөр дуугаар цангинуулах агаад 15 минут яриад хэсэг амсхийснээ цааш нь үргэлжлүүлэв.

Энэ үед олны дотроос хэн нэг нь малгайгаараа даллан яриаг нь тасалдуулав.

-Ярих яах вэ? Мөнгөө тараагаач ээ хэмээн мөнөөх яриа тасалдуулагчийн хэлэхэд, энэ тийм ч амар эд биш ээ хө хэмээн ноён Херберт хариулаад ямар ч шалтгаангүйгээр тэгээд ч шударга бусаар мөнгө хуваарилах нь утга учиргүй зүйл гэж тодотголоо.

Тэгснээ мөнөөх үг хэлэгчийг нүдээрээ эрж олоод өөр рүүгээ дохиход тэр нь ч явж очлоо.

-Гэхдээ бидний найз энэ тэвчээргүй нөхөр маань баялгийг хэрхэн тэгш шударга хуваахын үлгэр жишээг харуулах юм аа гэж Херберт зарлаад таны нэр хэн билээ хэмээн лавлав.

-Патрасио.

-За хө Патрасио. Чамд шийдэж чадахгүй ямар нэгэн асуудал байна уу?

Патрасио малгайгаа аван толгой дохив.

-Юу билээ?

-Надад ямар ч мөнгө байхгүй нь л миний гол бэрхшээл дээ гэж Патрасиог өгүүлбэл, хичнээн мөнгө хэрэгтэйгээ хэлнэ үү хэмээн цаадахь нь хүслээ.

-Дөчин найман песо.

Ноён Херберт дөчин найман песо хэмээн ёслол төгөлдөр уулга алдан зарлахуй хурсан олон алга ташин түрхрэв.

-Сайн байна.Патрасио. Чи нэг л юм хэлээд орхи надад! Чи юу хийж чадах вэ?

-Зөндөө л юм чадна.

-Нэгийг нь хэл!

-Би шувуу дуурайж чадна.

Ноён Херберт олон түмэн дахин алга ташихаа намдсаны хойно,

Ноёд, хатагтай нар аа! Бидний анд Патрасио маань шувуу дуурайх онцгой авьяастай юм байна. Одоо энэ хүн дөчин найман янзын шувууны дуу гаргаж үзүүлнэ. Ингэж бид энэ хүний амьдралын хамгийн чухал асуудлыг шийдэх юм аа гэлээ.

Патрасио өөрийг нь чимээгүй ширтэх олонд авьяасаа үзүүлж эхлэв. Мань хүн олны мэдэх шувуудыг исгэрэх, хөөмийлөх, шившрэх хослуулан дуурайсан агаад харин сүүлийн хэдэн авиа нь чухам ямар шувуудыг үлгэрлэснийг таахад бэрх байсан билээ.

Ноён Херберт цугларсан олноос дахин алга ташилт хүсээд Патрасиод яг дөчин найман песо гардуулан өгөв.

-Ингээд нөхдүүд минь. Нэг нэгээрээ гарч ирцгээнэ үү. Би маргаашийн яг өдий хүртэл та бүгдийн асуудлыг шийдэх болно хэмээн дараа нь ноён Херберт зарлалаа.

Өвгөн Якоб энэ тухай гэрийнхээ гадуур өнгөрөн явагсдаас олж мэдээд үймрэн догдолж орхив.

Энэ америк нөхрийн тухай юу гэж бодож байна? хэмээн тэр Дон Максимо Гомезоос асуувал цаадах нь мөрөө хавчин:

Өглөгийн эзэн гэдэг л байх гээд байна гэлээ.

-Би юу ч болохнээ хийж чаддагсан бол ч асуудлаа шийдүүлмээр л байна. Уул нь ч хорьхон песо л хэрэгтэй байна санж хэмээн өвгөн Якоб санааширлаа.

-Чи даам сайн тоглодог шүү дээ хэмээн Дон Максимо Гомез хэллээ.

Өвгөн Якоб энэ үгийг эс дуулаачийн дүр эсгэж байснаа ганцаараа үлдмэгц даамаа сонинд хулдаж аваад ноён Хербертийг зорьсон ажгуу.

Тэр шөнө дунд хүртэл ээлжээ хүлээлээ. Гэвч ноён Херберт чемоданаа хурааж, маргааш хүртэл баяртай гэв. Гэвч унтахыг яарсангүй, харин ч асуудлыг шийдүүлэхийг хүсэгчдийг дагуулан Катаринагийн очлоо. Хэдэн эрчүүд мөнөөх мөнгөтэй чемодануудыг нь барин дагалдах аж.

Херберт хүмүүсийн асуудлыг нэг нэгээр нь шийдсээр эцэстээ ажлаа амжуулчихсан хэдэн эрс болон ганц хоёр эмэгтэйчүүд л үлдсэн байлаа.

Өрөөний хойт буланд нэгэн эмэгтэй ганцаардангуй сууж, зарлалын самбар уншин өөрийгөө зугаацуулах нь үзэгдэв.

-Таны асуудал юу билээ? хэмээн ноён Херберт түүнээс асуулаа.

-Би бол үнэнч хүн. Надад ямар ч асуудал байхгүй гэж нөгөөх нь хариулав.

Ноён Херберт мөрөө хавчаад пиво уун тухалж хэн нэгэн асуудлаа шийдүүлэхийг хүлээлээ. Тэрээр энэ үед халууцан хөлөрсөн байлаа. Удсан ч үгүй түрүүчийн эмэгтэй олны дундуур зүтгэн гарч ирээд түүнд ямар нэгэн юм шивгэнэлээ.

Тэр эмэгтэй таван зуун песогийн асуудалтай ажээ.

-Та энэ мөнгөө яаж багцлах вэ? гэсэн ноён Хербертийн асуултанд хүүхэн тавтаар л толгойлно доо гэж хариулав.

-Тэгвэл энэ бол зуун эр хүн гээд төсөөл дөө.

-Хамаагүй ээ. Би энэ мөнгийг нэг дор л авч байвал тэд чинь миний амьдралын сүүлчийн зуун эр хүн байх болно.

Ноён Херберт бүсгүйг ажиглан харахул цэл залуу турьхан амьтан үзэгдэх агаад нүд нь шийдвэр төгс гялалзах аж.

-За яахав. Чи өрөөндөө орж бай. Би хүмүүсийг тав таван песотой чам руу явуулаад байя. Ноён Херберт ийн өгүүлээд байшингийн үүдний хонхыг цохилоо.

Тобиас өглөөний долоон цагт Катаринагийнх онгорхой байхыг олж үзээд орж очвол пиво, нойр хоёрт цохиулсан ноён Херберт мансууран сууж, охины өрөө рүү орох эрчүүдийг хянаж байх ажээ.

Тобиас ч мөн орж явчихав. Охин түүнийг таниад та ч бас ирээ юү хэмээн гайхлаа. Харин цаадуул чинь ир гээд ээ. Надад таван песо өгсөн. Удаж болохгүй гэсэн шүү хэмээн Тобиас учирлалаа.

Охин нов нойтон дэвсгэр даавуугаа хуулаад нэг үзүүрээс нь барихыг Тобиасаас хүслээ. Даавуу бэржээнх шиг хүнд болжээ. Тэр хоёр даавууг шавхартал мушгиад бас гудасны хөлстэй талыг доош харуулан эргүүлж дэвслээ.

Дараа нь Тобиас нөгөө ажлыг байдаг чадлаараа үйлдэж орхиод таван песог охины дэрний хажууд улам зузаарсаар буй багц мөнгөн дээр нэмэрлээд гарч одов.

-Аль чадах хүн болгоныг л нааш нь явуулаарай хэмээн ноён Херберт түүнээс хүсээд өнөө үдийн өмнө л дуусгамаар байна санж гэв.

Охин хаалгаа чихруулан нээж хүйтэн пиво хүсэв. Наана нь бас хэдэн эрчүүд ээлжээ хүлээн суух аж. Одоо хэдэн хүн үлдээд байна гэж охиныг асуухад хорин гурав хэмээн ноён Херберт хариулав.

Даамаа сугавчилсан өвгөн Якоб Хербертийг өдөржин дагасаар үдэш арайхийн ээлж дугаар нь болов. Тэр хоёр гудамжны голд хоёр сандал, давхар ширээ зоож, өвгөн Якоб өргийн эхний нүүдэл хийлээ.

Энэ бол өвгөн Якобын хувьд жаахан ухаан зарж чадсан сүүлчийн тоглолт байсан бөгөөд яах

аргагүй хожигдлоо.

-Дөчин песо! Би танд яахав хоёр сул нүүдэл өгье! хэмээн ноён Херберт өгүүллээ. Херберт дахиад л хожлоо. Мань эр эсрэг тоглогчийнхоо нүүдлийг харзнанхан даамнуудыг хайхрамжгүйхэн зөөж тавин тоглох агаад хожсоор л байлаа.

Цугларагсад тоглоомоос уйдаж эхлэв. Сүүлдээ өвгөн Якоб бууж өгөхөөр шийдсэн агаад таван мянга долоон зуун дөчин хоёр песо хорин гурван центийн өрөнд орсон байлаа.

Өвгөн царайгаа үл хувирган халааснаасаа гаргасан цаасан дээр даамаа асган хайрцаганд хийгээд буудалтай нь хамт сонинд ороолоо. Дараа нь намайг яавал ч яа. Би хойшид энэ мөнгийг чинь нэгмөсөн төлнө гэдгээ амлаж байна гэлээ.

Ноён Херберт өвгөний нүд рүү ширтэн, уучлахыг гүнээ хүсье! Та гэхдээ хариугаа 20 минутанд багтааж хэлнэ үү хэмээв. Тэрбээр нөгөөхөө тэвчээртэйе хүлээснийхээ эцэст, танд санал болгох юм алга уу гэж асуулаа.

Манай байшин хэмээн өвгөн Якоб гэмээ цайруулах мэт өгүүлээд нэг их үнэд хүрэхгүй л дээ. Гэхдээ л байшин шиг байшин хэмээв.

Ноён Херберт өвгөн Якобын байшингийн эзэмшигч болсон түүх энэ юм. Түүнчлэн тэр өрд унасан бусад хүмүүсийн ч байр сав, өмч хөрөнгийг авсан ба дараагаар нь хөгжим, галын наадам, акробат оролцсон баярын долоо хоног эхлүүлж түүнийгээ биечлэн удирдсан бүлгээ.

Энэ бол үл мартагдах өдрүүд байсан билээ. Ноён Херберт тосгоны онцгой хувь тавилангийн тухай ярьсан төдийгүй ирээдүйд сүндэрлэх учиртай дээвэр дээрээ бүжгийн талбай бүхий шилэн барилгуудын зураг хүртэл зурсан аж.

Тэгээд тэр зургаа олон түмэнд үзүүлэв. Тэд уг зургийг мэлрэн ширтэж, тэнд дүрслэгдсэн явган зорчигчдын дотроос өөрсдийгөө олох гэж өндөлзөв. Гэвч зурагт хүмүүсийг гоё ганган хувцастай дүрсэлсэн тул хэнтэй нь ч төстэй болсонгүй.

Хурсан олон ирэх 10-р сард буцан цуглах урилгыг инээлдэн хүлээн авсан бөгөөд баян тарган, сайхан амьдрах гоё мөрөөдөл нь ноён Херберт хонхоо цохиж, баяр цэнгүүн өндөрлөснийг зарламагц замхран сарнисан ажгуу.

Ноён Херберт энэ бүхний дараа л сая нэг амсхийлээ. Та энэ янзаараа бол удахгүй талийгаач болно шүү хэмээн өвгөн Якоб хэлэхэд над шиг их мөнгөтэй хүнд үхэх ямар ч шаардлага байхгүй гэж мөнөөх эр хариулсан болой.

Тэгээд тэр эр орондоо шурган арслан шиг хурхирч олон шөнө, олон өдөр нам унтлаа. Түүнийг хүлээн уйдсан хүмүүс хавч гогдож идэн, Катаринагийн шинэ пянзнуудыг сонсож байлаа.

Тэрхүү пянзнууд хэдий саяхных болов ч маш их дурсгалт аялгуу хангинуулах тул хүн болгон нулимс цувуулах аж. Эцэст нь энэ бүхнээс залхсан Катарина байшингаа хаан түгжиж авлаа.

Ноён Хербертийг ийн унтаж эхэлснээс хойш тэртээ хойно номлогч ламтан өвгөн Якобын

хаалгыг тогшлоо. Байшин дотроосоо түгжээтэй байсан агаад ноён Хербертийн амьсгалд агаар сийрэгжин эд зүйлс жингүйдэн хөвөлдөх аж.

Номлогч ламтан түүнтэй уулзах хүсэлтээ уламжлахад хүлээхээс өөр аргагүй гэдгийг өвгөн Якоб тайлбарлалаа. Тийм завгүй яваагаа өвгөн ламтан хариу айлтгахад,

-Эцэг минь та суугтүн. Хүлээж үз хэмээн өвгөн Якоб давтаад, энэ хооронд та надад ганц нэг юм хэлж өгч үзээч. Миний бие хорвоо дэлхийд юу болоод байгааг ойлгодог болоод удлаа гэхэд, номлогч ламтан, хай хөөрхий хүмүүсийг бүр үймүүлж орхиж. Тосгон удахгүй урьдынхаа байдалд орно. Дуулгах сонин энэ л байна хэмээн айлдав.

-Сарнайн үнэр дахиад гарвал нөгөөдүүл чинь буцаад ирнэ дээ.

-Гэхдээ ямар нэг юм бүтээхийг хүсэгчдийн хүслийг биелүүлэхэд нь тусална. Бид энд сүм барих нь туйлын чухал болоод байна.

-Аа тийм болоод л та ноён Херберттэй уулзахаар ирээ юу?

-Тийм ээ. Энэ америкчууд ер нь их өгөөмөр улс даг аа.

-Та жаахан хүлээ эцэг минь! Одоо ингэсхийгээд сэрэх байлгүй дээ. Номлогч, өвгөн хоёр ийнхүү ярилцаад даам тоглож эхлэв. Тэд хэдэн өдөр дамнасан удаан ужиг өрөг тоглох авч ноён Херберт нойрноос сэрсэнгүй хурхирсаар байсан амой.

Сүүлдээ номлогч ламтан цөхрөөд зэс таваг барин сүмийн хандив цуглуулахаар баахан явсан боловч гавьтай юм олсонгүй. Тэрбээр ийнхүү хандив гувшин явсаар цонхийн цайж, хамаг яс нь хажигнан дуугарах болсон агаад нэгэн ням гаригт хоёр гараа дээш сарвайн зогссоныг нь хэн ч үл анзаарсан ажгуу.

Эцэстээ ламтан гуай нэг хайрцаганд хувцсаа, бас нэг хайрцаганд цуглуулсан жаахан мөнгөө хийж аваад үүрд явж одсон авай.

Тэрбээр өөрийг нь болиулахаар оролдогсдод хандан, тэр үнэр хэзээ ч дахиад гарахгүй, танай тосгон аймшигт хараалд идэгджээ гэсэн бүлгээ.

Ноён Хербертийг сэрэхэд тосгон яг л урьдын адил болсон байлаа. Ирээд явсан хүмүүсийн тарьсан хог бороонд нэвчин дагтаршиж, гудамжны хөрс тоосго мэт хуурай, хатуу болсон байв.

Би ч мөн удаан унтаж дээ хэмээн ноён Хербертийг эвшээлгэхэд, хэдэн зуун жил л боллоо хэмээн өвгөн Яков хариулав.

-Хөөе! Би өлсөж үхэх нь ээ.

-Хэлээд яахав. Хүн болгон нь л турж үхдэгийн даваан дээр байна. Тэнгисийн хөвөөнөөс хавч гогдохоос өөр ямар ч зам алга даа.

Тобиас ноён Хербертийг галзуу хүн мэт элс самардан цацалж, идэх юм эрж байхад нь баян

хүн өлсөхөөрөө яг л ядуу хүн шиг байдгийг ойлгон гайхсан ажээ.

Ноён Херберт идээд цадчихмаар олигтой юм олоогүй тул хамтдаа явж тэнгисийн гүнээс хүнс олж идэхийг тэр үдэш Тобиаст санал болгов.

Тэнд юу байдгийг талийгаачид л мэднэ. Аюултай юм биш үү хэмээн Тобиас анхаарууллаа. Эрдэмтэд ч бас мэднэ хэмээн ноён Херберт өгүүлээд талийгаачдыг живүүлдэг тэр газар янзын амтлаг махтай яст мэлхийнүүд бий. Хувцсаа тайл, явцгаая гэлээ.

Ийнхүү тэд замдаа гарлаа. Тэр хоёр шулуухан хэсэг хөвөөд улмаар доошлон шумбахад эхлээд нарны туяа алдарч, тэнгисийн гэрэл тусч байснаа сүүлдээ эд юмс бараантан сүүмэлзэх гүнд хүрч очлоо.

Энэ үеэр тэр хоёр эр, эм хүмүүс морь унан давхилдах нэгэн тосгонтой тааралдахад Тобиас тэр зүг сэлсэн боловч ноён Херберт гараараа занган болиуллаа. Тобиас, энд зөндөө сарнай байна. Үүнийг Клотильдад харуулмаар байна гэхэд, дараа л ирж үз, би яг өлбөрөх нь хэмээн ноён Херберт хэлэв.

Тэр усны гүн рүү гараа сарвалзуулан наймаалж мэт шунгахад араас нь гүйцэж ядах Тобиас баян хүмүүс л ингэж сэлдэг юм байна хэмээн сэтгэж явав.

Мань хоёр ийнхүү тэнгисийн улам гүн рүү, үхэгсдийн нутаг дэвсгэр рүү алгуурхан орж явчих нь тэр.

Тэнд үй олон талийгаачид байх бөгөөд газар дээр ч ийм олон хүн үзээгүй мэт сэтгэгдэл төрүүлэх аж. Талийгаачдын цогцос гэдэргээ харсан байдалтай, олон үе давхаралдан хөвөх агаад төөрөлдсөн сүнс шиг үзэгдэх авай.

Энэ бол дивангалавын цогцсууд. Ийм байдалд ортлоо хэдэн зуун жил болсон байж таарна хэмээн ноён Херберт ярьлаа. Түүнээс доошлон улам олон цогцос бүхий хэсэгт очоод ноён Херберт зогслоо.

Түүний өмнө маш залуухан бүсгүйн цогцос хөвж явах аж. Нүд нь хараастай, хажуулдан хөвөх ба үй олон цэцгийн хэлхээ дагалдах аж.

Ноён Херберт цогцсыг хөвж өнгөртөл Тобиасын уруулыг хуруугаараа дараад дараа нь миний амьд яваа насандаа үзсэн хамгийн үзэсгэлэнтэй эмэгтэй энэ боллоо хэмээвэй.

Энэ чинь өвгөн Якобын эхнэр байна. Лав тавин насаар залуужсан байна шүү дээ. Гэхдээ л мөн байна даа хэмээн Тобиас өгүүллээ.

Тэр маш олон газраар аялж яваа юм байна. Араас нь дэлхийн бүх тэнгис далайн цэцэг хөвж явааг хараа биз хэмээн ноён Херберт хэлэв.

Тэд явсаар тэнгисийн ёроолд хүрлээ. Ноён Херберт хавтан мэт гялалзах хөрсөнд хүрээд ийш тийшээ хэд хэд холхиход Тобиас түүнийг дагаж байв. Тэрбээр гүний гэрэлд орсон хойноо л яст мэлхийнүүдийг олж үзэв. Мянга мянган яст мэлхий ёроолыг нилд нь бүрхсэн байх агаад

царцсан мэт хөдөлгөөнгүй харагдах аж.

-Эд бүгд амьд. Сая сая жил унтаж байгаа нь энэ хэмээн ноён Херберт өгүүлэв. Херберт нэгийг нь эргүүлж үзэн, хуруугаараа зөөлхөн хатгавал мөнөөх амьтан урсгал даган хөдөлж Тобиасыг өнгөрөн одов.

Тобиас тэнгисийг ёроолоос нь харан сонирхоод яг л зүүд шиг санагдаж байна гэлээ.

Энэ тухай хэнд ч хэлж болохгүй шүү. Хэлчихвэл ямар замбараагүй юм болохыг мэдэж байгаа биз дээ хэмээн ноён Херберт хажуугаас нь сануулав.

Тэднийг тосгонд эргэж ирэхэд бараг шөнө дунд болж байсан ба тэд Клотильдаг ус буцалгуулахаар сэрээв. Ноён Херберт яст мэлхийнүүдийг эвдэж янзалсан бөгөөд зарим нь үхээгүй байсныг агнах ч хэрэг гарав.

Тэд ийнхүү зогсоо зайгүй хөдөлсөөр гурван цагийн дараа л хоол бэлэн болж, амьсгалж чадахгүй болтлоо идэж авцгаав.

Хоолны дараа ноён Херберт Тобиаст хандан, за хө бид жинхэнэ үнэнийг л оллоо доо хэмээн хэлэхэд Тобиас яг тийм шүү гэж хариуллаа.

Жинхэнэ үнэн гэвэл нөгөө үнэр дахин хэзээ ч эргэж бий болохгүй нь гэж Херберт үргэлжлүүлэв. Харин Тобиас бий болж л таарна хэмээн зүтгэлээ. Тэдний ярианд Клотильда хөндлөнгөөс оролцон, үгүй ээ бий болохгүй. Яагаад гэвэл ердөө ч байгаагүй зүйл. Энийг та нар ойлгож авах хэрэгтэй хэмээв.

Тобиас түүнд хандан, чи өөрөө л эхэлж үнэртээ биз дээ гэхэд, би тэр шөнө хагас маанаг болчихсон байсан юм аа хэмээн Клотильда зүтгээд, харин одоо энэ тэнгисийг яах ёстойг мэдэх юм алга гээд яриагаа дуусгав.

Харин ноён Херберт тэр хоёрт явах болсноо дуулгаад энд ингэж өлсөж сууснаас уудам хорвоог тойрвол уйдаах юмгүй тухайд зөвлөсөн бүлгээ.

Ноён Херберт тийн явж одсон ажгуу.

Тобиас хашаандаа хоцрон тэнгэрийн оддыг тоолвол өнгөрсөн арванхоёрдугаар сарынхаас гурваар нэмэгдсэн байх ажээ. Энэ үед Клотильда түүнийг унтлагынхаа өрөөнд дуудсан боловч эр нөхөр нь огт анзаарсангүй.

-Хүүе нааш ир тэнэгхэн минь! Бид хоёрын туулай шиг хурьцдаг байснаас хойш зөндөө олон жил өнгөрсөн байна хэмээн Клотильда дуудлаа.

Харин Тобиасыг удаж удаж ирэхэд эхнэр нь аль хэдийн унтчихсан байв. Тобиас түүнийгээ хагас дутуу сэрээсэн боловч цаадах нь ихэд ядарсан байсан тул энгэр зөрүүлэх гэж өт хорхойнуудынх шиг юм болж дуусав. Ямар сайндаа л чи зүгээр нэг гурил шиг юм шалчигнаад байх юм даа гэж Клотильда уцаарлавав.

Бүсгүй бас тэнгисийн ёроолд ямар байсныг цааш өөр хүнд ярихгүй гэсэн өчиг өгөн байж нөхрөөрөө яриулах боллоо.

Тэнгисийн гүнд тосгон байна билээ. Тэнд довжоон дээрээ сая сая цэцэгстэй жижигхэн цагаан байшингууд байсан хэмээн Тобиас яриагаа эхэллээ.

Клотильда үүнийг сонсоод, за Тобиас минь бурханыг бодож энэ бүхнээ дахиад бүү эхэл хэмээн дуу алдсан бүлгээ.

Тобиас дахиад юу ч хэлэлгүй орныхоо нэг булан руу шигдэн унтахыг оролдлоо.

Тэр үүрээр салхи савар босон, улигт хилэнц хорхойг явж одтол унтаж чадаагүй билээ.

Зургаан цагт ирсэн бүсгүй

Хаалга нээгдлээ. Яг энэ цаг мөчид Жойсын ресторанд хүнгүй байлаа. Зургаан цагийн хонх дөнгөж цохиж байсан агаад байнгын үйлчлүүлэгчид зургаа гуч хүртэл ирэхгүй гэдгийг Жойс мэдэж байлаа.

Түүний үйлчлүүлэгчид айхтар ягшмал бөгөөд тогтмол зантай улс бөгөөд тухайлбал мөнөөх эмэгтэй яг л урьдынх шигээ зургаан цагийн хонх цохихтой зэрэгцэн орж ирээд чимээгүйхэн суулаа. Эмэгтэй асаагаагүй янжуур зуужээ.

Түүний суухыг харсан Жойс” Сайн байна уу хадагтай” гэлээ. Дараа нь тэрбээр лангууны нөгөө үзүүрт очин гадаргууг нь арчиж эхэллээ. Ер нь Жойс ресторанд нь хэн ч орж ирсэн ингэдэг зантай хүн юм. Энэхүү улаан царайтай бүдүүн боргил эр бүр ойр дотнын гэмээр энэ эмэгтэйд ч ажилсаг эрийн төрх харуулдаг билээ.

Та яамаар байна даа? хэмээн Жойсыг лангууны цаад булангаас асуувал:

Чамайг боловсон занд л эхлээд сургамаар байна санж гэж эмэгтэй хэллээ.

Эмэгтэй сандал өнцөгдөн сууж, лангуу тохойлдсон байх агаад зуусан янжуураа харуулах гэж уруулаа жимийлээ.

-Би анзаарсангүй л дээ хэмээн Жойсын хэлэхэд эмэгтэй,

-Чи юм анзаарч сурахгүй л юм даа гэлээ.

Рестораны эзэн лангуун дээр алчуураа орхиод тоос, давирхай үнэртсэн харанхуй тавиураас чүдэнз авлаа. Эмэгтэй мань эрийн болхидуу үслэг гарт асах галаас тамхиа асаахаар тонгойход Жойс түүний хямдхан вазелин ахиухан түрхсэн сэвсгэр үсийг харав. Мөн цэцгэн хээтэй хөхөвч, нүцгэн мөрийг нь, тамхиа асаагаад гэдийхэд нь сүүдэртэн тодрох хөхийг нь ч олж үзлээ.

- Та өнөөдөр үзэсгэлэнтэй сайхан байна хатагтай хэмээн Жойс хэллээ.

Үүнд нь эмэгтэй:

-Манж үгээ болиоч дээ. Энэ чинь чамд төлбөр хийхэд минь нэмэр болно л гэж бүү бод гэж хариуллаа.

- Үгүй дээ. Би тэгж хэлсэн юм биш хадагтай! Танд өдрийн хоол чинь зохиогүй дэг ээ хэмээн Жойс мэтгэв.

Эмэгтэй тамхиа гүнзгий сорон, лангуу тохойлдсон хэвээр рестораны том цонхоор гудамж ширтсээр суулаа. Түүний сэтгэл нь зовиуртай байгаа нь илт.

-Би танд сайхан мах давгаж өгье хэмээн Жойсын дуугарахад,

-Би мөнгөгүй хэвээрээ л байгаа шүү дээ гэж эмэгтэй хэллээ.

-Та бүтэн гурван сар мөнгөгүй явж байна. Харин би танд дандаа л хоол бэлдэж өгдөг биз дээ.

-Өнөөдөр харин өөр өдөр өө.

Эмэгтэй ийнхүү гунигтайхан өгүүлэнгээ гудамж руу хараа тавьсаар байх авай.

-Өдөр болгон л адилхан байдаг шүү дээ хэмээн Жойс хэлээд, өдөр бүр цаг яг зургаа болоход л та орж ирээд үнэг гүйцэхээр боллоо гэдэг. Би ч танд юм хийж өгдөг. Харин та өнөөдөр нохой шиг өлслөө гэсэнгүй. Гэхдээ өнөөдөр өөр өдөр гэж байгаа чинь л ялгаатай юм даа хэмээн хөврүүллээ.

-Энэ үнээн. Эмэгтэй ийн хэлээд лангууны нөгөө үзүүрт хөргөгч үзэж буй эр рүү харцаа шилжүүллээ. Тэр түүнийг хоёр, гурван секунд ажиглаад тавиур дээрх цагийг харлаа. Зургаан цагаас гурван минут өнгөрч байв.

-Тийм ээ. Жойс! Өнөөдөр их өөр өдөр шүү. Эмэгтэй ийн яриад тамхиныхаа утааг үлээж:

-Би өнөөдөр энд зургаан цагт ирээгүй. Ийм л ялгаа байна даа хэмээв.

Жойс цаг руугаа харав.

-Би энэ цаг нэг минут л хоцорч байвал гараа тасдаж хаяхад ч бэлэн байна.

-Учир нь цаганд биш ээ. Харин би өнөөдөр зургаан цагт ирээгүй юм шүү Жойс!

-Хатагтай таныг орж ирэхэд яг зургаа болж, хонх нь дөнгөж цохисон доо.

-Би орж ирээд 15 минут болж байна.

Жойс эмэгтэй рүү явж очоод долоовор хуруугаа зовхиндоо хүргэн тонгойж махлаг нүүрээ бүсгүйд ойртуулан:

Алив над руу тонгой гэлээ.

Эмэгтэй толгойгоо хойш нь хаялаа. Тэрээр гуниг, ядаргаандаа зөөлөрсөн шинжтэй гоёмсог сайхан үзэгдэвч нухацтай, зэвүүцсэн байдалтай болжээ.

-Тэнэглэхээ боль, Жойс! Намайг бүтэн зургаан сар уухгүй байгааг чи мэдэж байгаа биз дээ.

-Бусад хүнд л тэгж хэлээрэй. Та нэг, хоёр хундага тогтоосон л байна даа. Мөрийцсөн ч болно.

-Би найзтайгаа хоёр хундага уусан юм аа.

-Аа одоо л ойлголоо.

-Ойлгоод байх юм байхгүй. Би энд арван таван минут болж байна.

Жойс энэ үгийг сонсоод мөрөө хавчин,

-За яахав та энд арван таван минут болсон юм болог. Ер нь ч тэгээд арван минутын наана цаана ялгаа байв л гэж үү гэлээ.

-Харин энэ чинь л юмыг их өөр болгож байгаа юм шүү дээ хэмээн эмэгтэй хэллээ. Дараа нь тэр хайхрамжгүй дүр үзүүлэн гараа савчаад,

Би энд арван таван минут гэснээ цагаа хараад хорин минут болж байна хэмээв.

-За за хатагтай. Таныг жаргалтай байхыг харахын төлөө би өдөр шөнөгүй зүтгэнэ хэмээн Жойс өгүүллээ.

Мань эр тийнхүү ярилцах зуураа лангууны ард ямар нэгэн юм тасралтгүй хийж, өөрөөр хэлбэл үүргээ гүйцэтгэсээр байх ажээ.

-Таныг аз жаргалтай байхыг хармаар байна хэмээн Жойс давтлаа. Тэр гэнэтхэн зог тусан эмэгтэй рүү эргэж, би танд маш их хайртайг та мэдэх үү? гэлээ. Эмэгтэй түүн рүү таагүйхэн харц чулуудлаа.

-Өө тийм үү, ямар сонин нээлт вэ Жойс! Сая песо амласан ч чамтай явна гэж бодоо юу?

-Үгүй. Түүндээ биш л дээ. Танд үдийн хоол чинь зохиогүй юм байна гэж мөрийцмөөр байна, хатантаан.

-Үүнээс ч болсон юм биш. Бүсгүй ийн хэлснээ дуугаа ялимгүй хөгжүүн болгож, бүр сая песо байлаа ч чамайг дээрээ гаргасан ямар ч хүүхэн даахгүй гэсэн ажгуу.

Жойсын царай мэнчийлээ. Тэр цааш эргэн зогсоод ярих ажээ.

-Хатагтай! Таныг өнөөдөр барахгүй юм байна. Та давтсан махаа идээд харьж унтах нь дээр дээ.

-Би өнөөдөр өлсөөгүй байна.

Эмэгтэй цонхны цаана сүлжилдэх хүмүүс, тоос шороот хотыг ширтэх авай. Ресторанд бүүдгэр агаад нам гүм байв. Зөвхөн тавиурын тэнд Жойсын түгдгэнэх нь нам гүмийг эвдэх ажээ.

Эмэгтэй гудамж руу ширтэхээ гэнэт больж, нэг л өөр урьхан зөөлөн дуугаар,

Чи үнэхээр надад хайртай юм уу? гэлээ.

Жойс эмэгтэй рүү харалгүй,

-Тийм хэмээн хуурайдуухан хариуллаа.

Сая би чамд эвгүй юм хэлсэн ч гэсэн үү? хэмээн бүсгүй шалгаалаа. Жойс бүсгүй рүү үл харсан хэвээр, урьдын хөндий дуугаар,

-Та юу гэж хэлсэн билээ? гэлээ.

-Нөгөө сая песоны тухай.

-Би тэр яриаг чинь аль хэдийнэ мартчихсан.

-Тийм бол чи надад үнэхээр хайртай юм уу?

-Тийм ээ.

Яриа зогслоо. Жойс ямар нэгэн юм хийсээр, эмэгтэй рүү биш ханын шүүгээ рүү харсаар байх аж. Эмэгтэй тамхиныхаа бөөн утааг үлээгээд цээжээрээ лангуу налан тонгойж өлмий дээрээ явах мэт болгоомжтойгоор хэлээ хазлан байж, чи надтай унтахгүй ч гэсэн үү? гэж асуулаа.

Жойс сая л бүсгүй рүү харж:

-Би танд маш их хайртай учраас унтахгүй байсан ч яахав гэж өгүүлэв. Тэрбээр ингэж хэлснийхээ дараа бүсгүй рүү дөхөж очин хүчирхэг гараараа лангуу тулан тонгойж, нүд рүү нь ширтэн байж,

Би танд маш их хайртай учраас тантай явалддаг эрчүүдийг шөнө болгон алсан ч чадна гэлээ.

Бүсгүй тэрхэн зуураа цочирдсон мэт харагдлаа. Дараа нь тэр мань эрийг шоолох, өрөвдөхийн завсар ширтээд бяцхан тулгамдаад дуугаа хураалаа. Эцэст нь эмэгтэй гэнэт чангаар инээд алдаж, Жойс, чи хардаж байгаа юм уу. Ёстой алдаг эр байх нь гэсэн авай.

Жойс хамаг нууцаа гэнэт алдсан хүүхэд мэт үнэн сэтгэлээсээ ичингүйрэн улайв.

-Өнөө орой та юу ч ойлгохгүй юм шиг байна. Хатагтай. Мань хүн ингэж хэлээд алчуураар нүүрээ арчин, энэ муухай хорвоо таныг эвдэж байна даа хэмээн үргэлжлүүлэв.

Эмэгтэйн байдал өөр болж ирлээ. Гэхдээ л гэснээ бүсгүй үгээ таслаад гутарч цөхөрсөн ч гэсэн итгэл найдварын гал бөхөөгүй байсаар байх Жойсын нүд рүү ширтэн:

Тэгвэл чи харгүй гэж үү? гэлээ.

-Өөрийнхөөрөө л гэх үү дээ. Гэхдээ таны бодсон шиг биш хэмээн Жойс хариулаад цамцныхаа захыг султган алчуураар нойтон энгэр заамаа арчлаа.

Тэгээд? хэмээн бүсгүй лавлав.

-Би танд хайртай болохоороо ийм ажил хийхэд тань дургүй.

-Ямар ажил гэж?

-Өдөр болгон өөр өөр эрчүүдтэй уулздаг ажилд чинь.

-Хэн нэгэн эр хүнийг надтай явуулахгүйн тулд та түүнийг цааш нь харуулж чадах юм уу?

-Явуулахгүйн тулд биш харин тантай явалдвал алах л болно.

-Ялгаа нь юу байгаа юм?

Тэр хоёрын яриа улам сонирхолтой болж ирлээ. Эмэгтэй аяархан дур булаам дуугаар ярих аж. Эмэгтэй үгийнх нь мананд төөрсөн мэт хөдөлгөөнгүй зогсох эрийн эрүүл амгалан царайд нүүрээрээ бараг тулах шахжээ.

-Энэ бол үнэн шүү хэмээн Жойс хэллээ.

-Үнэхээр л тийм бол. Эмэгтэй ийн өгүүлээд тамхитай гараа өргөн, нөгөө гараараа Жойсын үсэрхэг шуунд хүрэнгээ:

-Чи үнэхээр хүн алж чадах юм уу гэлээ.

-Тийм юмны төлөө бол чадна. Тийм ээ хэмээн Жойс хариулахдаа дуу нь чичирхийлж байв.

Эмэгтэй илэрхий тохуурхсан өнгөөр агдагнан инээд алдлаа.

-Өө ямар онцгүй юм бэ гээд тэр үргэлжлүүлэн хөхөрч, Жойс хүн алах гэнэ. Надаас төлбөр авалгүй өдөр болгон давтсан мах шарж өгөөд намайг ямар нэгэн эр хүн олтол дэмий ярьж зугаацдаг энэ хуурамч бүдүүн эрийг алуурчин гэж хэн бодох вэ? Онцгүй байна, онцгүй Жойс! Чи намайг айлгаж орхилоо гэлээ.

Жойс мэгдэж орхив. Мань хүн бүр зэвүүцсэн ч байх. Магадгүй эмэгтэйг хөхөрч эхлэхэд хуурагдан мэхлэгдсэн мэт санагдсан болов уу.

-Та согтуу байна. Тэнэгхэн минь! Явж жаахан унт. Бүр юм идэж байгаагаа ч мэдэхгүй байх шиг байнаа даа хэмээн тэр хэллээ.

Харин эмэгтэй инээхээ больж дахин ширээ тулан бодлогоширлоо. Тэрбээр Жойс цааш явж хөргөгч нээснээ юу ч авалгүй буцааж хаагаад лангууны нөгөө үзүүрт очин тэртэй тэргүй цэвэрхэн гялалзах шилэн аягануудыг арчихыг дагуулан харж байв.

Тэгснээ өмнө нь чи надад үнэхээр хайртай юм уу гэж асуусан шигээ зөөлөн ялдам дуугаар Жойс! хэмээн дуудлаа. Жойс түүн рүү харсангүй.

-Жойс!

-Гэртээ харьж унт. Унтахынхаа өмнө сайхан усанд ороорой. За юу?

-Жойс. Яг үнэндээ бол би уугаагүй эрүүл байна.

-Гэхдээ та нэг л сонин байна.

-Нааш ир. Би чамтай юм яримаар байна.

Рестораны эзэн үл итгэх, баярлахын завсар эмэгтэй рүү дөхлөө.

-Улам ойртооч дээ.

Жойсыг түүнд тулж очиход эмэгтэй үсийг нь илт эрхлэнгүйгээр хуруундаа ороон байж,

Сая ярьснаа дахиад эхлээч дээ гэв.

-Энэ чинь юу гэсэн үг билээ?

-Чи эрчүүд надтай унтвал алж чадна гээ биз дээ?

-Тийм ээ зөв. Би тантай унтсан эрчүүдийг алж чадна.Хатагтай.

Бүсгүй түүнийг явууллаа. Тэгснээ:

Хэрвээ би түүнийг алчихвал чи намайг хамгаалах уу? хэмээн шамдангуй лавлахад Жойс гахайных мэт зантгар нүүрээ бүсгүй рүү харуулан сээтгэнэх болхидуухан дүр үзүүллээ.

Гэхдээ мань эр юу ч хэлэлгүй зөвхөн инээмсэглэх ажээ.

-Жойс. Хэл л дээ. Би түүнийг алчихвал чи хамгаалах уу?

-Гэхдээ ингэж хамгаалах амар биш байх л даа.

-Цагдаа нар чамаас илүү хэнд итгэхэв дээ.

Энэ үгэнд Жойсын сэтгэл ханан маадгархан инээмсэглэлээ. Эмэгтэй дахин лангуу дамнан тонгойгоод,

-Тийм биз дээ Жойс. Би чамайг амьдралдаа нэг ч удаа худлаа хэлж байгаагүй гэж мөрийцөхөд ч бэлэн байна гэв.

-Тэр талаар ч асуудал байхгүй гэж Жойс хариуллаа.

-Цагдаа нар чамайг сайн мэддэг болохоор чиний хэлсэн бүгдэд итгэх болно.

Жойс лангууныхаа цаана юу хэлэхээ мэдэхгүй түггэднэлээ. Эмэгтэй гудамж руу дахиад л ширтэж эхлэв. Дараа нь рестораны үйлчлүүлэгчид орж ирэхээс өмнө яриагаа дуусгах гэсэн мэт дуугаа өөрчлөн:

Жойс! Чи миний төлөө худлаа хэлж чадах уу? Яг үнэнээрээ шүү хэмээв.

Жойс толгойд нь ямар нэг суут санаа гялс хийх мэт эмэгтэйг нухацтайяа харлаа. Мөн сая нэг

чихээр нь ороод нөгөө чихээр нь гарч одсон тэрхүү суут санааны халуун бүлээн ул мөр чихэнд нь дүнгэнэх шиг болов.

-Та юу гээчтэй хутгалдаад байна даа, хатагтай хэмээн Жойс дуугараад лангуугаа тулан урагш бөхийлээ.

Эмэгтэй түүний эхүүн амьсгалыг шууд мэдэрсэн агаад Жойсын гэдэс лангуунд шахагдсан тул уг эвгүй үнэр улам ч хэцүү болж эхэллээ.

-Хатагтай минь! Энэ тоглоом биш шүү. Та юунд л хутгалдаад байна даа хэмээн Жойс асуулаа. Эмэгтэй хажуу тийш гилжийн:

-Юутай ч хутгалдсан юм байхгүй. Би зүгээр л өөрийгөө зугаацуулж байгаа юм гэснээ Жойсыг ахин эгцлэн ширтлээ.

-Чи огт хүн алахгүй гэж боддог уу?

-Би хэн нэгнийг цааш харуулна гэж хэзээ ч бодож байгаагүй.

-Хэн нэгэнсэх юм байхгүй. Надтай унтсан хүнийг л гэж байна шүү дээ.

-Та ч бүр ярьж өгөх нь. Би таныг ийм юмтай орооцолдох хүн биш л гэж боддог. Хэрэв та үүнийгээ болих юм бол танд өдөр бүхэн хамгийн том давтсан мах үнэгүй шарж өгнө шүү.

-Баярлалаа Жойс. Гэхдээ учир нь үүнд биш. Би одоо эр хүнтэй унтах чадваргүй болсон.

-Та дахиад л хольж хутгаад эхэллээ дээ.

Жойс хэлээд дахин тээнэгэлзсэн байдалтай боллоо. Харин эмэгтэй хольж хутгаад байгаа юм байхгүй хэмээн хариу барьлаа.

Түүнийг суудлаа засан займчихад нь хөхнийх нь даруулга дор үзэгдэх хавтгай мээмийг нь Жойс ажиглаатахав.

-Би маргааш бүр явлаа. Дахиж чамайг зовоошгүй нь. Би хэнтэй ч дахиад унтахгүй гэж амлая.

-Та яагаад ингэж шийдэв?

-Би дөнгөж сая ингэж шийдлээ. Энэ бол их заваан ажил гэж бодлоо.

Жойс алчуураа шүүрч аван өмнөх аягануудаа зүлгэж эхэллээ. Тэрээр ярилцагч руугаа үл харан байж, тэгэлгүй дээ. Таны энэ ч заваан ажил л даа. Гэхдээ энийг аль хэдийнэ мэдмээрсэн дээ хэмээв.

-Би ч хэзээний л мэддэг байсан л даа. Харин дөнгөж одоо л бүрэн ойлголоо.

Жойс инээмсэглэлээ. Мань хүн инээмсэглэсэн чигээр харцаа дээшлүүлэн харцаа дээшлүүлэн

эмэгтэйг үзэхүл, цаадах нь бодлогошрон дүнсийж, нүүрэнд нь намрын эрт боловсорсон алтлаг өнгө туяарах шиг болоод хоёр мөрөө хавчин дүмбийн суух ажээ.

Тэгснээ Жойст хандан:

Өөртэй нь унтчихаад өөрийг нь жигшсэндээ цааш нь харуулах бодолтой ийм хүүхэнтэй наргих эр хүн байх уу? Чи юу гэж бодож байна? хэмээн асуув.

Жойс хоолой зангируулан:

Ийм юмаар толгойгоо гашилгаад яахав хэмээн хариуллаа.

-Хэрэв эмэгтэй хүн унтсан эрийгээ хувцсаа өмсөөд зогсож байхад нь ой гутаж байгаагаа хэлвэл яахав. Тэр хүнд шөнөжин талхиулсныхаа дараа, ой гутам үнэрийг чинь ямар ч саван ариутгаж дийлэхгүй болохоор зэвүү хүрээд байна гэж хэлбэл яахав, аан Жойс?

-Ариутгаж бололгүй дээ. Ийм юмны төлөө түүнийг алах шаардлагагүй ээ. Зүгээр явуулчих хэрэгтэй.

Жойс ийн хэлэнгээ лангуугаа зүлгэх аж. Харин эмэгтэйн дуу улам догдлонгүй болж ирлээ.

-Гэхдээ ой гутаж байгаагаа хэлсээр байтал хувцсаа өмсөхөө больчихоод ахиад ноолоод унавал...

-Олигтой эр хүн бол ийм юм хийхгүй л дээ.

-Хэрэв хийвэл яах вэ гэж байна шүү дээ.

Эмэгтэй дээрхийг хорсолтойгоор хэлснээ:

-Хэрвээ эр хүн өөдгүй амьтан байгаад эмэгтэйгээ дургүйцэн ой нь гутаж бүр үхмээр байхад нь ноолоод байвал яахав. Түүнийг хутгалж алахаас өөр замгүй байвал яах юм? хэмээн үргэлжлүүлээ.

-Энэ ч онцгүй л дээ. Гэхдээ ийм юм хийх эр хүн байхгүй биз дээ.

-Хэрвээ байвал яахав.

-Гэхдээ бүр тийм яадгаа алдсан амьтан байхгүй байлгүй дээ.

Жойс лангуугаа арчсаар байх агаад ярих сонирхолгүй болсон байлаа.

Эмэгтэй хурууныхаа үеэр ширээ тогшлоо. Тэрээр эдүгээ буурьтай, шийдэмгий харагдах аж.

-Тэнэг минь, чи юу ч ойлгосонгүй хэмээн бүсгүй хэлээд Жойсын ханцуйнаас татан өөртөө ойртуулаад ийм үед эмэгтэй нь эрэгтэйгээ алах ёстой гэж хэл л дээ хэмээв.

-За за. Таныхаар болог хэмээн Жойс эвлэрэхийг хүссэн маягтай дуугарлаа. Эмэгтэй мань эрийн ханцуйнаас чангаасан хэвээр,

-Энэ чинь аргагүй хамгаалалт мөн биз дээ хэмээн шалгаалаа.

-За бараг тийм юм даа. Рестораны эзэн ийн хэлээд эмэгтэй рүү нүд ирмэсэн нь сэтгэл зүрхээ ч өгч, гэмт хэргийн хамтрагч ч болж буйгаа илтгэх маяг үзүүлсэн нь тэр байлаа.

Гэвч эмэгтэй үнэн сэтгэлээсээ ярьсаар байх авай.

-Ийм эмэгтэйг хамгаалахын тулд худлаа мэдүүлэг өгч чадна биз дээ?

-Энэ ч нөгөө юунаас л болно л доо.

-Юунаас болно гэж?

-Цаад эмэгтэй хэн бэ гэдгээс болно доо.

-Чи тэр эмэгтэйд маш их хайртай гээд төсөөл. Хамт амьдардаггүй ч гэсэн.

-За за. Таны хэлснээр больё хатагтай.

Жойсын санаа амарч бүр залхсан шинжтэй байв. Тэр цааш нааш холхисонгүй, харин цагаа харж зургаан цаг гучин минут болж буйг үзлээ. Тэрээр цонхоор гадагш ширтэн, шилэн аягануудаа улам хичээн арчиж буйгаа удахгүй үйлчлүүлэгчид ирэх тул тэр биз хэмээн өөр зуураа бодох авай.

Харин эмэгтэй сандал дээрээ биеэ барьсан байдалтай чимээгүйхэн сууж, рестораны эзэн эрийг мөнхийн гунигтай нүдээр ширтэх ажгуу.

Тэгснээ гуйсан өнгөөр

Жойс! хэмээн дуудлаа.

Цаадах нь түүнийг гунигтай зөөлөн нүдээр харлаа. Гэхдээ эмэгтэй түүнтэй ганцаардлаа хуваалцаж, хайр хамгаалал хүссэндээ биш, зүгээр л тохуурхан харж байгаа даа гэж бодсон тул нэг их сонсох ч гэсэнгүй.

-Би маргааш явлаа гэж хэлсэн. Харин чи юу ч хэлэхгүй юм аа.

-Тийм л дээ. Гэхдээ хаашаа явахыгаа хэлээгүй шүү дээ та.

-Эндээс л лав явна. Хэн нэгэнтэй унтаж хонох хүсэлтэй нэг ч эр хүнгүй тийм газар луу явлаа.

Жойс дахин инээмсэглэлээ. Тэгснээ мань эр гэнэт амь орсон мэт нүүрээ хувирган,

Та үнэхээр бүр явах гэж үү хэмээн лавлав.

-Энэ танаас л шалтгаална. Хэрэв чи намайг энд хэдэн цагт ирснийг минь чин үнэнээр хэлэх юм бол би цаашид хэзээ ч ийм юмтай орооцолдохгүй. Тэгж тохирох уу?

Жойс өөртөө итгэлтэй инээмсэглэн толгой дохилоо. Эмэгтэй түүн рүү тонгойв.

-Харин намайг хэзээ нэгэн цагт эргэж ирэхэд минь чи яг энэ цагт, энэ сандал дээр хүүхэн суулгачихсан ярилцаж байх юм бол би хардана шүү.

-Та эргэж ирэхдээ надад бэлэг авчирна биз дээ?

-Би ертөнцийн нөгөө өнцгөөс хамаагүй сургуультай баавгай олж аваад чамд авчирч өгнө өө.

Жойс инээмсэглэн эмэгтэй тэр хоёрын хоорондох үл үзэгдэгч шилэн ханыг арчих мэт алчуураа агаарт хөдөлгөлөө. Эмэгтэй ч гэсэн үнэн сэтгэлээсээ сээтгэнэх янзтай инээмсэглэх ажээ.

Дараа нь Жойс лангууныхаа нөгөө буланд очин шилэн аягануудаа дахин арчиж гарав. Тэгснээ:

Дараа нь яахав хэмээн дуугарлаа.

-Чи хүн асуувал намайг зургаад арван таван минут дутуу байхад энд орж ирсэн гэж үнэхээр хэлнэ биз дээ?

Рестораны эзэн энэ удаа эмэгтэйг дөнгөн данган сонсож буй мэт царайлан зөрүү харсан хэвээр:

-Яах гэж хэмээн асуулаа.

-Энэ хамаагүй. Зүгээр л тэгээд хэлчихвэл болно гэж эмэгтэй хариуллаа.

Энэ үед анхны үйлчлүүлэгч рестораны хаалгаар орж ирэн лангуу руу алхлаа. Жойс цагаа харахад зүү нь яг зургаан цаг гучин минут дээр гозойж байв.

-За. Хатагтай. Таныг юу ч гэсэн би хэлснээр чинь хийнэ хэмээн Жойс яарангуй өгүүлэхэд,

-Тэгвэл сайн байна. Одоо хоолыг минь бэлдээд орхи гэж эмэгтэй хэллээ.

Жойс хөргөгч рүүгээ очин, дотроос нь хэрчих махтай таваг гарган ширээн дээр тавиад зуухаа асаалаа.

-Би танд үдэлтийн сайхан зоог барья хатагтай!

-Баярлалаа, Пепилло!

Эмэгтэй гэв гэнэтхэн шавар хүмүүсээр дүүрэн хачин ертөнцөд очсон мэт гүн бодлогошрон хэсэг суулаа.

Тэрбээр лангууны тэртээ буланд түүхий махыг буцламгай тосонд хиймэгц тас нясхийхийг үл сонсох ажээ. Түүнчлэн Жойсын эргүүлж тойруулсан давтсан мах шаржигнан шарагдах, шүүслэг үнэр нь зоогийн газрын агаарт нэвчин үнэртэхийг ч анзаарсангүй.

Эмэгтэй ийнхүү хэсэг сууснаа түр зуур үхээд амь орох мэт нүдээ цавчиллаа. Тэр зуухныхаа хөгжилтэйхэн дүрэлзэх галд туяаран зогсоо зоогийн газрын эзэн эрийг харлаа.

-Пепилло!

-Аан.

-Чи юу бодож зогсоно вэ?

-Таныг нэг тийм жижигхэн, хөөрхөн бамбарууш олж чадах болов уу л гэж гайхаж зогсоно.

-Тэгэлгүй яахав. Чадна. Чадна. Харин чамайг гуйсан болгоныг минь биелүүлээсэй гэж хүсэх байна. Үдэлтийн бэлэг чинь болог.

Жойс зуухныхаа дэргэд зогссон хэвээр эмэгтэйг ажиглан хараад, би танд өмнө нь зөндөө хэлсэн. Та миний давтсан махнаас гадна өөр ямар нэгэн юм хүсээ юу? гэлээ.

-Яг тийм.

-Юу хүсч байна гэж?

-Надад дахиад нэг арван таван минут хэрэгтэй байна.

Жойс арагш эргэн цагаа харлаа. Дараа нь лангууны нөгөө үзүүрт чимээгүйхэн зогсоо үйлчлүүлэгч рүүгээ нэг, хайруулын таваг руугаа нэг харлаа. Зөвхөн дараа нь л үг хэлэх сөгөөтэй болов.

Тэгээд, хатагтай минь! Би ёстой юу ч ойлгосонгүй хэмээв.

-Жойс! Тэнэгтэхээ боль л доо! Би энд тав гучид ирсэн шүү. Битгий мартаарай гэж эмэгтэй хэлвэй.

Бямба гаригийн маргааш

Үзэсгэлэнгийн хоёр танхим, үйлчилгээний есөн өрөө бүхий асар том байшиндаа амьдрагч бэлэвсэн эхнэр Ребека салхивчнууд нь гаднаасаа нүх гарсан байхыг олж үзсэнээр энэ явдал эхэллээ.

Тэгэхэд зургадугаар сар болж байв. Тэрбээр анх унтлагын өрөөнд нь ийм явдал болсныг үзээд өөрийн зарц, нөхрөөс нь хойш итгэмжлэгдсэн хүн болоод буй Арженидад хэльюү гэж бодов. Тэгснээ тавилга хогшлоо ийш тийш нь шилжүүлж байхдаа (Ребека юу ч хийхгүй боловч тавилга, хогшлоо л зөөж шилжүүлдэг болсоор уджээ) зөвхөн унтлагын өрөөний төдийгүй бусад бүх салхивч сүйтгэгдсэнийг мэдээтхэв.

Энэхүү бэлэвсэн эхнэр болбоос туйлын эрхэмсэг зантай хүн бөгөөд дээр цагт, тусгаар тогтнолын дайны үед хааны талд байлдаж явсан ба хожим нь III Чарльзын байгуулсан Сан Илдефонсо хотыг үзэх гэж л Испани руу бэрх хүнд аялал хийж явсан эцгийн талын өвгөөсөө энэ чанарыг өвлөсөн аж.

Ребека ийнхүү байдлыг хараад Арженидатай ярилцахаа больж уг явдлыг хотын захиргаанд мэдэгдэхээр хамба хилэн цэцгэн хээ шигтгэсэн сүрлэн малгайгаа өмсөн гарч одов.

Түүнийг захиргаан дээр очиход захирагч мөн л адил эвдэрсэн салхивчнуудыг өөрийн биеэр засан завгүй байх нь үзэгдэв. Захирагч цамцгүй байх агаад үсэрхэг цээжээ ил гарган хэнэггүй байх нь бэлэвсэн эхнэрт бүдүүлэг муухай санагдаж байв.

Ребека эмх цэгцгүй бохир өрөөнд орвол ширээн дээр нь үхсэн шувууд овоолоостой харагдав. Гэвч тэрбээр нэгд гадаах халуун, хоёрт салхивчнууд нь эвдэрснээс төрсөн зэвүүцэл хоёроос болоод уг шувууд яагаад ийм болсныг бодох ч хүсэлгүй байв.

Түүнчлэн захирагч шатны дээр эвдэрсэн салхивч янзлан түүнийг үл анзааран буй нь нэр төрийг нь гутаасан мэт олиггүй санагдаж байв. Тэрээр салхивчийг нь эвдсэнээр өөрийнх нь нэр төрд халдсан тухайд л зөвхөн бодож байсан тул хотын захиргааны мөн л эвдэгдсэн салхивчийг үзээд ч ямар нэг уялдаа холбоо олж харсангүй. Тэрбээр ёсорхуу, албархуу дүр эсгэн, нарны халхавчныхаа гоёмсог бариулыг түшин байж,

Би санал гомдлоо бүртгүүлмээр байх юм хэмээн өгүүлэв.

Шатны дээд тавцан дээр байсан захирагч халуунд мэнчийсэн царайгаа сая л нэг юм харуулав. Тэгэхдээ бэлэвсэн эхнэр албан өрөөнд нь морилсон энэхүү чухал хэрэгт баярласан байдал огт гаргасангүй. Урьдын адил өмнөх салхивчныхаа бэхэлгээг тайвнаар салгах зуураа “За юу болоов” гэж асуулаа.

-Хөршийн банди нар салхивчнуудыг минь сүйтгээд хаячихлаа.

Захирагч эмэгтэйг дахин харлаа. Тэрбээр малгайных нь цэцгэн хээнээс мөнгөлөг өнгөт гутал хүртэл амьдралдаа анх үзэж буй мэт тун хянамгай ширтлээ. Тэгснээ түүнээс харц үл салгасан хэвээр залхуутайяа хөдлөн бууж ирээд нэг гараараа тэлээгээ барьж халив бариастай нөгөө

гараараа ширээ рүү занган:

-Хатагтай гуай, банди нар биш. Энэ бол шувууд гэв.

Ингэж хэлэхэд л Ребека хатагтай ширээн дээрх үхсэн шувууд, шатны тавцан дээрх захирагч гэрийнх нь эвдэрхий саравчтай ямар холбоотойг арайхийж ухаарав. Тэрбээр унтлагын бүх л өрөөнүүддээ үхсэн шувууд хөглөрөлдөн буй дүр зургийг дотроо дүрслэн бодож, шувууд! хэмээн уулга алдав.

Шувуу! Захирагч ийн давтаад, та анзаараагүй чинь сонин юм. Түүнээс биш шувууд цонх мөргөөд байшин дотор орж үхдэг явдал гараад бүтэн гурав хонож байна даа гэж өгүүллээ.

Ребека хотын захиргаанаас гарч явахдаа ичиж зовсон байлаа. Басхүү суурингийн бүхий л хов живийг ярьдаг мөртлөө шувуудын тухай ганц ч үг дурсаагүй Арженидад ч уур хүрэв.

Тэр дөхөж буй наймдугаар сарынх мэт хурц наранд гялбалзах халхаа дэлгэн суурингийн эзгүй бүгчим гудамжаар алхахдаа бүх л байшингуудын бүхий л унтлагын өрөөнүүдээс үхсэн шувууны хурц нялуун үнэр сэнгэнэж буй мэтээр төсөөлөн байсан ажгуу.

Энэ бол зургадугаар сарын сүүл үе байсан агаад тосгоны түүхэнд байгаагүй их халуун болж байлаа. Гэвч шувуудын үхэлд сэтгэл үймэрсэн суурингийнхан түүнийг ч анзаарах сөхөөгүй байсан хэрэг.

Хэдий уг хачирхалтай явдал амьдрал ахуйд нь шууд нөлөөлөөгүй ч тэдний ихэнх нь бүр наймдугаар сарыг түгшсэн хэвээр угтав. Харин Ариун Дээд Тарнийн сүмийн санваартан, гурван янзын муу үйл хийж буй шулмасыг харсан хэмээн барин тавин хэлдэг, гүн сүсэгт 94 настай номхон өвгөн л тэдгээрийн тоонд үл багтаж байв.

Мань өвгөн эхлээд хоёр ч үхсэн шувуу олж үзээд тоогоогүй аж. Эхнийхийг нь мягмар гаригийн мөргөлийн дараа сүмийн агуулахаас олоод мууранд бариулчихаж хэмээн бодож. Маргааш нь хоёр дахийг нь мөргөлийн байрныхаа тагтнаас олоод мөн л муурнаас зайлахгүй хэмээн бодож, хөлөөрөө өшиглөн туусаар гудамжинд гаргаж хаясан аж.

Мань өвгөн баасан гаригт галт тэрэгний буудал дээр очоод урт сандалд нь тухлах гэтэл тэнд бас нэг үхсэн шувуу байх нь тэр. Санваартан гуай уг шувууг хөлнөөс нь өргөн эргүүлж тойруулан шинжээд, тэнгэр минь, энэ долоо хоногт гурав дахиа үхсэн шувуу оллоо хэмээн бодов.

Энэ тохиолдлын дараа Антони Изабел эцэг ламтан сууринд юу болоод байгааг ойлгож эхлэв. Гэхдээ сүсэгтнүүд ухаан санаа нь үүлэнд хөвж явдаг ч түүнийг хичээнгүй, номхон сайн хүн хэмээн үнэлдэг, гурван муу үйл үйлдэгч шулмасыг харсан гэж тангарагладаг энэ нь суурингийнханд жаахан давсалсан мэт санагддагийг хэлэх хэрэгтэй) басхүү өндөр настай тул дээрх явдлыг жаахан буруу ойлгосон ажгуу.

Тэр шувуу тойрсон энэ явдлыг анзаарсан хойноо ч уг хэрэг шашны номлол сургалтаас чухал гэдэгтэй эвлэрэхгүй байлаа.

Ер нь бол эцэг Антони Изабел үхсэн шувууны эвгүй үнэрийг анх үнэртсэн хүний нэг юм. Тэр баасан гаригийн шөнө намуухан салхиар тархсан эвгүй үнэрт сэрээд хар дарсных уу аль эсвэл зүүд нойрыг нь түйвээх гэсэн шулмасын илбэ (жилбэ) үү гэж бодсон хэрэг. Тэр эргэн тойрныг шиншлэн үнэртэж байхдаа шулмас гэгч хүний таван мэдрэхүйн алинд нь ч нэвтрэн хорлодог тухай шашны номлолын үнэн зөвийг биеэрээ үзэв гэж сэтгэжээ.

Харин маргааш нь нийтийн мөргөлийн өмнө довжоон дээр зугаалж яваад хэн нэгэн нь үхсэн шувууны тухай ярихыг сонсов.

Долоо хоногийн турш цуглуулсан шувуудын сэг ийн үнэртэж буй тухай хэн нэгэн нь ойлгуулах хүртэл номлол сургааль, шулмас хийгээд үнэрлэх эрхтнээр дамжуулан үйлдэгдэх нүглийн тухай бодож байсан ламтны ухаан бодол самууран, библийн анхааруулга, шулмасын үнэр, үхсэн шувууд толгойд нь холион бантан болон чихцэлдэв.

Ням гаригт тэрбээр ариун номоос ерөнхийд нь ойлгодоггүй уртын урт хэсгийг чангаар дуудан уншиж аваад шулмас болон мэдрэхүйн таван эрхтэн хоорондын тухай бодлоо таягдан хаясан бүлгээ.

Гэхдээ л уг бодол тархиных нь мухарт үлдсэн байх. Учир нь далан жилийн өмнө шашны сургуулийн сурагч байхад нь ч тэр, ер гарсан хойно нь ч тэр ийм явдал тохиолдсоор байгаа юм.

Тэртээ шашны сургуульд нэгэн бороотой өдөр Софоклын гар бичмэлийг уншиж байгаад бороо зогссон хойно цонхоор байгаль дэлхийн гоо сайхныг хараад Грекийн театр, сонгодгуудын тухай мартаж орхисон явдал бий аж.

Иймэрхүү бүтээлүүдийг “эртний бяцхан туг” гэдэг байлаа тэр үед. Уг явдлаас гуч юмуу дөчин жилийн хойно тэрээр тосгоны чулуун ордон дотор явж мөнөөх семинарт уншиж байсан Софоклын шүлгийн мөрүүдийг огтхон ч түвэггүй дуржигнуулсан аж. Тэгэхэд ламтан баялаг сэтгэхүйтэй, яриа хөөрөөтэй дэд хамбатай чухамхүү “эртний бяцхан туг”-ийн тухай удтал ярилцсан юм даг.

Тэрхүү дэд хамбаган болбоос ярвигтай үгсийн эвлүүлэг гэгчийг зохиов хэмээн ярьдаг байсан ба тэр нь олон жилийн хойно үгийн сүлжээ нэрээр нийтэд тархжээ.

Ламтан тэр үед юмыг задлан шинжилдэгээрээ шагшигдан бүр ширээт лам ч болох бололцоотой болоод байсан аж. Гэвч бүр 1885 оны дайнаас төө өмнө тосгонд шигдэж орхисон тул тэр бололцоо ч лөөлөө болоод өөрийг нь залуу номлогчоор солих тухай яригдаад зөндөө удсан хойно унтлагын өрөөнд нь шувуу үхсэн өнөөгийн энэ хэрэг тохиолдсон ажгуу.

Чухам яг энэ явдлаас хойш тосгоныхон түүнийг ердөө хайхрахаа больсон агаад гар бичмэлээ харааны шилгүйгээр уншиж чадаад байгаа ч мань хүн энэ хайхрамжгүй байдлыг нэг их сайн ойлгоогүй л байв.

Антони Изабел ламтан ер нь хэвшмэл зуршилтай хүн билээ. Жижигхэн, үл ажиглагдам биетэй, тайван дөлгөөн зантай номлолын үед хүнд муухан сонсогддог аргадангуй дөлгөөн

дуутай нэгэн ажгуу. Тэрбээр үдийн цай хүртэл шулханагандаа бүчтэй сарж даавуун өмдөө л зөвхөн өмсөөстэй чигээрээ түшлэгтэй сандал дээр нойрмоглоон суудаг зантай ажгуу.

Тэгээд ч тэр олон нийтэд ном айлдахаас өөр албагүй хүн юм. Хэдий долоо хоногт хоёр ч удаа нүгэл наманчлах нууц бүхээгт ажилладаг боловч тэнд нь хэн ч ирдэггүй аж.

Ийнхүү хүмүүс нүглээ үл наманчилж буй явдал нь тэд сүсэг бишрэлээ гээснийх гэж ламтан бодох ба шулам үзэгдэж буй нь үүний баталгаа хэмээн сэтгэх бүлгээ.

Гэхдээ шулам харагдсан явдалд мань хүн өөрөө ч хүмүүс ч эргэлздэг бүлгээ.

Ламтан сүүлчийн тав орчим жилд төдийгүй үхсэн шувуу олдсон эхний хоёр тохиолдолд ч үхдэл мэт амьдралаас тасархай байснаа гэнэт ойлгосон хэрэг. Гурав дахь шувуу олдсоны дараагаар л амьдралд алгуурхан буцан орж тэр ч бүү хэл галт тэрэгний сандал дээр үхсэн шувууны тухай байнга бодох болжээ.

Тэр сүмээс аравхан алхам зайд ажлын болон унтлагын өрөө, гудамж руу харсан тагт бүхий салхивчгүй жижиг байшинд амьдрах бүлгээ. Мань хүн энэ хорвоогийн аз жаргал гээчийг ийм дулаахан биш байшинд ч амсаж болдгийг гайхан мэдэрдэг биз гэж бодмоор.

Тэр өглөөгүүр хаалга нь хагас онгорхой өрөөндөө нүдээ анин сууж, гүн ухаан бясалгах авай. Гэхдээ сүүлийн гурван жилд ийн суухдаа бүр юу ч бодохоо больсноо өөрөө ч үл анзаарах ажээ.

Яг арванхоёр цагт үдийн хоол нь идэх бөгөөд үүнд нь ясны тунгалаг шөл, цагаан будаа, сонгиногүй мах, шарсан гадил юмуу эрдэнэ шишийн талх, ламтны хэзээ ч амсаж үзээгүй хэдэн ширхэг сэвэг зарам байх бүлгээ.

Хоол зөөгч хөвгүүн зоогийн савыг санваартны сууж буй сандлын дэргэд тавих бөгөөд өвгөн хөвгүүний хөлийн чимээ дуулдахаа болих хүртэл нүдээ ч үл нээх ажээ. Ийм болохоор нь ламтныг үдийн өмнө дугхийгээд авдаг хэмээн тосгоныхон бодох бөгөөд харин үнэн чанартаа шөнө ч олигтой унтаж чаддаггүйг нь мэддэггүй байв.

Энэ үед түүний дадал зуршил маш энгийн, бараг бүдүүлэг гэмээр болоод байв. Тэр суудлаасаа ч өндийлгүй сэрээ, хутга, таваг үл хэрэглэн ганц халбагаар хоолоо зооглох аж. Дараа нь толгойгоо бяцхан норгож, шаан хээтэй цамцаа өмсөөд тосгоныхон ид дугхийн буй цагаар төмөр замын буудал руу зүглэх бүлгээ.

Тэр сүүлийн хэдэн сарын турш яг энэ маршрутыг баримталж буй агаад шулмас үзэгдэх үед бодож олсон уншлагаа дүнгэнүүлэн сажилдаг байв.

Үхмэл шувууд унаж эхэлсэн тэр явдлаас хойш 9 өдрийн дараа нэгэн бямба гаригт Гэгээн нууцын сүмийн санваартан, эцэг ламтан Антони Изабел Ребека авгайн байшингийн өмнүүр явж байтал нэгэн үхсэн шувуу яг хөл дор нь унасан бүлгээ. Санваартны толгойд зөн билэг нь гялсхийх шиг болж тэр шувуу бусад шувуудтай адилгүй аврагдаж болох юм гэсэн бодол зурсхийв.

Санваартан Ребекагийн хаалгыг тогших үед цаадах нь өдрийн унтлагандаа бэлтгэн хөхөвчөө тайлж байсан ажгуу. Унтлагын өрөөндөө байсан бэлэвсэн эхнэр тогшилтыг сонсоод салхивч руугаа өөрийн эрхгүй харлаа. Сүүлийн хоёр өдөр салхивчаар шувуу орж ирээгүй билээ. Харин салхивч эвдэрсэн байсан амой.

Ребека санаа сэтгэлийг нь урвуулсан явдал болох шувуудын довтолгоо эхэлсэн мөчөөс л хойш салхивчнуудыг засах үргүй зардал гарах нь дээ хэмээн сэтгэл зовнисоор байгаа юм.

Тэр цахилгаан сэнсний шуугианаас хаалга тогшихыг ялган сонсоод хонгилын нөгөө үзүүрт Арженида унтаж буйг ууртайхан саналаа. Гэхдээ өдий цагт хэн түүнийг ийн үймүүлж болох тухайд бодсон ч үгүй. Эмэгтэй хөхөвчөө буцаан өмсөөд өрөөний хаалгыг түлхэн хонгилд гарч, хайнгадуухан алхалсаар тавилга чимэглэл дүүрэн том өрөөгөө гатлан төмөр сараалжин хаалгыг нээхийн өмнө гартаа шувуу барин нүдээ анин дуугүй зогсоо эцэг Антони Изабелийг олж үзэв. Тэрбээр хаалга нээгдэхийн өмнө “бид энүүнд жаахан ус өгөөд тавган дээр тавьбал сэргэх байх даа” гэсэн авай.

Ребека хаалга онгойлгож өгөөд айсандаа ухаан алдаж унах дөхөв. Ламтан тэднийд таван минутаас илүү болоогүй бөгөөд ер нь ч эцэг ламтан тосгонд гучин жил амьдрахдаа тэднийд түүнээс илүү хэзээ ч удаж байгаагүйг тэгэхэд л бэлэвсэн эхнэр ухаарав.

Хэдий бэлэвсэн эхнэр ламтны холын хамаатан боловч том өрөөний баян тансаг тавилга болон байшингийн нууцлаг тачаангуй байдал нь ламтны дотроо бодоод байдаг нэгэн зүйлийг батлах мэт санагдаж байв. Бэлэвсэн эхнэрийн үеэл хурандаа Аурелино Буэндиа нэгэнтээ хамба ламтныг төрөл садантайгаа уулзахгүйн тулд тосгонд ирдэггүй гэж хэлсэн хэмээх домог шиг юм яригддагийг ламтан энэ үеэр эргэн саналаа.

Дээрх зүйл үнэн ч бай худал ч бай сүсэг бишрэлийн өчүүхэн ч тэмдэг үзүүлдэггүй бөгөөд жилдээ ганц удаа нүглээ наманчлахдаа нөхрийнх нь үхлийг тойрсон жигтэй явдлыг тодруулах гэсэн санваартны асуултанд булзааруулсан хариулт хэлдэг цорын ганц эзэмшигчтэй энэ байшинд эцэг ламтан Изабел нэг л тааламжгүй байдлыг мэдэрдэг ажгуу.

Санваартан гоёмсог дүүжин сандалд суун бэлэвсэн эхнэрийг хүлээж байхдаа хурандаа болон өөрийнхөө эхнэрийн үеэл ах Жойс Аркадио Буэндиа хорь гаруй жилийн өмнө гар бууны суманд өртөж, давируул болон тэлээгээ шажигнуулсаар дөнгөж тайлсан урт оймсон дээрээ нүүрээрээ шаан унасан тэр цагаас хойш амар амгаланг үзээгүй энэ байшингийн жигтэй хуурай хөндий уур амьсгалыг мэдэрчээ. Ребека том өрөөндөө буцаж ирэхдээ эцэг Антони Изабел дүүжин сандалд оньсого мэт сууж байхыг хараад дахин түгшлээ.

-Амьтны амь бол бурхан тэнгэрийн хувьд хүний амьтай ижилхэн байдаг хэмээн Антони Изабел хэллээ. Гэхдээ Жойс Аркадио Буэндиаг дурссангүй. Бэлэвсэн эхнэр ч энэ талаар бодсонгүй. Учир нь эцэг ламтан өөрт нь гурван ч удаа шулмас үзэгдсэн талаар номлогчийн индрээс ярьснаас хойш Ребека түүний нэг ч үгэнд итгэхгүй байхаар шийдсэн аж. Бэлэвсэн эхнэр ламтныг үл анзаарсан байдал зориуд эсгэн байж шувууг авч аягатай усанд дүрээд сэгсрэв. Түүний байдал хайхрамжгүй бөгөөд дургүй нь хүрсэн янзтай, амьтны амийг аврах ямар ч хүсэлгүй байгааг эцэг ламтан анзаарлаа.

-Та шувуунд хайргүй юмаа даа хэмээн тэр зөөлөн боловч хагуухан хэллээ. Бэлэвсэн эхнэр нүдээ солбин ширэв татлаа.

-Би өмнө нь шувуудад дуртай байсан. Гэхдээ байшин дотор минь орж ирж үхээд байгаа тул одоо бол үзэн ядаж байна гэж тэр ширүүллээ.

-Олон шувууд үхсэн дээ. Ламтан ийн хэлэхэд дууных нь өнгөнд гүн ухааны аялга сонсогдох шиг болов. Бэлэвсэн эхнэр жигшсэн байдлаар шувууны усыг шавхран тавган дээр тавих зуураа, бүгд үхдэг байсан ч яахав. Гэхдээ салхивчнуудыг минь эвддэггүй бол надад тээр болоод байх юм ч алга л даа уг нь гэсэн ажгуу.

Ийм хатуу зүрх сэтгэлтэнтэй өмнө нь учирч байгаагүй мэт сэтгэгдэл тэгэхэд эцэг ламтанд төрлөө. Дараа нь тэрбээр шувууны арчаагүй жижиг биеийг авч үзээд мөнөөх амьтан амьсгалахаа больсныг мэдэв. Тэр үүнийг мэдэнгүүтээ бүх зүйлийг, тэр дундаа байшингийн хөндий бөгөөд нууцлаг тачаангуй байдал, Жойс Аркадио Буэндиагийн биенээс ханхалж асан дарины хурц үнэрийг ор тас мартан долоо хоногийн эхээр мэдрэгдэж эхэлсэн ер бусын үнэнийг ойлгов.

Тэр бэлэвсэн эхнэрийн харцаар үдүүлэн гартаа үхсэн шувуу барин ууртай янзаар байшингаас гарч одохдоо үхсэн шувууд тэнгэрээс унасаар, Бурханы сонгосон элчийн хувьд ертөнцийн бүх шулам сөнөх тэр өдрийн тухай ариун сургаалийг таг мартсан байснаа санасан бүлгээ. Тэрбээр мөн өдрөө ердийнхөөрөө төмөр замын буудал руу явсан ч чухам яах гэж буйгаа төдийлөн ухаарахгүй байв. Тэр хорвоо дэлхийд ямар нэгэн юм болоод байгааг там тум ойлгож байсан агаад самууран будилж, хэлэх ч юмгүй болсноо мэдэрч байв. Түүнчлэн галт тэрэгний буудлын сандал дээр сууж байхдаа ертөнцийн бүх шулам устаж алга болох учиртай тэр цагт үхсэн шувууд тэнгэрээс унадаг тухай номонд бичсэн эсэхийг санахыг оролдсон ч чадсангүй, бүгдийг нь таг мартаж орхисон байв. Санваартан Ребекагийн байшинд саатсанаас болоод галт тэргийг өнгөрүүлж орхисноо санаад тасалбар түгээврийн газрын хагархай шилэн нүүртэй тоосонд даруулсан цаг нэгд 12 минут дугуу байгааг заасаар л байгааг харав. Тэр сандалд буцан суухдаа халууцан бүгчимдэж буйгаа мэдрэв. Мөн өнөөдөр бямба гариг шүү дээ гэж саналаа.

Эцэг ламтан далдуу модны навчсаар сүлжсэн дэвүүрээ хойш тавин хэсэг зүүрмэглээд өөрийнхөө жанч, гутал, биенд нь наалдсан уртаас урт шалбуур өмдөндөө уцаар нь хүрч маш их халууцаж байгаагаа мэдрэв. Тэрбээр суудлаасаа огт хөдлөлгүй жанчныхаа товчийг тайлан, ханцуйнаасаа алчуураа авч хөлөрсөн нүүрээ шудрах зуураа өөрийгөө газар хөдлөлт ч юмуу ямар нэгэн гамшигт үзэгдлийн гэрч болж байна хэмээн сэтгэсэн бүлгээ. Иймэрхүү зүйлийг тэр хаа нэгтээ уншсан аж. Гэвч тэнгэр цэлмэг, шувууд нь үл мэдэгдэх шалтгаанаар алга болсон огторгуй тод тунгалаг хэвээр үзэгдэх авай. Тэр ийнхүү тэнгэр ширтэх зуураа шувуудын үхлийн талаар хэсэг зуур мартсан байлаа.

Тэр одоо өөр юмны тухай, тухайлбал гэнэт хүчтэй шуурга босч болох тухай бодов. Гэвч тэнгэр урьдын адил дөлгөөхөн, болор тунгалаг байх агаад энэ тэнгэрийг харж буй нүд нь ч хөндлөнгийн хүнийх мэт бодогдох нь хачин. Түүнийг хойт зүгт хараа бэлчээхэд далдуу модны дээгүүр байшингийн зэвтэй дээврүүд харагдан, овоолсон хогон дээгүүр нисэлдэх элээнүүдийн удаан, чимээгүй дүрс үзэгдэх аж. Хачирхалтай нь тэртээ дээр идэр хөвгүүн

ахуй цагтаа нэгэн ням гаригийн хичээл дээр мэдэрсэн догдлолоо өвгөн ахин мэдэрлээ.

Тэгэхэд сургуулийн захирал түүнд хувийн номын сангаа ашиглахыг зөвшөөрдөг байсан агаад мань хүн нэн ялангуяа ням гаригт уг номын санд хэдэн цагаар сууж захирлын хайш яайш том том латин үсгээр тэмдэглэл хийсэн, мод ханхалсан номнуудын шарланги хуудсуудыг уншдаг байсан билээ. Нэгэн ням гаригт захирал нь номын санд орж ирснээ түүний уншиж байсан номны завсраас сугаран унасан хуудас цаасыг сандран шүүрч авсан ажээ. Антони Изабел захирлынхаа ийн догдлохыг үл мэдээчин царай гаргасан ч мөнөөх хуудсанд юу бичигдсэнийг уншиж амжсан хэрэг. Тэнд ягаан бэхээр гараар гаргацтай бичсэн ганц өгүүлбэр байв. Захирал түүний өмнө суугаад хэрхэн амьсгаа нь дээрдэн догдолж байсныг түүнээс хойш хагас зуун жил гаруйн хойно энэхүү хаягдан мартагдсан тосгоны дээгүүр элээ нисэлдэхийг хараад эргэн санаж буй нь энэ болов.

Ламтан уг дурсамжнаасаа болоод халууцах биш харин ч даарах шиг болон хөл нь мөсөнд хайруулсан мэт янгинахыг мэдрэв. Түүнд гэнэт аймшигтай санагдлаа. Гэхдээ үйрэн самуурсан бодол санаа, түүн дотор шулмасын хөл шаварт наалдах, аль эсвэл үхсэн шувууд тэнгэрээс унах явдал ийнхүү айх шалтаг болсон ч байж болох юм. Гэхдээ Гэгээн нууцын сүмийн ламтан шувууд үхэж буй явдлыг нэг их сайн мэдээгүй хэвээр байсныг хэлэх хэрэгтэй юм. Ламтан ийн байснаа хоосон агаарт замхран одооч хэн нэгнийг мэндчилэх мэт хоёр гараа наманчлан өргөж, Тэнүүлч жүүд! хэмээн хашгирсан бүлгээ.

Яг энэ үед галт тэрэгний дохио хадлаа. Ламтан энэ олон жилийн туршид анх удаа уг дохиог сонссонгүй. Харин галт тэрэг зогсоолд өтгөн угаа манаруулсаар зогсохоо зэвгэй тугалган дээвэр дээр үнс нурман бороо асгарахыг харлаа. Гэхдээ энэ нь нэн холын тайлагдашгүй нойрмог зүүд байсан бөгөөд ням гаригт хийх ёстой нэгэн ажилдаа үдээс хойно дөрвөн цагаас бэлтгэх хүртлээ энэхүү зүүднээсээ сэргж чадахгүй байсан хэрэг.

Санваартан үүнээс найман цагийн хойно нэгэн эмэгтэйг шунхдах шашны зан үйлийг удирдан хийх ажилд тохоогдов.

Харин энэ өглөөний галт тэргээр хэн ирснийг ламтан мэдсэнгүй. Тэр өнгөө алдан гандаж салбайсан сүүлийн дөрвөн вагоныг удтал мэлрэн ширтэхдээ сүүлийн хэдэн жилд ямар хүмүүс тосгонд бууж хоцорсоныг огтхон ч үл санана. Өмнө нь байдал өөр байсан билээ. Тэгэхэд тэр жимс ачсан нэг зуун дөрвөн вагон бүхий цувааг үдээс хойшжин ажиглаж, сүүлийн вагоны үйлчлэгч ногоон дэнлүүгээр дохисоор бүрэнхийд алслан одохыг харан суудаг байв. Үүнийг хойно тосгоноо харахад бүх гэрэл гэгээгээ асаасан байдаг байсан нь түүнийг өөр тосгонд аваачсан мэт санагддаг байлаа, тэр үед. Чухам ийм ч учраас мань хүн галт тэрэгний буудалд байнга очдог зуршилтай ч болсон байж магадгүй юм. Сүүлдээ хувьсгал үймээн гарч ногоочдыг буудаж алснаас гадил жимсний тариалан зогсож мөнөөх зуун дөрвөн вагон сураггүй болоод зөвхөн хүн тээдэг ганц шар вагон л үлдсэн түүхтэй юм.

Тэр өдөр бямба гариг байсан бөгөөд цорын ганц хүн тосгонд ирлээ. Гэгээн нууцын сүмийн эцэг ламтан Антони Изабелийг зогсоолоос явахад түүнийг сүүлчийн вагоны цонхоор харсан хүн бол ихэд өлссөн нэгэн хөвгүүн байсан агаад ламтныг хармагцаа бүтэн хоног юу ч идээгүй яваагаа санажээ. Санваартан байгаа газар зочид буудал байж л таарна гэж тэр шийдлээ.

Тэгээд галт тэрэгнээс бууж наймдугаар сарын төмөрлөг наран дор халцайн нооройсон гудамжийг гатлан зогсоолын эсрэг талд байрлах байшингийн сүүдэрт явж очлоо. Тэр байшингаас бягтруулын дуу гарах аж. Хоёр өдөр хэлэн дээрээ юм тавиагүй хөвгүүн уг байшинг зочид буудал гэдгийг үнэрээр нь андахгүй танилаа. Тэрбээр “Моканда зочид буудал” гэсэн хаягийг харалгүйгээр байшинд явж оров. Мань хүн хаягийг хараад ч бичиг үсэггүй тул уншиж чадах ч үгүй юм.

Буудлын эзэгтэй нь таван сартай жирэмсэн бүсгүй байх аж. Тэр эмэгтэй ээж нь өөрийг нь тээж байхдаа ямар байсан яг түүн лүгээ гич шиг шар ногоон болсон байлаа.

-Аль болох хурдхан шиг хоол өгнө үү гэж хөвгүүнийг хүсэхэд мөнөөх хүүхэн лазандуухан хөдөлсөөр хэрчсэн гадил, хоосон яс бүхий таваг шөл авчирч өгөв.

Энэ үеэр галт тэрэгний дохио хангиналаа. Шөлний сайхан үнэрт мансууран суусан хөвгүүн буудал хүртэлх зайг тооцоолон бодоод галт тэрэгнээс хоцруужин хэмээн тэвдлээ. Тэгээд үсрэн босоод үүдэнд очсон ч цааш явсангүй, учир нь галт тэргэнд сууж нэгэнт амжихгүй болсноо ухаарав. Хөвгүүн ширээнд эргэн суухдаа өлсч байгаагаа аль хэдийн мартсан байсан бөгөөд сүүлээ шарваж буй нохойных мэт аймтгай харцтай өрөвдмөөр охин бягтруулын дэргэд зогсож буйг үзэв.

Дараа нь тэрээр хоёр сарын өмнө эхийнхээ авч өгсөн малгайг авч өвдгөндөө хавчуулаад хоолоо идэж дуусгав. Хөвгүүн хоолоо идээд ширээнээс босохдоо галт тэрэгнээс хоцорч нэрийг нь ч мэдэхгүй /мэдэхийг ч хүсэхгүй/ энэ тосгонд бямба, ням гаригийг өнгөрүүлэх болсондоо санаа зовсон шинжгүй болсон байв. Түүнийг өрөөний булан дахь түшлэгтэй сандалд нуруугаа амраан, хөгжмийн дууг үл чагнан нүдээ анин удтал суусны дараа өөрийг нь сэмхэн ширтэж асан нөгөө охин:

-Довжоон дээр сэрүүн байгаа даа хэмээн хэлвэй.

Хөвгүүн өвчинд баригдсанаа байнга мэдэрч явдгаас хөндлөнгийн хүнтэй ярих хэцүү байдаг бөгөөд дуу хоолой нь бодож байснаас нь өөр аялгатай сонсогддог юмсанж.

-Тийм ээ хэмээн тэр хэллээ. Тэгснээ сандал дээрээ займчсанаа уг сандлыг дүүжин биш гэдгийг санав.

-Энд ирсэн хүмүүс довжоон дээр сэрүүхэн болохоор сандлаа тийш нь аваачдаг юм гэж охин хэлэв. Охины байдлыг ажвал түүнтэй ярилцахыг тун их хүсч буй нь илт. Охиныг бягтруул чангалах зуур хөвгүүн зориглон харвал тэр охин тэр газартаа хэдэн сар жилээр суусан мэт мөддөө ховхрох янзгүй байв. Охин хэдий бягтруулаа чангалж байсан ч хамаг анхаарлаа ярилцагч руугаа хандуулан инээмсэглэх аж.

-Баярлалаа хэмээн хөвгүүн өгүүлээд босохоор зэхлээ. Охин түүнийг ширтсээр, хүмүүс малгайгаа өлгүүрт өлгөдөг юм байна лээ гэж нэмж хэллээ.

Хөвгүүн энэ үгийг сонсоод эг маг болон гайхасхийж, галт тэрэгнээс хоцорсноо харамсан санав. Энэ үед буудлын эзэн хүүхэн орж ирээд, та нар юу л хийж байна даа хэмээн асуулаа.

-Тэр бусад хүмүүстэй адилхан сандлаа довжоо руу аваачих гэж байна гэж охин хэлэв. Охины дуунд тохуурхсан өнгө байх шиг хөвгүүнд санагдав.

-Санаа зоволтгүй. Би жижиг сандал дөхүүлж өгье хэмээн буудлын эзэн хэллээ.

Охин инээд алдахад хөвгүүнд таагүй боллоо. Тэр өдөр халуун бөгөөд хуурай байсан тул тэр халууцан хөлөрсөн байв. Буудлын эзэн савхин бүрээстэй явган сандлыг довжоо руу чирч гаргахад хөвгүүн тийш очюу гэтэл охин дахиад яриад эхлэв.

-Наадах чинь довжоон дээр очоод шувуунаас айх байх даа гэж тэр хэллээ. Хөвгүүн охин руу муухай хартал буудлын эзэн охин руу хяламхийж:

-Чи томоотой суувал яах ч үгүй гэлээ. Наад охин чинь юу гэчихэв ээ хэмээн хөвгүүний асуухад охин үгийг нь тосон авч:

-Яг өдийд л довжоон дээр үхсэн шувууд унадаг юм даа гэлээ.

-Наадах чинь зохиож байгаа юм хэмээн эзэн бүсгүй хэлээд өрөөний голд байх жижиг ширээн дээрх цэцгийн баглааг янзлахаар тонгойлоо. Бүсгүйн хуруу чичигнэх аж.

-Зохиосон юм биш. Та уржигдар хоёрыг өөрөө шүүрдэж хая гээ биз дээ хэмээн охин хариу зүтгэв. Буудлын эзэн ширэв татлаа. Гэвч охин бүгдийг тайлбарлахыг хүсч буй нь илт байлаа.

-Ноёнтоон! Яг юу болсон гэвэл уржигдар хэдэн банди нар наад хүнийг чинь айлгах гээд довжоон дээр хоёр үхсэн шувуу авчраад орхичихсон юм. Тэгсэн чинь хүмүүс тэднийг тэнгэрээс унасан гэж хэлсэн юм. Ер нь наадах чинь хэн юу ярина шууд л үнэмшдэг зантай юм л даа хэмээн тэр хөврүүллээ.

Хөвгүүн инээмсэглэлээ. Дээрх тайлбар түүнд хөгжилтэй санагдсан тул өөрийг нь буландан харж буй охины зүг харц чиглүүллээ. Бягтруул дуугарахаа болин зогсчээ.

Буудлын эзэн гарч одоход хөвгүүн хонгил чиглэн алхвал охин аяархнаар, яг үнэндээ шувууд тэнгэрээс унаж байхыг би нүдээрээ харсан юм. Надад итгээрэй. Олон хүн харсан шүү хэмээн хэлвэй.

Тийм ээ, би ч харсан хэмээн хөвгүүн үгийг нь дагуулаад гадагш гарлаа. Гадаа чавганы модны сүүдэр тусан байшин доторхоос сэрүүн байв. Мань хүн явган сандлыг хаалганд тулган тавиад гэдрэг налан сууж ээжийгээ дурсан саналаа. Ээж нь шүүрээр тахиа хөөж байхдаа гэнэт хүүгээ байхгүй гэдгийг санаад дүүжин сандал дээрээ ядарсан царайтай сууж байгаа байх даа хэмээн тэр бодов.

Тэр долоохон хоногийн өмнө өөрийнхөө амьдралыг ямар ч асуудалгүй, хэвийн хэмээн сэтгэж байсан бүлгээ. Харин зургадугаар сарын тэр өглөө хорин нэгэн насныхаа ойн өдөр сургуулийнхаа дөрвөн шавар ханан дунд байж байтал ээж нь түүнд, хайрт хүүдээ, төрсөн өдрөөр нь дурсгав гэж бичсэн ил захидал, малгай бэлэглэхэд энэ бодол нь гэнэт өөрчлөгдсөн ажгуу.

Түүнд энэ сургууль, ялааны баасанд шавуулсан дэлхийн газрын зураг, хананд өлгөөтэй самбар дээр нь сурагчдын нэр бүхий олон аяга тэргүүтэн уйтгартай санагдан сэтгэл нь гэгэлзэж эхэлсэн ажээ. Гэхдээ түүний амьдарч буй тэр газар халуун газар биш байсныг хэлэх хэрэгтэй. Тэр бол тайван, ногоонд умбасан тосгон байсан бөгөөд үнсэн саарал өнгөтэй цүүцгэр хөлт тахианууд угаагуур дор өндгөө дарахаар хичээлийн танхимд орж ирдэг байв.

Харин түүний эх гунигтай зожиг эмэгтэй байв. Тэр харуй бүрийгээр кофены тариалангийн үнэр нэвчсэн агаар амьсгалан байж, Мануар шиг сайхан тосгон дэлхийд өөр хаа ч байхгүй гэдэг байв. Тэгснээ дүүжин орон дээр хэвтэх хүү рүүгээ харан чи том болоод үүнийг ойлгоноо хэмээн хэлдэг ажгуу. Гэвч хөвгүүн юу ч ойлгоогүй билээ. Өвчинд баригдан зожигрон ганцаардсан тэрбээр бүр арван тав хүрч үеийнхнээсээ өндөр горзгор болсон хойноо ч юм ойлгосонгүй. Ер нь арван таван нас хүртэл түүний амьдралд дүүжин орон дээр хөрвөөхөөс өөр өөрчлөлт ороогүй билээ.

Тэр үед ууц, нурууны өвчтэй ээж нь арван найман жил багшилсан сургуулиасаа гарч асар том довжоо бүхий байшинд нүүн орсон бүлгээ. Тэд мөнөөх довжоон дээр хичээлийн танхимд орж ирдэг шиг үнсэн саарал хөлт тахианууд тэжээж эхэлсэн ажээ. Хөвгүүний хувьд ийн тахиа маллах нь амьдралдаа анх удаа бодит байдалтай тулгарсан хэрэг болов. Мөн энэ үеэр ээж нь тэтгэвэртээ гарахаар шийдэн уг асуудлыг хөөцөлдөхийг түүнд даатгасан бас нэг чухал үйл явдал болов.

Хүү бичиг цаас бүрдүүлэх ажилд сайтар оролцсоноор барахгүй ээжийнх нь тэтгэвэрт гарах нас арай болоогүй байсан тул сүмийн санваартан ламыг ятган иргэний үнэмлэхийнх нь хугацааг зургаан сараар сунгуулж чадлаа.

Тэрээр пүрэв гаригт ээжийнх нь багшлах эрдмийг харуулсан дэлгэрэнгүй зааварчилгаа аваад арван хоёр песо, солих хувцастайгаар тэтгэвэрт гарах гэдэг нь засгийн газраас түүнийг гар газар, хөл хөсөр байлгах гэж өгдөг тодорхой хэмжээний мөнгө юм байна гэсэн бүдүүн бараг ойлголттойгоор хотын зүг мордсон ажээ.

Тэр халуунд мансууран буудлын тагтан дээр зүүрмэглэж байхдаа өөрийнхөө нөхцөл байдлыг эргэцүүлж үзэв. Галт тэрэг ирэхээр түүнд сууж энэ аймаар халуун тосгоноос явж бүх юм сайн сайхан болно гэж тэр бодлоо. Хөвгүүн дөрвөн цагаас өмнөхөн тухгүйхэн байдалд унтахдаа дүүжин ороо авч явдаг байж хэмээн санав. Тэгж байснаа боодолтой хувцас болон тэтгэврийн баримт бичгүүдийг галт тэргэнд мартаж буусан гэдгээ гэнэт саналаа. Тэр сандран тэвдэж ээжийнхээ тухай сэтгэл түгшин бодлоо.

Түүнийг хоолны өрөө рүү сандлаа чирч ирэхэд тосгоны гэрэл ассан байлаа. Тэр цахилгаан чийдэн гэгчийг хэзээ ч хараагүй тул зочид буудлын бүүдгэр гэрлүүд маш сонирхолтой санагдлаа. Ээж нь цахилгаан чийдэнгийн тухай ярьж байсныг хөвгүүн эргэн санаж, толины өмнө шавааралдах хөх түрүүнүүдтэй дайтсаар сандлаа цааш чирэв.

Тэр нөхцөл байдал маш муугаар эргэснийг бодолхийлэн халуун, амьдралдаа анх тулгарсан ганцаардал хоёрт цохиулан хоолоо дуртай дургүй идлээ. Есөн цаг өнгөрч байхад сонингоор доторлосон унтлагын өрөөнд түүнийг аваачлаа.

Мань эрийг шөнө дунд зовиурт нойрондоо умбаж эхэлж байхад тэндээс таван гудамжны тэртээ Гэгээн нууцын сүмийн эцэг ламтан Антони Изабел ор руугаа хошуугаа шаан хэвтэж өглөө долоон цагт хийх ажлынхаа тухай эргэцүүлж байлаа.

Тэр арван хоёр цагаас өмнөхөн эмэгтэйчүүдийн шунхдах ёс үйлдэхээр гудамжинд гарсан ч тун их ядран, сэтгэл нь үймэрсэн тул дээр зан үйлд хэрэглэхээр зэхсэн зүйлсээ орныхоо хажууд тавиад ийн хэвтсээр даруй хэдэн цагийг өнгөрүүлжээ.

Ламтан үүрээр далайн эргийн шувуудын дуунаар сэрээд өрөөнийхөө хатуу хүйтэн шаланд толгойгоороо тулан жаал хэвтэхдээ бие болоод үйлдсэн нүгэл, насалсан насныхаа жинг мэдэрч байв.

Тэр тамд очих замаас зайлуулах учиртай ёслол хийдэг хүйтэн шалан дээр хацраа хайруулж хэвтэхдээ дахин босч чадахгүй нь хэмээн айж “бурхан минь” хэмээн бувгналаа. Санваартан өөр юу ч бодолгүй, тэр байтугай үхлийн ганц шад маань ч хэлэлгүй хэдий удаан хэвтсэнээ мэдсэнгүй. Хэдэн минут бараг л үхчих шиг болов.

Гэвч дахин ухаан орохдоо өвчин зовиур мэдэрсэнгүй. Тэр хаалган доогуур туяа татахыг харан алсад азарган тахиа гунигтай орилохыг сонсоод өөрийгөө амьд гэдгийг ойлгосноор барахгүй өглөө удирдан явуулах ёслол дээр хэлэх үгээ тодоос тод санасан ажгуу. Түүнийг хаалганыхаа түгжээг тайлахад үүр тэмдгэрч байлаа. Тагт руу харахул гурван үхсэн шувуу нэвсийн хэвтэж байв.

Шувууд ийнхүү бөөнөөр үхсэн нь хүмүүн бидний нүглээс болов хэмээн эцэг ламтан бодсоор үхсэн шувуудыг ширтэн есөн минут бодлогоширов.

Дараа нь хонгилын нөгөө үзүүр рүү очин гурван үхсэн шувууг авч устай гүцэнд хийлээ. Тэгэхдээ яах гэж ингэж буйгаа төдийлөн ойлгосонгүй. Сүүлийн үед болж буй үйл явдлууд амьдралын минь хамгийн аугаа их өдөр болох гэж буйг зөгнөж байгаа хэрэг хэмээн эцэг ламтан бодлоо.

Долоон цаг гэхэд халуу шатаж эхэллээ. Зочид буудлын цорын ганц үйлчлүүлэгч өглөөнийхөө цайг хүлээж байв. Бягтруултай охин хараахан босоогүй ажээ. Буудлын эзэн бүсгүй айсуу явааг харахад цүдгэр гэдсэн дотор нь долоон цагийн хонх дуугарч буй мэт санагдах аж.

-Чи галт тэрэгнээсээ хоцорчихсон юм байна шүү дээ хэмээн тэрбээр хожимдсон ч гэлээ харамссан өнгөөр хэлээд түүнд сүүтэй кофе, шарсан өндөг, ногоон гадилын зүсмэл авчирч өглөө.

Хөвгүүн идэхийг оролдсон ч чадсангүй. Халуу шатаж эхэлж буйд санаа зовнин хөлөрч, дотор нь бачимдаж байлаа. Тэр хувцастайгаа бүхлээрээ маш муу унтсан агаад ялимгүй халуунтай ч байв.

Том ногоон цэцгэн хээтэй палаажаар гоёсон буудлын эзэн аяга тавгаа хураахаар ирэхэд нь хөвгүүн түгшүүр зовлонгоо мэдрэн ээжийнхээ тухай саналаа. Мөн хүүхний хувцас өнөөдөр ням гариг гэдгийг сануулах ажээ.

-Нийтийн мөргөл болох уу? гэж тэр асуув.

-Тийм ээ, болно болно гэж бүсгүй хэлснээ гэхдээ хүн очдоггүй болохоор бараг болдоггүй юм. Шинэ лам ирүүлэхгүй байгаа юм гэж үргэлжлүүлээ.

-Одоо байгаа лам чинь яачихсан юм?

-Тэр бараг зуугаад настай хагас галзуу хүн л дээ.

Бүсгүй нэг гартаа таваг барьсан чигээр хөдөлгөөнгүй бодлогошрон зогсоод, тэр нэг өдөр номлолын индэр дээрээс шулмас харсан гэж ярьснаас хойш хэн ч мөргөлд очихоо больчихсон юм гэж өгүүлэв.

Хөвгүүн нэгд сэтгэл санаа нь үймэрсэн хоёрт гэвэл зуун настай хүнтэй уулзах нь сонин санагдсан тул сүм рүү явлаа. Хүн суудаг шинж тэмдэггүй, тугалган дээвэрт модон байшин, тоост гудамжнуудтай энэ суурин үхмэл харагдах аж.

Энэ бол зүлэг ногоогүй гудамж, цонх нь битүү хаалттай байшингууд, лүгхийм халуу шатсан тунгалаг тэнгэр бүхий Ням гаригийн тосгон байв. Хөвгүүн уг тосгонд гариг өдөр заасан ямар нэг бичээс алга даа хэмээн бодсоор тосгоны эл хуль гудамжаар алхаж явахдаа аль ч тосгоны ямар ч гудамж сүм юмуу оршуулгын газар руу хөтөлж аваачдаг хэмээн эхийнхээ ярьдгийг санав. Тийн явсаар цагаан баганан цамхаг бүхий салхинд элэгдэн гандсан жижиг байшинд тулж ирэв. Байшингийн оройд салхины чиг заагч байх агаад мөн тэнд байх цагийн зүү дөрвөн цаг арван минут дээр зогсчээ.

Тэрээр довжооны гурван гишгүүрийг дамжин сүмд орж очиход хүний хуучин хөлс, арц утлаганы үнэртэй холилдон ханхийх агаад сүм бараг хоосон байв.

Гэгээн нууцын сүмийн эцэг ламтан Антони Изабел дөнгөж индэртээ морилоод байв. Ламтан ёслолоо эхлэх гэж байхдаа нэгэн хөвгүүн малгайтай чигээрээ орж ирэн эзгүй сүмийг тунгалаг том нүдээрээ тойруулан харахыг анзаарлаа. Тэгээд хамгийн захын сандалд толгойгоо гилжийлгэн, гараа өвдгөндөө аван суулаа.

Ламтан хөвгүүнийг гаднын хүн гэдгийг харангуутаа мэдлээ. Яагаад гэвэл ламтан тосгонд гучин жил амьдарсны хувьд эндхийн хүмүүсийг бараг үнэрээр нь ялгаж чадах болсон билээ. Ноомой байрын тэр хөвгүүн уй гунигтай царайтай, уранхай ноорхой хувцастай нэгэн ажээ.

Энэ хүүхэд хувцастайгаа бүхлээрээ унтдаг болов уу хэмээн ламтан бодоход сэтгэлд нь жигшмээр ч юм шиг, өрөвдмөөр ч юм шиг мэдрэмж төрж байв.

Гэвч ламтан хөвгүүнийг сандал дээр суухыг хармагцаа сэтгэл зүрх нь хөөрөн догдолж, амьдралынхаа хамгийн чухал номлолоо тавих цаг ирснийг мэдэрлээ. Түүнийг энд үлдээж хайрлагтун гэж ламтан ертөнцийн эзэнд хандан залбираад номлолоо эхэлсэн авай.

Тэр эхэндээ юу хэлж байгаагаа ч мэдэлгүй ярьж эхэллээ. Тэр өөрийгөө сонсохгүй байсан ч зүрхнийх нь гүнээс намрын налгархан аялгуу урсан гарч байхыг мэдэрч байлаа. Харин үгс нь

ойлгомжтой, тод байж хүнд хүрч буй эсэхэд эргэлзэж байсан ажгуу.

Гэвч сэтгэл санаа нь агаархал хоосон маягаас ангид ертөнцийн эзний ариун сүнсний таалалд оршиж буй нь тодорхой байлаа.

Ребека унтлагынхаа өрөөнд байхдаа удахгүй халуу шатаж эхэлнэ хэмээн цухалдуухан байв. Хэрэв тэр тосгонд тохиолдоод буй энэ эвгүй явдлын сүүдэрт цохиулаагүйсэн бол элэнц эцгийнхээ мөрөөр жаал зугаа юмаа цүнхэлж аваад хаа ч хамаагүй яваад өгөх байсан сан. Гэвч тэр энэ л тосгонд урт урт хонгил, алсдаа өнгө бууруулагч шилээр сэлбэхээр төлөвлөөд буй хагархай цонхтой найман унтлагын өрөөтэй байшиндаа үхэх хувь заяатайгаа битүүхэндээ мэддэг байв. Тиймээс төрөлх тосгондоо үүрд үлдэн ” миний алдарт үеэл ” номоо туурвиж, залуу лам залж авчраад хамба хилэн цэцгээр чимсэн малгайгаа духдуулан сүмд очихоор хатуу шийдсэн аж.

Маргааш даваа гаригт мэндчилгээ бүхий захидлыг /Ийм захидал бичих нь хөнгөмсөг бөгөөд үл хүндэлсэн хэрэг гэж хурандаа Буэндиа хэлдэг байв/ хамба ламд заавал илгээе байз гэж Ребекаг бодож байтал Арженида үүдээр шагайж

-Авхайтан! Ламтан индэр дээрээ галзуурч орхисон гэнэ ээ хэмээн хашгирав. Эзэгтэй өнгө алдсан хорчгор нүүрээ түүн рүү хандуулан, тэр лав сүүлийн таван жил галзуураад байгаа биз дээ хэмээв.

Тэгээд хувцсаа үргэлжлүүлэн баглаж байхдаа тэр дахиад л шулмас харж л дээ хэмээв.

-Энэ удаа шулмас биш гэнэ ээ хэмээн Арженида өгүүллээ.

-Тэгээд юу харсан гэнэ вэ

-Тэр Тэнүүлч Жүүд харсан гэж ярьж байна гэнэ.

Тэртээ охин цагаасаа хойш сонсоогүй байсан тэр үгийг дуулсан бэлэвсэн эхнэрийн нуруу зарсхийгээд явчихлаа. Түүний тархинд хагархай салхивч, бүгчим халуун, үхсэн шувууд, залхаан цээрлүүлэлт бүгд чихцэлдэн чих нь шуугих шиг боллоо. Тэнүүлч Жүүд!

Царай нь барайж, нүд нь гөлийж орхисон Ребека өөрийг нь ам ангайн ширтэх Арженидаг чиглэн алхлаа.

Тэгээд гүнзгий амьсгаа авснаа, тийм ээ энэ үнэн, шувууд яагаад үхээд байгаагийн учрыг одоо л ойлголоо хэмээв. Уймарч бачимдсан эхнэр хар нэхмэл нөмрөгөө шүүрч аваад уртын урт хонгилыг гатлан, элдвийн гоёл чимэг бүхий том өрөөгөөр дамжин гудамжинд гарч, алсгүй орших Ариун нууцын сүмд хүрч очлоо.

Түүнийг очиход эцэг ламтан, би түүнийг харсан гэдгээ та бүхэнд тангараглаж байна. Би өнөө өглөө мужаан Жонасын эхнэрийг будах ёслолоос харьж явтал тэр замд минь тааралдсан. Түүний царай бурханы хараалд хорчийн харлаж, мөрөөр нь шатсан цучил үлдэж байсан гэдгийг тангараглая хэмээн ярьж байв.

Номлол нь агаарт замхран, гар нь чичирч, бүх бие нь сулран нуруугаар нь хүйт оргихыг ламтан мэдэрлээ. Тэр гэдэс нь мушгиж, ам нь цангахыг ойлголоо. Тэгээд бодит байдлыг ухаарахтайгаа болжээ.

Сүмд хүмүүс бужигналдан уй гашуудалт эмгэнэлт царай гаргасан Ребекка сүмийн дээвэр өөд гар сунган диваажинд мөргөж буйг ламтан үзлээ. Юу болоод байгааг тэр бүүр түүрхэн ухаарч, ид шид гэгч тохиолдож байгаа бололтой хэмээн шийдлээ. Тэгээд чичирч салганасан гараа индрийн модон ирмэгт тавиад яриагаа үргэлжлүүлсэн авай.

-Тэр над руу чиглэв хэмээн ламтан хэлэхдээ өөрийнхөө итгэлтэй дууг сонслоо.

-Нүд нь улаанаар эргэлдэж, үс гээг нь сэгсийсэн тэр амьтан над руу дөхөж ирэхэд түүнээс эм ямааны үнэр ханхалж байсан. Би ертөнцийн эзний нэрийн өмнөөс түүнийг зогсоохоор шийдэн гараа өргөөд, зогс, ням гаригт амьтнаар өргөл өргөдөггүй юм гэж хэлсэн юм.

Ламтныг ийн үгээ хэлж дуусгахад ид халуу шатаж байлаа. Энэ бол наймдугаар сарын хөшүүн бүтэж үхэм бүгчим халуун билээ. Гэвч эцэг ламтан тэр халууныг үл анзаарч байлаа. Тосгоныхон түүний номлолыг ахин сонсож эхэлсэнд тэр сэтгэл ханасангүй. Мөн хэдхэн хормын дараа сэнгэнэсэн дарсаар цангаагаа тайлна гэдэгт ч баярласангүй.

Түүнд нэг л тохигүй, зовиуртай байв. Тиймээс ч ёслолын энэ торгон мөчид анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байсан хэрэг. Тэгж тэгж амьдралдаа анх удаа өөрөөрөө бахархах гээчийг үзлээ. Ламтан индрийн шургуулгыг шалмаг түлхэн хаагаад Питагорос хэмээн дуудсан бүлгээ.

Эцэг ламтны загалмайлуулсан хүү сүмийн зарлага гялаан толгойт банди ламтанд дөхөж очлоо.

-Мөргөлчдийн өглөгийг цуглуул хэмээн Антони Изабел дуугарлаа.

Хүү эргэн тойрноо нүдээ анивчуулан жаал харснаа өглөгийн таваг хаана байгааг би мэдэхгүй шүү дээ гэлээ.

Энэ бол үнэн хэрэг байсан бөгөөд өглөг цуглуулах явдал хэдэн сар болоогүй аж.

-Арын өрөөнөөс том уут аваад чадахаараа цуглуул даа гэж ламтан хэллээ.

-Би хүмүүст юу гэх вэ хэмээн хөвгүүн лавлав.

-Тэнүүлч Жүүдийг хөөн зайлуулах гэж байгаа юм гэж хэлээрэй.

Ламтан ийн хэлснийхээ дараа ямар их ачаа үүрч буйгаа тов тодорхой ойлголоо.

Тэрээр сүмд лаа асаах, өөрийнхөө амьсгалах хоёрыг хэсэгхэн чагнаад гараа хүүгийн мөрөн дээр тавьлаа. Тэгээд “бүх мөнгийг цуглуулаад хамгийн эхэнд ирсэн байсан тэр хүүд ламтан өглөө гэж хэлээд өгөөрэй. Бас тэр хүүд шинэ малгай худалдаж ав гэж хэлээрэй” гэсэн ажгуу.

Монтиелийн бэлэвсэн эхнэр

Монтиелийг үхэхэд түүний эхнэрээс бусад нь баярласан бөгөөд тэд харин энэ явдалд итгэтлээ удсан ажгуу. Дэр, хөнжил хөглөрсөн бүгчим өрөөн дэх хулуу мэт бөөрөнхий булантай хүрэн авсны зэргэлдээ хэвтүүлсэн амьгүй цогцсыг харсаар байгаа мөртлөө эргэлзээд байсан олон хүн байсан хэрэг. Талийгаачийн сахал, үсийг сайтар хусаж маажиндсан цагаан шаахай өмсүүлсэн байсан агаад тэр мөчид амьдаас амьд мэт үзэгдэж байв. Авсны тагийг хааж хадаад хана дагуулан тавьсны хойно л золигийн Жойс Монтиел тоглоогүй үнэхээр л үхчихэж гэдэгт бүхэл тосгон сая л нэг юм итгэжээ.

Гэхдээ бэлэвсэн эхнэрээс бусад хүмүүс түүнийг ердийн жамаар талийсанд нэн гайхсаар хоцров. Түүнийг отоонд орж, араасаа буудуулан үхнэ хэмээн бүгдээрээ бодож байсан боловч ганцхан авааль эхнэр нь л эр нөхрөө өндөр насыг насалж, гэр орондоо өвчин зовлонгүй, гэгээн ламтан шиг нүглээ ариусгаад диваажинд морилно хэмээн хатуу итгэсээр ирсэн түүхтэй аж. Тэрхүү эхнэр ялимгүй л тооцоо алдсан байв. Жойс Монтиел 1952 оны наймдугаар сарын хоёрны үдээс хойш хоёр цагийн хирд гэртээ, дүүжин сандал дээр сууж байгаад эмчийн хориглосныг умартан хэт уурласнаас болж насан эцэслэсэн бүлгээ.

Оршуулганд олон хүн ирж, жижигхэн байшинд гашуудлын цэцэг багтахгүй болох нь гэж Монтиелийн эхнэрийн санаа зовж байсан нь талаар болжээ. Монтиелийг нас барсанд эмгэнэл илэрхийлж нэг намынх нь болон сүсэг нэгт цөөн нөхөд нь ирж мужийн захиргаанаас ганц цэцгэн титэм илгээжээ. Герман дахь консулын газар алба хашдаг хүү нь болон Парист суугаа хоёр охиноос нь тус бүр гурав гурван хуудас цахилгаан ирүүлэв. Тэдгээр цахилгааныг холбооны салбарын палигар хушуут үзгээр зогсоогоор бичсэн байх бөгөөд хорин долларын хураамжинд тэнцэх олон үг олж бичихийн тулд нилээд олон хуудас урж хаясан ажээ. Хүүхдүүдийнх нь хэн ч эргэж ирнэ гээгүй байлаа.

Тэр шөнө Монтиелийн жаран хоёртой бэлэвсэн эхнэр өөрт нь аз жаргал хайрласан тэр эрийнхээ авсанд дэрээ тулган уйлж хэвтэхдээ ганцаардлын гашууныг анхлан амсчээ. Ерөөсөө л хаалгаа үүрд түгжээд хэвтчихье. Намайг энэ авсанд түүнтэй минь хамт хийчихнэ биз. Бусад нь надад пад ч алга гэж тэр эхнэр бодож байлаа. Тэрбээр залуудаа цэвэр ариун сэтгэлтэй ч мухар сүсэгтэй нэгэн байсан агаад амьдралын бодит байдлыг насан туршдаа ойлгоогүй хүн билээ. Түүнд эцэг эхийнх нь ойртон танилцахыг зөвшөөрсөн цорын ганц эр хүн нь Монтиел байжээ.

Гурван өдрийн дараа эр нөхрийнх нь цогцсыг хөдөөлүүлсний хойно л өөрөө өөрийгөө агуулах боллоо гэдгийг бэлэвсэн эхнэр уйлж гиншсээр ойлголоо. Гэвч цоо шинэ байдалд хөл алдан төөрлөө. Тэр бүхнийг эхнээс нь эхлэх болжээ.

Жойс Монтиелийн булшиндаа авч орсон түмэн нууцын нэг нь төмөр авдрынх нь түгжээ байсан агаад тосгоны дарга энэ асуудлыг шийдэхээр шуударчээ. Төмөр авдрыг даргын тушаалаар довжоо руу чирч гаргасан хоёр цагдаа түгжээ рүү нь автоматаар галлаж гарав. Ийнхүү тосгоны даргын хашгирах, буу тачигнахыг үдээс өмнөжингөө сонсч хэвтсэн бэлэвсэн эхнэрийн толгойд түмэн таагүй бодол эргэлдэх аж.

-За яахав. Дайн дажин намжаах гэж тавын таван жил бурханд залбирсны минь хариуд орон

гэр рүү минь буудаж байх шив. Таарсан таар шуудайнууд хэмээн тэр орон дотроо зүхэж хэвтлээ. Бэлэвсэн эхнэр тэр өдөр хараал хийн бүгдийг тонилгохыг оролдсон ч хэнд ч хараал нь үйлчилсэнгүй. Түүнийг сүүлдээ ядраад зүүрмэглэх завсар асар хүчтэй нүргээн дэгдэж, байшин суурин хүртэл чичрэн доргилоо. Нөгөөдүүл төмөр авдрыг дэлбэлсэн нь тэр аж. Монтиелийн эхнэр хүндээр санаа алдвай.

Аравдугаар сард эцэс төгсгөлгүй бороо цутгаж бэлэвсэн эхнэр туйлын ганцаардаж Жойс Монтиелийн том байшинд сэлүүргүй завь мэт хөвж явлаа.

Тэдний гэр бүлийн үнэнч анд ноён Кармикал аж ахуйнх нь асуудлыг цэгцэлж эхлэв. Монтиелийн бэлэвсэн эхнэр нөхрөө үхсэн гэдэгтэй эцэстээ эвлэрэн унтлагын өрөөнөөсөө гарч гэрээ додомдохыг оролдлоо. Тэр байшин дахь гашуудлын туузнуудыг хаман авч хананд өлгөсөн талийгаачийн хөрөг дээр тохжээ.

Тэрбээр оршуулганаас хойш хоёр сарын дараа хумсаа мэрдэг зуршилтай боллоо. Нэгэн өдөр их уйлснаас бөлцийж улайсан нүдтэй бэлэвсэн эхнэр ноён Кармикал борооны шүхрээ дэлгээтэй чигээр орж ирэхийг хараатхав.

-Шүхрээ эвхээд орж ирж бай л даа ноён Кармикал. Таны энэ муу ёроос болж бидэнд ийм гай тохиолдлоо гэж тэр хэлсэн авай. Ноён Кармикал ч шүхрээ эвхэн буланд тавьлаа. Тэр хүн болбоос эвэр ургасан хөлийнхөө зовиурыг багасгахын тулд хутгаар зүсэн уужилсан гутал өшиглөж, цагаан хувцас өмссөн өндөр туранхай негр болой.

-Би шүхрээ хатаах гэж л ингэдэг юм л даа.

Бэлэвсэн эхнэр нөхрөө нас барснаас хойш анх удаа цонхоо нээлээ.

-Ийм их гай тохиолдоод байхад дээр нь энэ өвлийн байж байгааг. Ядаж яасан ч урт өвөл вэ дээ хэмээн бэлэвсэн эхнэр хумсаа мэрэнгээ бувгналаа.

-Өнөө маргаашгүй тэнгэр сайжирна ч гэж лав байхгүй дэг ээ. Яагаад гэвэл урьд шөнө миний хөлийн эвэр өвдөөд ер унтуулсангүй хэмээн өвгөн негр өгүүллээ. Бэлэвсэн эхнэр ноён Кармикалын хөлийн эвэр цаг агаарыг таадаг гэдэгт итгэдэг байв. Тэр эхэндээ Жойс Монтиелийн оршуулганд үзэгдээ ч үгүй олноос нүүр буруулан ганцаар байхыг оролдсон ч сүүлдээ сэтгэл нь хямран дордож, нөхрөөсөө өв болгон авсан учир начрыг нь хэзээ ч ойлгохгүй баахан үнэт цаасан дунд хумсаа мэрэн, хорвоогийн хатууг гайхан мэгшсээр өдрийг бардаг болжээ.

Энэ үеэр түүнийг эргэж тойрсон хүмүүс бэлэвсэн эхнэрийг галзуурчихаж гэж бодож байжээ. Гэвч түүний ой ухаан хэзээ хэзээнийхээсээ саруул байлаа.

Тэр нэгэн цагт улс төрийн хэлмэгдүүлэлт эхлэхээс өмнөх аравдугаар сард Монтиелийн эхнэр цонхныхоо өмнө сууж талийгаачдад залбирал үйлддэг байсан аж. Эр нөхөр нь хэзээ ч бүтэн үг хэлдэггүй зантай хүн байв.

-Хөөрхий минь! Өдөрт ганц нэг юм л там тум хэлдэг сэн гэж бэлэвсэн эхнэр дурсан ярих аж.

Авгай эхнэрээ диваажинд амар тайван залрах эрхтэй хэмээн боддог билээ.

Эцэстээ арга нь барагдсан Монтиелийн бэлэвсэн эхнэр хумсаа мэргэж эхэлснийг ноён Кармикал зогсоох гэж оролдлоо. Гэвч байдал сайжирсангүй. Харин ч айлган сүрдүүлэх замаар хавь орчны бизнесийг атгаж байсан Монтиелийн үхлийн дараа тосгоныхон хариугаа авч юу ч худалдан авахаа больсон тул сүү нь торхондоо гашилж, бал нь өмхийрөн, бяслаг нь өтөж байлаа. Ийнхүү Жойс Монтиел зургаан жилийн аллага таллагынхаа хариуг үхсэн хойноо үзэж буй юм. Бүхэл улсын түүхэнд хэн ч ийм богино хугацаанд түүн лүгээ хагартал баяжсан тохиолдол үгүй аж.

Цэргийн дарангуйлал тогтмогц анхны тосгоны дарга ирэхэд Жойс Монтиел будааны тээрэм дээр насныхаа хагасыг өнгөрөөсөн төлөв нэгэн байв. Түүнийг азтай бас үнэн сүсэгтэй хүн гэдэг байсан үе бий. Учир нь тэрээр сугалаа хожвол гэгээн Жозефийн том хөргийг худалдан авч сүмд хандивлахаа олны өмнө амласнаа хоёр долоо хоногийн хойно биелүүлсэн удаатай юм.

Харин сөрөг хүчнийг устган дарах тушаалтай цагдаагийн хэрцгий түрүүч тосгоны даргаар ирснээс хойш байдал тэс өөрөөр эргэв. Жойс Монтиел түүний баруун гар нь болоод авчээ. Ийн гэнэт тодорсон бизнесмен дайснуудаа баян, ядуугаар нь ердөө хоёр хувааж орхив. Цагдаагийнхан ядуусыг тосгоны төв талбай дээр буудан алж байхад харин баячуудад хорин дөрвөн цагийн дотор зайлан явахыг тулгав.

Жойс Монтиел тосгоны даргатай аллагынхаа төлөвлөгөөг боловсруулан бүгчим өрөөндөө өдөр шөнөгүй сууж байхад эхнэр нь үрэгдэгсдийн араас маани уншиж суудаг байв. Тосгоны даргыг гарсан хойгуур тэр нөхөртөө хандан энэ хүн бол алуурчин. Чи засгийн газарт хэлж энэ араатныг холдуулж үз хэмээн хэлдэг байв. Харин тэр үед тун завгүй болчихоод байсан Жойс Монтиел эхнэрээсээ харцаа буруулан байж битгий тэнэгтээд бай хэмээдэг ажгуу.

Үнэн хэрэгтээ тэр ядуусыг устгаад зогсохгүй, баячуудыг тонох ажилтай болсон байлаа. Тосгоны дарга баячуудын хаалгыг автоматаар шүршин хорин дөрвөн цагийн дотор явахыг тушаасны дараа Жойс Монтиел тэдний эдлэн газар, мал сүргийг өөрийн тогтоосон үнээр худалдан авч өөрийн болгож байв.

-Ийм тэнэг юм битгий хий. Тэд чамд сайн санахгүй дээ гэж эхнэрийгээ хажуугаас нь үглэхэд Жойс Монтиел түүнийг хажуу тийш нь түлхэж, хоол ундаа л хийж бай, харин надад бүү саад бол гэж уцаарладаг байв.

Ийнхүү аллагын жил хүрэхгүй хугацаанд Жойс Монтиел тосгоны хамгийн баян, хүчирхэг хүн болон хувирчээ. Тэр охидоо Парис руу илгээж, хүүгээ Герман дахь консулын газрын ажилтан болгоод эзэмшил газраа захиран суудаг болов. Гэвч тэрбээр буруу гарын баялгаа зургаан жил ч идэж чадалгүй үхсэн аж.

Түүнийг үхсэнээс хойш нэг жилийн дараагаас бэлэвсэн эхнэрийнд нь байшингийн шат шажигнуулан ирэх хүн болгон муу мэдээ авчрах болов. Тэд дандаа үдшийн бүрийгээр ирж, танай тийм юм алга болж, ийм юм байхгүй болж. Дахиад л хулгайч нар ирж, өчигдөр танай тавин тугалыг туугаад арилсан байна гэхчлэн мэдээлэх болов.

Ийм юм сонссон бэлэвсэн эхнэр дэмий л сандалдаа мэлрэн сууж хумсаа хэмлэх бүлгээ.

-Жойс Монтиел! Би энэ тосгоныхныг өөдгүй амьтад гэж чамд үргэлж хэлдэг байсан даа. Чамайг минь булшинд ороод хөрж ч амжаагүй байхад энэ тосгоныхон бидэнд тараа таниуллаа даа хэмээн тэр бувтнадаг байв.

Түүнээс хойш хэн ч тэднийхээр шагайгаагүй билээ. Өдөр шөнөгүй бороо цутгасан олон сарын туршид байшингийн босгыг алхсан ганц хүн нь шүхрээ хэзээ ч эвхдэггүй зантай ноён Кармикал байсан юм.

Байдал улам дордсоор байлаа. Ноён Кармикал Монтиелийн хүүд хэд хэдэн захидал бичлээ. Түүнчлэн мань эр энэ гэрийг толгойлоод аваад явдаг ч юм билүү гэсэн шүү юм бодож бэлэвсэн эхнэрийн эрүүл мэндийн байдлыг судлан шинжихийг ч оролдов. Харин Монтиелийн хүү хариу захидалдаа буцаж очихгүй гэдгээ тодорхой өгүүлсэн байв. Тосгонд очиж буудуулж үхэхээ болих минь гэж тэр шулуухан бичсэн ажгуу. Ноён Кармикал үүнийг уншаад бэлэвсэн эхнэрийн өрөөнд очин гэр орноо өөд татах хэрэгтэйг сэнхрүүлж гарав. Гэтэл бэлэвсэн эхнэр хариуд нь чи хүссэн бүгдээ аваад явж үз, би амар жимэр үхэх минь гэсэн бүлгээ.

Түүнээс хойш бэлэвсэн эхнэрийн хорвоотой харьцдаг ганц суваг нь охиддоо бичдэг захидал болов. “Энд их сайхан байна. Та нарыгаа азтай сайхан яваа болохоор би тун их жаргалтай байна” хэмээн тэр бичиж байлаа. Охид нь ч хариу бичиж байлаа. Захидлыг тохьтой дулаахан газар бичсэн нь илт агаад хоёр охин хоёулаа эргэн ирэхийг үл хүсч байлаа.

“Энэ бол соёлтой хөгжилтэй газар. Улс төрийн шалтгаанаар биесээ алдаг бүдүүлэг улсад очиж амьдрах арга даан ч алга” гэж тэд өгүүлжээ. Үүнийг уншсан ээж нь өгүүлбэр бүхнийг зөвшөөрөн толгой дохиж сэтгэл нь сэргэн суудаг байв.

Охид нь Парисийн махны дэлгүүрийн тухай, тэнд гахайн гулуузнуудыг урт хонгилын хананд ярайтал өлгөж дээр нь цэцгэн титэм зүүсэн байдаг тухай бичжээ. Захидлын эцэст охидынхоос нь өөр бичигтэй хэн нэг нь “Та төсөөл дөө. Тэр гахайнуудын бөгсөнд дэлхийн хамгийн гоё, хамгийн бүдүүн гадас шаалттай байдаг юм” хэмээн нэмсэн байв.

Монтиелийн бэлэвсэн эхнэр уг өгүүлбэрийг уншаад олон жилийн туршид анх удаа инээмсэглэжээ.

Тэгээд гэрлээ унтраалгүй чигээр унтлагынхаа өрөөнд орж хэвтэхийнхээ өмнө сэнс залгалаа. Мөн орны дэргэдэх шүүгээнээс хайч, самбай авч химлэсээр байгаад улайлган цоохортуулж орхисон баруун гарынхаа эрхий хурууг боолоо. Дараа нь залбирч эхэлсэн агаад боолттой баруун гар нь барьсан эрихийг нь мэдрэхгүй байсан тул эрихээ зүүн гартаа шилжүүллээ. Удалгүй бэлэвсэн эхнэр алсад аянга нүргэлэхийг сонсоод унтчих шиг боллоо.

Тэрбээр толгойгоо цээжиндээ наан гэлжийн хэвтэх бөгөөд эрих барьсан зүүн гар нь газар гулдайх аж.

Тэгтэл гартаа сам барьж хумсных нь хэлтэрхийнүүдийг атгасан цагаан өмсгөлтэй Их ээж

довжоон дээр үзэгдлээ.

-Би хэзээ үхэх вэ? гэж Монтиелийн бэлэвсэн эхнэр түүнээс асуулаа. Их ээж толгойгоо өргөөд, гар чинь хөшөөд эхлэхээр л үхнэдээ хэмээвэй.

Үхэл дурлалаас ч хүчтэй

Сенатын гишүүн Онесимо Санчес үхэхээсээ яг зургаан сар арван нэг хоногийн өмнө насан туршийнхаа мөрөөдөл болсон бүсгүйтэй учрав. “Амбан захирагчийн сарнайн бут” хэмээх сүржин нэртэй, шөнөдөө хулгайн тээврийн онгоц нуугдан зогсдог, өдөртөө хөвөөлсөн тэнгисийнхээ хуурай салхинд зүлгүүлэн хатмал цөлд бүүдийн навсайж байдаг тосгонд тэрээр түүнтэй учирсан хэрэг.

Ер нь бол энэ тосгонд амьдрагсдын хөөрхийлөлтэй тавиланг өөрчилнө гэдэг хэний ч санаанд багтамгүй бөгөөд нэр нь хүртэл даажигнал аж. Учир нь Онесимо Санчесийг Лаура Фаринатай уулзах үед дэргэд нь байсан тэрхүү цэцэг л энэ тосгонд анх үзэгдсэн цорын ганц сарнай байлаа.

Сенатын эрхэм гишүүний дөрвөн жил тутамд явуулдаг сонгуулийн компанийн үеэр энэ явдал болжээ.

Өглөөгүүр багт наадмын цуваа, сурталчилгаанд хамрагсдыг олон болгож харагдуулах үүрэгтэй хөлсний индианчууд ирсэн юм. Түүнчлэн бараа бологсдын хөсөг, дуу хөгжим, элдэв өнгийн галаар тургилах цаасан буу, сүмийн тэргүүний жимсний өнгөт чийчаан сэлт үд дундаас өмнө нэмэгдэв.

Онесимо Санчес сэрүүцүүлэх төхөөрөмжтэй машиндаа тааваараа байсан ч хаалга нээгдмэгц гал мэт агаарт төөнөгдөн цэвэр торгон цамц нь шөлөнд дүрчихсэн мэт болтол хөлөрч орхиод зуун жилээр хөгширсөн юм шиг санагдаж, хэзээ ч байгаагүйгээр ганцаардан байгаагаа мэдэрчээ.

Үнэндээ бол тэр дөчин хоёрхон настай, Готтингений их сургуулийг төмөрлөгийн инженер мэргэжлээр онцсайн төгссөн, тааруухан орчуулгатай латины суутнуудын номыг хэдий сүйдтэй ойлгодоггүй ч унших дуртай нэгэн байв. Мань хүн гоо төгөлдөр герман эмэгтэйтэй гэрлэж, таван хүүхэдтэй болсон бөгөөд эмч нар гурван сарын өмнө дараагийн зул сарын баярын үеэр нас барах тухай нь дуулгатал хорвоогийн хамгийн аз жаргалтай хүн байсан аж.

Цуглааны бэлтгэл хийгдэх зуур сенатын гишүүн өөрийнх нь амралтанд зориулан тохижуулсан байранд цаг орчим тухлав.

Тэр цөлийн урт замд үхүүлчихэлгүй авч ирсэн сарнайгаа услаад, үдээс хойшжин дайлуулах ёстой ямааны шарсан махнаас зайлсхийхийн тулд жаахан боов боорцог идэж, өвчин намдаагч эмнээсээ ахиухан ууж авав. Дараа нь цахилгаан сэнс залгаад сарнайн бутныхаа сүүдэрт дүүжин орон дээр нүцгэлэн хэвтсэн боловч унтаж байхдаа үхчих вий гэсэн айдаснаасаа болоод бүр үймэрч орхив. Эмч нараас өөр хэн ч түүнд тоотой хоног үлдсэнийг үл мэдэх бөгөөд хатуу чангадаа биш, харин ичиж нэрэлхсэндээ энэ тухай хэнд ч хэлэлгүй үйлээ тосохоор шийдсэн юм санж.

Тэр үдээс хойш гурван цагт сонгогчидтойгоо уулзахдаа цэмбэн шарваар, цэцгэн хээт цамцаар гоёж, өвчин намдаах эмний ачаар өнгө зүстэй гялалзаж, өөртөө тун ч итгэлтэй болсон байлаа. Гэвч үхлийн аймшиг бодсоноос нь хавьгүй хүчтэйгээ мэдрүүлснээс түүнтэй гар

барихаар зүтгэлдэх олныг жигшин зэвүүцэхийн сацуу уулзалт болж буй давсархаг нүүрсэн талбайд дороосоо төөнүүлэн халуунд шаналах хөл нүцгэн индианчуудыг өрөвдөх сэтгэл ч төрсөнгүй. Тэрээр олны уухайг гараараа бараг л ууртай гэмээр занган намдаагаад халуунд дүнсийх тэнгисийн зүг ширтэн элдэв дохио зангаа ч үгүй яриагаа эхлэв. Дуу хоолой нь жигд, тод, сонсголонтой боловч хэлж байгаа үгс нь үнэнээс хол хөндий, Марк Аврелийн “Бясалгал” номондоо бичсэн сургаалийн яг эсрэг чанартай ажээ.

Тэрээр “Бид бүхэн байгалийг ялан дийлэхийн тулд энд байгаа юм” хэмээн бүхий л итгэл үнэмшлийнхээ эсрэг үгээр яриагаа эхлээд “бид цаашдаа эх орондоо бутач хүүхэд мэт, өсөж төрсөн нутагтаа дүрвэгсэд мэт, энэ ангамал газарт бурханд шоовдорлогдсон өнчид мэт байхаа болих цаг ирлээ. Бид бүхнийг өөрчилнө. Хатагтай, ноёд оо! Бид жаргалант амьдралыг сүндэрлүүлэн цогцлоох болно” гэлээ.

Түүнийг үгээ хэлж байх зуур урьдаас төлөвлөсөн циркийн үзүүлбэрхүү зүйл явагдаж эхлэв. Туслахууд нь цаасан шувуу хөөргөж, тэдгээр хиймлүүд далайн зүг хийсэн нисэлдэх зуур бусад эрчүүд тэрэгнээс шон буулган хүмүүсийн ард давсархаг хөрсөнд зоож эхлэв. Улмаар мань эрчүүд гялалзсан цонхтой улаан тоосгон байшингуудын нүүрэн талыг дүрсэлсэн далбагар цаасан хавтангуудыг шонд бэхэлж ард нь нооройх жинхэнэ тосгоны хөөрхийлөлтэй дүрийг далдалж байв.

Сенатын гишүүн яриагаа улам чимэхийн тулд латинаар хоёр ч ишлэл хэлэв.

Тэр сонгогчиддоо бороо оруулдаг төхөөрөмж, мал амьтны зөөврийн тэжээгүүр болон шорвог хөрсөнд ч ногоо ургуулж, цонхон дор нь цэцэг ургуулах шидэт тос олж өгөхөөр амлаж байлаа. Энэ үеэр мөнөөх дээр өгүүлсэн хиймэл цаасан ертөнц бэлэн болсон тул сенатын гишүүн маань тэр зүгт занган “Харцгаа нөхөд минь! Бид ийм л орчинд амьдрах болно” гэж цоглог дуугаар хашгиран хэлээд, тийм ээ энэ бол бидний ирээдүй хэмээн нэмлээ.

Цугларсан олныг эргэж харахад цаасан байшингуудын ард босгосон хөлөг онгоцны зурмал тосгоны хамгийн өндөр байшингаас ч өндөр сүртэйеэ үзэгдэж байв. Харин нэг газраас нөгөөд зөөсөөр элэгдэж, хомхой цаг агаарт идэгдсэн тэрхүү цаасан хотхон “Амбан захирагчийн сарнайн бут” тосгоны бодит дүртэй бараг адилхан өнгө зүсээ алдан хорчийж орхисныг ганцхан сенатын гишүүн л анзаарчээ.

Нелсон Фарина арван хоёр жилийн дотор энэ удаа л сонгуулийн цуглаан, шоунд очсонгүй. Тэр их үдийн амралтаар байшингийнхаа сүүдэр дэх дүүжин орон дээрээ, анхныхаа эхнэрийг багалзуурдаж алаад мөчилж орхисон тэр л гараараа барьсан модон саравчин дор тухлан сенатын гишүүний уулзалтын чимээг сонсож байв.

Энэ эр урьд цагт Өмнөд Америкийн Гвиней дэх Чөтгөрийн арал хэмээх ялын газраас зугтаж, тоть шувууд болон Суринамийн нийслэл Фарамарибобоос олж авсан, Бурханд сүжиггүй гоо сайхан хар арьст бүсгүйн хамт усан онгоцонд чихэлдсээр энэхүү тосгоны барааг харсан хэрэг. Мөнөөх эмэгтэй Нельсон Фаринагаас нэг охин төрүүлээд ердийн жамаар өөд болсон агаад өөрийнх нь өнгөт байцааны талбайд мөчлөгдөн булагдсан хүмүүстэй адил бордоо болсонгүй, харин ч бүрэн бие цогцостойгоо, дани нэртэйгээ орон нутгийн оршуулгын газарт нойрсчээ.

Охин нь ээжийнхээ арьсны өнгө, бие хааг өвчиж харин аавынхаа дүрлэгэр шар нүдийг дуурайсан аж. Ийм ч учраас эцэг нь ертөнцийн хамгийн сайхан эмэгтэйг өсгөж өндийлгөж буй хэмээн дотроо боддог нь бүрэн үндэстэй ажгуу.

Нельсон Фарина сенатын гишүүн Онесимо Санчесийг сонгуулийн анхны компаниа эхэлж байх үеэс хойш л өөрийг нь хуулийн цээрлэлээс аврах учиртай хуурамч паспорт гуйж гувшсаар ирж. Гэвч сенатын гишүүн нөхөрсөг боловч шийдэмгийхэн татгалзсаар өнөөдрийг хүрчээ. Нельсон Фарина ч цөхөрсөнгүй, боломж олдох бүрт мөнөөх хүсэлтээ давтдаг байв. Харин өнөөдрийн тухайд дүүжин орон дотроо, далайн дээрэмчдийн үүр уурхай болсон энэ новшийн газар амьдаараа ялзрах болох нь гэж өөрийгөө зүхэж хэвтэв. Тэрээр хүмүүс сүүлчийн удаа алга ташихыг сонсоод хүзүүгээ өлийлгөн цаасан үлгэрийн ар яс мод, байшин барилгын нэвт гэрэлтэх хий дүрс, далайн хөлөг онгоцны зурмалыг түшин зогсогч этгээдийг олж үзээд дур гутан газар нулимав.

Нохойн баас! Муу хулхи улс төрчдийн нэг! гэж тэр хэлэв.

Сенатын гишүүн үг хэлснийхээ дараа заншил ёсоор хөгжмийн хангинаан, цаасан бууны тургиан дундуур өөрсдийнхөө зовлон бэрхшээлийг тоочих оршин суугчдаар хүрээлүүлэн тосгоны гудамжаар уруудав. Тэр хүмүүсийг ихэд анхааралтай мэт сонсож нэг ихийг амлалгүй шиг эвтэйхэн зөвлөгөө өгөөд салж чаддаг нэгэн байв.

Нэгэн эмэгтэй зургаан хүүхдийн хамт байшингийн дээвэр дээр зогсоод олны дуу шуугианаас даван чанга ярих нь сонсогдов.

-Би нэг их юм гуйхгүй ээ, сенатын гишүүн гуай гэж тэр хэлээд ус зөөх ганц илжиг л хүсч байна хэмээв.

Сенатын гишүүн зургаан хэрзгэр хүүхдийг нь анзаарч:

Нөхөр чинь юусан билээ хэмээвэл манай хүн Аруба арал руу алт олохоор явсан гэж эмэгтэй хоржоонтойхон дуугараад, тэгсэн чинь гадаад хүүхэнтэй нөхцөөд гарч өгсөн дөө гэлээ. Энэ үгэнд нь олон түмэн нэрхийтэл инээлдэв.

За яахав, та илжигтэй болно гэж сенатын гишүүн хэллээ. Тун удалгүй түүний туслахууд сенатын гишүүний бэлэг гэдгийг хэн ч мартагын аргагүйгээр сонгуулийн сурталчилгааны лоозонг ууцан дээр нь арилдаггүй бэхээр томоос том палийлгасан ногттой илжиг чирч авчирсан ажгуу.

Сенатын гишүүн цаашаа бас жаахан явж түүнийг харах гэж үүд рүүгээ ороо чирч ирсэн өвчтөнд эм халбагадаж хүртэл өгөв.

Тэр гудамжны буланд хүрээд Нельсон Фаринагийн баргар царайлан дүнсийн суугааг үзэж, сайн уу хөөе, сонин юу байна даа хэмээв.

За яахав дээ, дажгүй дээ гэж нөгөөх нь хариуллаа.

Энэ үеэр хүмүүсийн шуугианыг сонссон охин нь гарч ирлээ. Тэрбээр хямдхан палааж өмсөн үсээ өнгийн туузаар чимэглэж нүүрээ будсан нь баян тансаг биш ч эзнийх нь эгнэшгүй гоо сайхныг хараад хараад ханамгүй ажээ.

Сенатын гишүүний амьсгал бөглөрч, “Чөтгөр алгад! Бурхан ийм солиормоор амьтан бүтээдэг байх нь” гэж уулга алдлаа.

Тэр шөнө Нельсон Фарина охиндоо хамаг өнгөтэй өөдтэйг нь өмсүүлээд сенатын гишүүн рүү явуулав. Хурал болж байгаа байшингийн бүгчимд зүүрмэглэх хоёр харуул хонгилд байх ганц сандалд түүнийг суулгав.

Харин сенатын гишүүн маань зэргэлдээ өрөөнд тосгоны дарга нартай уулзан, олон түмэнд цухуйлгадаг ч үгүй, мань эр үг яриандаа дурьддаг ч үгүй бодит байдлын талаар сонсож суулаа. Тэр хүмүүс бусад газарт ч үргэлж тааралддаг улсуудтай ширхэг зөрөхөөргүй ав адилхан тул сенатын гишүүнд тун уйтгартай, ядаргаатай байлаа. Цамц нь хөлсөнд нэвчсэн тул тасалгааны голд адуу шиг уухилах цахилгаан сэнсэнд хатаахыг оролдож суув.

Тийм ээ. Бид цаасан шувуу идэхгүй нь мэдээж. Энэ ямааны өтөг бууцны оронд мод цэцэг сагсайж, усан дотор нь шоргоолж биш загас үрждэг болсон цагт л бидний ажил дуусна. Тийм биз дээ” хэмээн сенатын гишүүн айлдлаа.

Тэнд байгсдын хэн нь ч дуугарахгүй дүмбийн сууцгаах аж. Сенатын гишүүн ийн ярих зуураа хуанлийн хуудас таслан авч эрвээхэй хийгээд түүнийгээ ямар ч зорилгогүй шидэж орхисон нь сэнсний салхиар туугдан өрөөний хагас онгорхой хаалгаар гарч одов. Сенатын гишүүн үхлийн тухай бодлоо үргээж ядах зуураа “Тийм болохоор би та нарын сайн мэддэг юмыг давтаад яахав. Намайг дахин сонгогдвол та нарын л амьдрал дээшилнэ шүү дээ. Энэ цөлийн бохир усанд хордож, хөлс баасандаа хутгалдаж яваа минь эцсийн эцэст та нарт л ашигтай биз дээ” гэлээ.

Лаура Фарина цаасан эрвээхэй хийсэн гарч ирэхийг харлаа. Харин хоёр харуул буугаа түшин дугжирч байсан хэрэг. Эрвээхэй тэрүүхэндээ хоёр эргэлдээд хана мөргөн тэндээ наалдаж орхиход охин түүнийг хумсаараа ховхолж авах гээд барсангүй. Энэ үеэр өрөөнөөс дуулдах алга ташилтанд сэрсэн нэг харуул “наадах чинь ханын зураг шүү дээ” гэж нойрмоглоон дуугарав.

Хүмүүс өрөөнөөс гарч эхлэхэд Лаура Фарина эргэн суулаа. Сенатын гишүүн хаалганы түгжээг нэг гараараа тулан зогсож байгаад бүх хүмүүс явж өнгөрсөн хойно л түүнийг олж харав. “Чи энд юу хийж явдаг билээ?” гэж түүнийг асуухад “Аав намайг явууллаа” гэж Лаура Фарина хариуллаа.

Сенатын гишүүн бүгдийг ойлголоо. Тэрээр харуулууд руу нэг, охин руу нэг харах зуураа бүсгүйн гоо үзэсгэлэн үхлийг ч мартуулах хүчтэйг ухаарлаа. Мөн эрлэгийн элч сүүлчийн удаа ивээж байгаа нь энэ байх гэж шийдээд “За ор, ор” гэлээ.

Лаура Фарина босгон дээр тээнэгэлзэн зогслоо. Учир нь өрөөнд үй түмэн цаас бужигнан хийсч байх аж. Сенатын гишүүн сэнсийг салган “чи харж байгаа биз дээ” хэмээн инээвхийлээд “баас ч хийсч явж мэднэ” гэлээ. Лаура Фарина суулаа. Түүний арьс гөлгөр,

тунгалаг яг л жимс мэт, үс гээг нь залуу гүүний дэл мэт агаад торомгор нүд нь нар мэт гэрэлтэж байлаа.

Түүний харцанд сарнай цэцэг өртөхийг сенатын гишүүн анзаарав. Энэ бол сарнай” гэхэд нь охин, тийм байна, би Риохагийн усан боомтод харсан юм байна гэж охин хариуллаа.

Онесимо Санчес улмаар орон дээр сандайлан суугаад сарнайн тухай ярилцах зуураа цамцныхаа товчийг мулталж эхлэв. Тэр цээжнийхээ зүүн талд жаданд сүлбүүлсэн зүрх шивсэн агаад хөлсөнд нэвчсэн цамцаа шалан дээр чулуудаад охиноор гутлаа тайлуулахыг хүсэв.

Охин өвдгөөрөө бохирон тонгойж гутлынх нь үдээсийг тайлах зуур мань эр түүнийг анхааралтай гэгч нь ажиглан, энэ явдал хэнд нь аз, хэнд нь эз авчрах бол доо гэж бодож байлаа.

Чи ч бүр хүүхдээрээ юм аа гэж сенатын гишүүн хэлэхэд “Та ч итгэхгүй биз дээ. Би ирэх дөрөвдүгээр сард арван ес хүрнэ” гэж охин хариулав.

-Хэдэнд тэр билээ?

-Арван хоёрны өдөр

Сенатын гишүүний сэтгэл сэргэж, бид хоёр хоёулаа хонины ордных юм байна хэмээн инээмсэглээд ганцаардлын орд гэдэг юм даа гэлээ.

Лаура Фарина гуталтай ноцолдоод түүний яриаг нэг их анхаарсангүй.

Харин сенатын гишүүн түүнийг яахаа мэдэхгүй тээнэгэлзэж байв. Учир нь мань эр эхнэрээсээ өөр хүнтэй төдийлөн хавьтаж үзээгүй юм санж. Тэр ийн эргэлзэх зуураа Лаура Фаринаг өвдгөн завсраа хавчуулан бүсэлхийгээр нь тэврэн орон дээр гэдрэг харуулан хэвтүүлэхдээ дотуураа нүцгэн, биеэс нь ой хөвчийн үнэр сэнгэнэн, зүрх нь хүчтэй цохилж, хүйтэн хөлс нь цутгасныг анзаарав.

Лаура Фарина ямар нэгэн юм хэлэхийг хүссэн ч амьсгалахад ч төвөгтэй байсан тул дуугарсангүй хувь заяандаа бүгдийг даатгаж орхилоо.

Сенатын гишүүн түүнийг хажуугаар нь хэвтүүлээд гэрлээ унтраахад өрөөнд бүрэнхий болж сарнайн бут л бараантаж байв.

Мань хүн хэсэг зуур бүсгүйг энхрийлэн илж таалаад улмаар гараа явуулсаар салтаанд нь хүртэл хүйтэн төмөр баригдах нь тэр!

Энэ чинь одоо юу вэ? гэж сенатын гишүүн асуугаад цоожтой агтавч гэсэн хариу сонслоо.

“Чөтгөр ав, тэгээд түлхүүр нь хаа байгаа юм гэж хариулт нь дэндүү тодорхой зүйл асуулаа.

Охин, түлхүүр нь аавд байгаа, таныг туслах тухайгаа бичгээр баталгаа гаргаж өгвөл өгнө

гэсэн гэлээ.

Сенатын гишүүний уур хүрчээ. Муу мэлхий, баас гэж үглээд нүдээ анин бодлогоширохдоо Марк Аврелийн тэр нэгэн сургаалийг эргэн санав. Тэр сургаальд “Та ч бай өөр хэн нэгэн ч бай үхэх, тэр бүү хэл үхээд нэр чинь ч үлдэхгүй болох тэр цаг тун удахгүй ирнэ” гэсэн байдаг сан.

Сенатын гишүүн тайвширсныхаа дараа “Чи миний тухай юу сонссоноо хэлээч” гэхэд та үнэхээр жинхэнэ үнэнийг мэдмээр байна уу? гэж охин асуув.

Тийм ээ жинхэнэ үнэнийг.

За яахав гэж Лаура Фарина шийдэмгийхэн дуугараад хүмүүс таныг бусдаас долоон дор новш гэх юм билээ гэлээ.

Сенатын гишүүн энэ удаа цухалдсангүй. Тэрээр нүдээ анин удаан хэвтсэнийхээ дараа дахин нүдээ нээхдээ далдын далд зөн совингоо олж үзсэн мэт харагдаж байв.

Дараа нь “Ээ дээ тамын ч хорвоо юм даа, чи тэр жингэрийн үр аавдаа намайг тусална гэж байна гэж хэлээрэй” хэмээн дуугарлаа.

Та хүсвэл би өөрөө яваад түлхүүр аваад ирье хэмээн Лаура Фарина хэллээ.

Сенатын гишүүн түүнийг гэдрэг нь хэвтүүлээд “Түлхүүрийн талаар мартаад зүгээр л дэргэд минь унт. Ганцаардсан үед хэн нэгэн дэргэд байх хичнээн сайхан” гэлээ.

Охин сарнай цэцгийн бутнаас харцаа салгалгүйгээр түүний толгойг мөрөндөө татаж наалдууллаа.

Сенатын гишүүн түүний бэлхүүсээр тэвэрч нүүрээ биенд нь наалдуулаад ой хөвчийн зэрлэг согооных мэт үнэрт нь мансуурлаа.

Тэрээр энэ явдлаас зургаан сар арван нэг хоногийн хойно яг л ийм байдалтайгаар, Лаудра Фаринатай холбогдсоноос ихэд буурсан нэр төртэйгээ, хүүхнийг орхиод үхнэ гэдэгтээ гашуудан цурхиртал уйлсаар бие барсан билээ.